



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ  
БАЙРЛАХ “ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН БАЯНХӨНДИЙ  
АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ АШИГЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот

2026 он

## АГУУЛГА

ОРШИЛ .....	4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ .....	5
БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	9
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	9
Төслийн нэр:.....	9
“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төсөл.....	9
Төсөл хэрэгжүүлэгч:.....	9
1.2. Төслийн зорилго .....	10
1.3. Төслийн хүчин чадал, хэрэгжих хугацаа .....	10
1.4. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт .....	11
1.5. Уурхайн ажлын горим .....	11
1.6. Уурхайн ажилчдын хотхон.....	11
1.7. Ил уурхай .....	12
1.8. Хүдэр боловсруулах үйлдвэр .....	13
1.8.1. Үйлдвэрийн технологийн горим .....	14
1.8.2. Лаборатори .....	14
1.8.3. Химийн бодис .....	14
1.8.4. Химийн бодисын агуулах.....	15
1.8.5. Хаягдлын нэгдсэн сан .....	15
1.8.6. Машин механизмын засварын газар.....	16
1.8.7. Тэсэлгээний ажил, тэсрэх бодисын агуулах .....	16
1.9. Шатахуун түгээх станц .....	17
1.10. Цахилгаан хангамж.....	17
1.11. Бохир ус цэвэрлэх байгууламж.....	18
1.12. Уурхайн дулаан хангамж.....	19
1.13. Ус хангамж.....	19
1.14. Тээвэрлэлт.....	20
1.14.1. Дотоод зам.....	20
1.14.2. Агаарын харилцаа .....	21
1.15. Холбоо харилцаа.....	21
1.16. Хүний нөөцийн бодлого .....	22
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	23
2.1. Физик газарзүй .....	23

2.2.	Уур амьсгал .....	23
2.3.	Гадаргын ус .....	23
2.4.	Газрын доорх ус .....	23
2.5.	Хөрсөн бүрхэвч .....	24
2.6.	Ургамлан нөмрөг .....	24
2.7.	Амьтны аймаг .....	24
2.8.	Нийгэм - Эдийн засаг .....	25
<b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ҮНДСЭН БОЛОН БОЛЗОШГУЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....</b>		<b>26</b>
<b>БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ .....</b>		<b>29</b>
4.1.	Зорилго, зорилт .....	29
4.1.1.	Баримтлах зарчим .....	29
4.1.2.	Хамрах хүрээ .....	29
4.2.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй .....	30
4.3.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	31
4.4.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	45
Модны усалгааг дэмжих хувинг туршилтаар хэрэглэх .....		47
4.5.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	48
4.5.1.	Дүйцүүлэн хамгааллын талаар баримтлах бодлого .....	48
4.6.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .....	51
4.7.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	51
4.8.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	51
4.9.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	52
4.10.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	58
4.11.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	63
4.12.	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ .....	68
4.13.	БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	68
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....</b>		<b>70</b>
<b>Хавсралтын жагсаалт .....</b>		<b>71</b>

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Дагаж мөрдөх хууль.....	5
Хүснэгт 2. Дагаж мөрдөх стандартууд.....	5
Хүснэгт 3. Дагаж мөрдөх дүрэм, журам.....	7
Хүснэгт 4. Хөндий (MV-021444) талбайн булангийн цэгүүд.....	10
Хүснэгт 5. Уурхайн ашиглалтын тоног төхөөрөмж.....	12
Хүснэгт 6. Уурхайн ашиглалтын технологийн схем.....	12
Хүснэгт 7. Хэрэглэх химийн бодис, тн.....	15
Хүснэгт 8. Ус хангамжийн эх үүсвэр.....	19
Хүснэгт 8. Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	26
Хүснэгт 10. БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2026 он.....	30
Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	32
Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	46
Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	49
Хүснэгт 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	51
Хүснэгт 15. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	51
Хүснэгт 16. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	52
Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	54
Хүснэгт 18. Хог хаягдлын ангилал, тэдгээрийг устгах аргууд.....	58
Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	60
Хүснэгт 20. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	64
Хүснэгт 21. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	68
Хүснэгт 22. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	69

## ЗУРАГ

Зураг 1. Хөндий талбайн байршил.....	9
Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал.....	11
Зураг 3. Уурхайн хотхон.....	12
Зураг 4. Боловсруулах үйлдвэр.....	13
Зураг 5. Хүдэр боловсруулах үйлдвэрийн технологийн ерөнхий схем.....	14
Зураг 6. Хаягдлын нэгдсэн сан.....	16
Зураг 7. Тэсрэх бодисын агуулах.....	17
Зураг 8. Баянхөндий-Нарийнсухайт 110 кВ-ын ЦДАШ.....	18
Зураг 9. Бохир ус цэвэрлэх байгууламж.....	18
Зураг 10. Уурхайн бүсийн уурын зуух.....	19
Зураг 11. Ус хангамжийн системийн схем.....	20
Зураг 12. Төслийн дотоод замын трасс болон хөндлөн огтлол.....	21

## ОРШИЛ

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутаг дэвсгэрт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Хөндий нэртэй талбайд “Баянхөндий алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах” төслийг хэрэгжүүлэхээр олборлолт, үйлдвэрлэлийг цогцоор бүтээн байгуулах ажлыг гүйцэтгэж байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахын тулд байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн туршлага, менежментийг нэвтрүүлж олон нийтэд нээлттэй, хариуцлагатай уул уурхайн жишиг төсөл болох зорилго тавин ажиллаж байна.

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д зааснаар боловсруулсан

Эко трейд ХХК-ний 2021 онд боловсруулсан Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөлтэй алтны үндсэн ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд (2021-2025) тусгагдсан байгаль хамгаалах арга хэмжээний заалтуудаас 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулан энэ оны БОМТ-г боловсруулав.

Баянхөндий төслийн үйл ажиллагаанд коронавирусын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, хил гаалийн хүндрэл бэрхшээл, нөгөө талаас зарим төрийн бус байгууллага, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, тэдгээрийг мэдээллээр хангах зэрэг олон хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж, төсөл хөгжүүлэлтийн үе шатанд өөрчлөлт орсноор барилга угсралтын ажил 2023 оны 07 сард эхэлсэн.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК нь үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын холбогдох хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрхзүйн актуудын нийцлийг ханган, төслийн зүгээс үзүүлэх аливаа нөлөөллийг стандартын шаардлагад нийцүүлэх, боломжит хамгийн бага түвшинд байлгахыг зорьдог.

Төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд дагаж мөрддөг хууль, үндэсний стандарт, эрхзүйн актуудыг 3- д харуулав.

### Хүснэгт 1. Дагаж мөрдөх хууль

Д/д	Байгаль орчинтой холбоотой хууль, журмууд	Анх батлагдсан огноо	Шинэчлэн батлагдсан огноо
1.	Агаарын тухай хууль	2006.07.08	2023.01.06
2.	Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хууль	2010.06.24	2019.11.13
3.	Ашигт малтмалын тухай хууль	2006.07.08	2023.01.06
4.	Амьтны тухай хууль	2000.05.05	2023.01.06
5.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995.03.30	2023.01.06
6.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	2012.05.17	2023.01.06
7.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль	2012.05.17	2023.01.01
8.	Байгалийн ургамлын тухай хууль	1995.04.11	2024.06.05
9.	Газрын тухай хууль	2002.06.07	2023.01.06
10.	Гамшгаас хамгаалах тухай хууль	2017.02.02	2023.01.06
11.	Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газарт ашигт малтмал олборлох, хайхыг хориглох тухай хууль	2009.07.16	2015.12.04
12.	Ойн тухай хууль	2012.05.17	2023.07.07
13.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	2008.05.22	2023.07.07
14.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	2012.05.17	2023.01.01
15.	Хог хаягдлын тухай	2017.05.12	2023.01.01
16.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	1994.11.15	2023.01.06
17.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	2014.01.09	2024.01.02
18.	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль	2006.05.25	2024.06.05
19.	Усны тухай хууль	2004.04.22	2023.01.06
20.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	2012.05.17	2022.06.03
21.	Соёлын тухай хууль	1988.11.19	2023.01.06
22.	Соёлын өвийг хамгаалах тухай хууль	2001.06.08	2023.01.06

### Хүснэгт 2. Дагаж мөрдөх стандартууд

Д/д	Стандартын дугаар	Стандартын нэр
<b>Хөрс, ургамал</b>		
1.	MNS 3985:1987	Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл.
2.	MNS 5850:2019	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

3.	MNS 3475:2003	Ургамлын хорио цээр. Нэр томьёо, тодорхойлолт.
4.	MNS 3298:1991	Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага.
<b>Ус</b>		
5.	ISO MNS 24511:2012	Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ. Ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшнийг үнэлэх аргачлал. үнэлэх заавар
6.	MNS 4943:2015	Усны чанар, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
7.	MNS 4586:1998	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.
8.	MNS 3597:1983	БО-ны хамгаалал, Усан мандал. Гадаргын ба газрын доорх усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага
9.	MNS 3342:1982	БО-ны хамгаалал, Усан мандал. Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
10.	MNS 6148:2010	Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
11.	MNS 0900:2018	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
12.	MNS 3935:1986	Ахуйн хэрэгцээ, ундны зориулалттай ус. Хээрийн шинжилгээний аргад тавих ерөнхий шаардлага.
<b>Агаарын чанар</b>		
13.	MNS 4585:2016	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
14.	MNS 5885:2008	Агаарт байх бохирдуулагч бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага.
15.	MNS 3383:1982	Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо, тодорхойлолт.
<b>Нөхөн сэргээлт</b>		
16.	MNS 5914:2008	БО. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
17.	MNS 5915:2008	БО. Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал.
18.	MNS 5916:2008	БО. Үржил шимт хөрсийг хуулах шаардлага.
19.	MNS 5917:2008	БО. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
20.	MNS 5918:2023	БО. Эвдэрсэн газрыг дахин ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
21.	MNS 4943:2015	Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага

**Хүснэгт 3. Дагаж мөрдөх дүрэм, журам**

Д/д	Журам	Тайлбар
1.	“Засгийн газарт чиглэл өгөх тухай” <i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг</i>	Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г чиглэл болгосугай.
2.	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” <i>Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол</i>	"ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ 33. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд мод тарих, ургуулах, арчлах үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх.
3.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам. <i>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-03 тоот тушаал</i>	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
4.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам. <i>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаал</i>	өсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн (цаашид төсөл хэрэгжүүлэгч гэх) байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
5.	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам. <i>Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоол</i>	Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (цаашид "газрын хянан баталгаа" гэх) хийхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.
6.	Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам. <i>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 тоот тушаалын хавсралтаар батлагдсан.</i>	Энэхүү журмыг ус олборлох, дамжуулах, нөөцлөх, борлуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа ус хангагч, усны тоолуурын хэмжил зүйн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болон ус ашиглагч, хэрэглэгч дагаж мөрдөнө. Унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын усны олборлолт, дамжуулалт, нөөцлөлт, борлуулалт, хаягдал усны тоо хэмжээг тогтоох ба ашиглалтын тайлан мэдээг гаргах ажилд эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан усны тоолуурын заалтыг үндэслэнэ.
7.	Байгаль орчинд халгүй, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуй нэгж байгууллагыг урамшуулах журам. <i>Засгийн газрын 2017 оны 290 тоот тогтоол</i>	Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой, аюултай нөлөөллийг багасгах дэвшилтэт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж урамшуулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
8.	Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн	Энэхүү журмын зорилго нь хог хаягдлын менежментийн мэдээллийг бүрдүүлэх, мэдээллээр хангах хог хаягдлын

	<p>тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам. <i>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/428 тушаал</i></p>	<p>улсын мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн сан” гэх)-ийн тогтолцоотой холбоотой харилцааг зохицуулахад оршино.</p>
9.	<p>Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам <i>Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал</i></p>	<p>Энэхүү журмын зорилго нь “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 заалтын дагуу химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах харилцааг зохицуулахад оршино.</p>
10.	<p>Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам <i>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/87 тоот тушаал</i></p>	<p>Уул уурхайн олборлолт, баяжуулалт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, бүртгэх, тайлагнах үйл ажиллагаа болон тэдгээр үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд энэхүү журмын зорилго оршино.</p>
11.	<p>Аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналт шалгалтын журам. <i>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан.</i></p>	<p>Аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү нийтлэг журам болон Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.</p>
12.	<p>Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам <i>Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаал</i></p>	<p>Тус журмын 2.2-т Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь үүсгэж буй барилгын хог хаягдлаа эх үүсвэр дээр нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх шинж чанараар тодорхойлж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дүгээр тушаалаар батлагдсан Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн “аюултай”, “хяналттай”, “энгийн” зэрэглэлд хамрагдсанаар нь ангилан ялгана.</p>

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА


### 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Торонто, Монголын хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци” (тэмдэг: ERD) “Эрдэнэ Монгол” ХХК-ийг 2002 онд үүсгэн байгуулж, Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор Хонг Конгийн Хөрөнгийн Бирж (тэмдэг: 975)-д бүртгэлтэй “Монголиан Майнинг Корпорэйшн (ММС)”-тэй стратегийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээг 2024 оны 01 сарын 23-ны өдөр эцэслэн байгуулснаар Эрдэнэ Монгол ХХК-ийг тавь тавин хувийн хөрөнгө оруулалттайгаар эзэмших болсон.

**Төслийн нэр:** “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төсөл  
**Төсөл хэрэгжүүлэгч:** Гадаадын хөрөнгө оруулалттай “Эрдэнэ Монгол” ХХК  
 Улсын бүртгэлийн дугар: 9019005124  
 Регистрийн дугаар: 2718243

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД 8-р хороо, Сентрал таур, 16 давхар  
 Утас: +976 77118534

**Төслийн нэр, байршил:** “Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшдэг MV-021444 дугаартай “Хөндий” ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутагт байрладаг. “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн талбай нь Улаанбаатар хотоос 980 км, Баянхонгор аймгийн төв Баянхонгор хотоос баруун урагш 340 км, Шинэжинст сумын төвөөс баруун урагш 100 орчим км зайтай.



**Зураг 1. Хөндий талбайн байршил**

Ашигт малтмалын газрын ГУУКХ-ийн даргын шийдвэрээр “Эрдэнэ Монгол” ХХК-д Хөндий нэртэй XV-015569 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 19936.34 га талбайг 2010 онд олгож, хайгуулын ажлын явцад “Эрдэнэ Монгол” ХХК-ийн хүсэлтээр 2014 онд 15422.01 га талбайг буцаан, 4514.33 га талбайд хайгуулын ажлыг үргэлжлүүлэн, 2308.62 га талбайд ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон ба үлдсэн 2205.71 га талбайг буцаан өгсөн.

Хөндий талбайд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнг 2019 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж нөөцийг батлуулсан бөгөөд “Эрдэнэ Монгол” ХХК-д АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр 2019 оны 08 дугаар сарын 05-нд ашигт малтмал ашиглах MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий 2308.62 га талбайг 30 жилийн хугацаатай олгосон.

#### Хүснэгт 4. Хөндий (MV-021444) талбайн булангийн цэгүүд

Тусгай зөвшөөрөл	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
MV-021444 (2,308.62га)	2019-08-05	30	1	98° 48' 40"	43° 53' 50"
			2	98° 47' 18.81"	43° 53' 50"
			3	98° 46' 33.93"	43° 57' 36.11"
			4	98° 50' 0.34"	43° 57' 36.11"
			5	98° 50' 0.34"	43° 55' 30"
			6	98° 48' 40"	43° 55' 30"

### 1.2. Төслийн зорилго

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хөндий эрдсийн дүүргийн алтны үндсэн ордуудыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан эрхзүйн актуудыг мөрдлөг болгож, үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэн, эдийн засгийн үр ашигтайгаар байгалийн баялгийг зохистой ашиглах дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, компанийн ажилтнууд болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч, оролцогч талуудад хүртээхэд төслийн зорилго оршино.

### 1.3. Төслийн хүчин чадал, хэрэгжих хугацаа

Хөндий талбайд хүдэр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, ордын уул техникийн нөхцөл, ордын геологийн тогтоц, уурхайн ашиглалтын жилүүдэд уулын цул олборлолтын хэмжээг жигд байлгах зэргээс хамаарч ил ордыг ил аргаар ашиглах 7 жилийн хугацаанд 74.12 сая.тн уулын цул үүнээс 14.90 сая.тн хүдэр олборлож, 59.22 сая.тн хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 3.97 тн/тн байна. Барилгын материалын ордуудыг ашиглах ил уурхайн төлөвлөлтийг төслийн бүтээн байгуулалтын ажлын нийт хэрэгцээ шаардлагад нийцүүлэх байдлаар төлөвлөлтийг гүйцэтгэсэн болно. Ил уурхайн ашиглалтын хугацаанд нийт 450.90 мян.м<sup>3</sup> уулын цул үүнээс 266.65 мян.м<sup>3</sup> барилгын материал олборлож, 184.25 мян.м<sup>3</sup> хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.69 м<sup>3</sup>/м<sup>3</sup> байна.

Хүдэр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал 650.0 мян.тн/жил ба төслийн хэрэгжих 10 жилийн хугацаанд 3.11 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.51 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 5,719.76 мян.тн хүдэр үүнээс эхний жил 3.80 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.37 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 300.0 мян.тн хүдэр, 2-4 дэх жилд 4.00 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.51-1.90 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,950.0 мян.тн хүдэр, 5-7

дахь жилд 3.10 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.32-1.90 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,950.0 мян.тн хүдэр, 8-10 дахь жилд 1.84-1.85 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.08-1.10



гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,519.76 мян.тн хүдрийг тус тус тэжээхээр төлөвлөсөн.

## **Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал**

### **1.4. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт**

Баянхөндий, Хар морь алтны үндсэн ордуудыг ашиглаж эхлэхийн өмнө боловсруулах үйлдвэр, уурхайн ажилчдын хотхон, засварын газар, дэд бүтцийн дагалдах барилга байгууламжууд баригдана. Дээрх объектууд нэгдсэн цогцолбор байдлаар баригдснаар олборлолтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ. Олборлолтын үе шатанд ил уурхай, гадаад овоолгууд үүснэ.

### **1.5. Уурхайн ажлын горим**

Уурхайн үйл ажиллагаа нь жилд 350 хоног ажиллаж, 15 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар ТЭЗҮ-д тусгагдсан. Хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 11 цаг байна. Төслийн барилга угсралтын ажил 2023 оны 7 дугаар сараас эхэлж, нийт 18 барилга байгууламжийг барьж байнгын ашиглалтад хүлээж авах улсын комисст хүлээлгэн өгсөн. Уурхайн хөрс хуулалтын ажил 2025 оны 5 дугаар сарын 07-нд эхэлсэн.

### **1.6. Уурхайн ажилчдын хотхон**

Уурхайн ажилчдын хотхоныг ордоос хойш 8 км зайд байгуулсан. Гал тогоо, хоолны заал, спорт заал, лобби танхим, фитнесс өрөө, интернет кафе, амрах өрөөнүүд, агуулах, угаалгын газар, автогараж зэрэг уурхайн ажиллагсдын амьдрах тав тухтай орчинг бүрдүүлсэн 370 хүртэлх хүнийг хүлээн авах хүчин чадалтай орчин үеийн байгууламжийг барьж, 2025 оны 5 дугаар сарын 08-нд барилгыг байнгын ашиглалтад хүлээж авах улсын комиссын гишүүдийн саналаар “ашиглалтад хүлээж авсан”. Уурхайн нэгдсэн оффис ажиллагсдын стресс тайлах өрөө, хоолны танхим, яаралтай тусламжийн тоноглол бүхий өрөөтэй ба яаралтай тусламжийн эмч 24 цаг бэлэн байдал хангаж ажиллаж байна.



**Зураг 3. Уурхайн хотхон**

### 1.7. Ил уурхай

Ил уурхайн загварчлалаар Баянхөндий орд 352-585 метрийн өргөн, 848.0 метрийн урт, 142-161 метрийн гүнтэй, 40-45 градусын налуутай, 37.3 га талбайг хамаарсан, Хар морь орд 98-170 метрийн өргөн, 368 метрийн урт, 33-55 метрийн гүнтэй, 40-45 градусын налуутай, 4.7 га талбайг хамаарсан уурхай үүснэ.

Ордын уул геологийн нөхцөл, хүдрийн биетийн хэлбэр ба байршил, хөрсний зузаан зэрэгт үндэслэсэн ба хүдрийн биет нь босоо уналтай, хэвтээ зузаан дунджаар 80 метр, газрын гадаргууд хүдрийн биетийн гарштай тул Баянхөндий болон Хар морь алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан. Ил уурхайгаас 2026 онд уулын цулаар 4.98 сая.м3 уулын ажил хийгдэнэ. Үүнээс 3.98 сая.м3 хөрс хуулалт, 370.4 мян.м3 буюу 978.0 мян.тн үйлдвэр тэжээх хүдэр олборлолтын ажил хийгдэнэ

Олборлолтын үйл ажиллагаанд дараах тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан.

#### Хүснэгт 5. Уурхайн ашиглалтын тоног төхөөрөмж

Д/д	Марк	Төрөл	Загвар	Хүчин чадал Багтаамж		Тоо ширхэг
				Нэгж	Хэмжээ	
1	HYUNDAI	Эксковатор	R1250-9	М3	6.7	1
2	HYUNDAI	Эксковатор	HX520	М3	3.2	1
3	Бусад	Автосамосвал	TL875K	тн	60	2
4	SHANTUI	Бульдозер	DH46-C3	М3	13.7	2
5	XCMG	Грейдер	GR3005Tpro	М3	4.6	1
6	HYUNDAI	Утгуурт ачигч	HL780-9s XTD	М3	5.2	2

#### Хүснэгт 6. Уурхайн ашиглалтын технологийн схем

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
	Хөрс хуулалт	Өрөмдлөг, тэсэлгээ Ухаж ачих

Автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын технологи		Тээвэрлэх Овоолох
	Хүдэр олборлолт	Өрөмдлөг, тэсэлгээ Ухаж ачих Тээвэрлэх Овоолох (хураах)

Барилгын материал боловсруулах үйлдвэр барихгүй бөгөөд шууд уурхайлан олборлож дүүргэлтийн материалаар хэрэглэнэ, ТТАМ-ыг боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж байхгүй. Мөн 2026 онд нөөцийг борлуулахгүй, зөвхөн дотооддоо 125.0 мян.м<sup>3</sup> дайрга, 75.0 мян.м<sup>3</sup> шавар ашиглах тул ТТАМ-аас олох борлуулалтын орлогогүй болно. ТТАМ-ын нөөц хаягдал, бохирдол тооцсоноор Төвийн дайрганы ордоос 95.95 мян.м<sup>3</sup>, Тойгийн дайрганы ордоос 30.24 мян.м<sup>3</sup>, Ангийн шаврын ордоос 75.37 мян.м<sup>3</sup> нийт 201.56 мян.м<sup>3</sup> нөөц ашиглана.

Тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг үргэлжлүүлэн 17,650 т.м баганат, 30,000.0 т.м цохилтот өрөмдлөг, суваг малталт 3,000 т.м буюу 7200 куб метр ажлыг гүйцэтгэхээр хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан.


Хайгуул, олборлолтын ажил хийх явцад төрөл бүрийн шалтгааны улмаас төлөвлөсөн ажилд өөрчлөлт орох, хайгуулын үр дүнгээс хамааран дараагийн шатны ажилд өөрчлөлт орох явдал байдаг.

### 1.8. Хүдэр боловсруулах үйлдвэр

ХБҮ-ийн хүчин чадал 650.0 мян.тн/жил ба төслийн хэрэгжих 10 жилийн хугацаанд 3.11 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.51 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 5,719.76 мян.тн хүдэр үүнээс эхний жил 3.80 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.37 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 300.0 мян.тн хүдэр, 2-4 дэх жилд 4.00 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.51-1.90 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,950.0 мян.тн хүдэр, 5-7 дахь жилд 3.10 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.32-1.90 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,950.0 мян.тн хүдэр, 8-10 дахь жилд 1.84-1.85 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.08-1.10 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,519.76 мян.тн хүдрийг тус тус тэжээхээр байна.



Зураг 4. Боловсруулах үйлдвэр



Зураг 5. Хүдэр боловсруулах үйлдвэрийн технологийн ерөнхий схем

### 1.8.1. Үйлдвэрийн технологийн горим

Ил уурхайгаас ирүүлсэн анхдагч хүдрийг 1 шатны бутлалт, 2 шатны нунтаглалт, ангилалт болон уусгалт шингээлтийн СІР технологиор баяжуулж, десорбци электролизийн процессоор алтыг ялгаж авна. Хүдэр боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлыг стандарт шаардлагын дагуу саармагжуулж, саармагжуулсан хаягдлыг фильтр прессээр шүүн шааж гаргасан 15%-ийн чийглэгтэй хатуу хаягдлыг нэгдсэн хаягдлын сан /IWF/-д хуримтлуулна.

### 1.8.2. Лаборатори

Үйлдвэрийн дэргэдэх лаборатори нь үйлдвэрийн бүх шатны эрдэс химийн сорилт, шинжилгээ, судалгаа гүйцэтгэж, анхдагч хүдэр, хаягдал болон баяжмалын чанарыг тодорхойлох, хүдэр боловсруулах технологийн явцыг шалгах, сайжруулах, тохируулга хийж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажиллах явцыг шинжлэн судлах, сорьц боловсруулна. Технологийн шат дамжлагуудаас ирсэн сорьцыг шинжилж, цаг тухайд нь үр дүнг боловсруулна.

### 1.8.3. Химийн бодис

Химийн бодисоос үүдэлтэй аюул осол нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл өндөртэй. Химийн хорт болон аюултай бодисын үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах “Химийн бодисын ослын үед ажиллах төлөвлөгөө”-г боловсруулан мөрдөж ажиллана.

**Хүснэгт 7. Хэрэглэх химийн бодис, тн /2026 он/**

№	Химийн бодисын нэр /Монгол/	Химийн бодисын нэр /Англи/	CAS number	Томъёо	Ашиглах зориулалт	Хэрэглээ, тн
1	Шохой	Quick Lime	1305-78-8	CaO	Уусмалын орчин тохируулах	237.7
2	Натрийн цианид	Sodium Cyanide	143-33-9	NaCN	Алтны хүдэр уусгах	170.6
3	Натрийн гидрооксид	Sodium Hydroxide	1310-73-2	NaOH	Уусмалын орчин тохируулах	88.9
4	Флокулянт	Flocculant		AN934 SH	Өтгөрүүлэх	43.9
5	Натрийн метабисульфид	Sodium Metabisulphite (SMBS)	7681-57-4	Na <sub>2</sub> S <sub>2</sub> O <sub>5</sub>	Хаягдал хүдэр дэх цианидыг задлан саармагжуулах	195.0
6	Давсны хүчил	Hydrochloric Acid /37%/	7647-01-0	HCl	Идэвхижүүлсэн нүүрс цэвэрлэх	136.7
7	Зэсийн сульфат	Copper Sulphate	7758-98-7	CuSO <sub>4</sub>	Хаягдал хүдэр дэх цианидыг задлан саармагжуулах	37.8
8	Идэвхижүүлсэн нүүрс	Activated Carbon		C	Алт шингээх	25.0
9	Бура	Borax /99%/	1330-96-4	Na <sub>2</sub> B <sub>4</sub> O <sub>7</sub>	Алт хайлуулах	1.7
10	Цахиурын исэл	Silica	112945-52-5	SiO <sub>2</sub>	Алт хайлуулах	1.7
11	Натрийн карбонат	Soda Ash	497-19-8	Na <sub>2</sub> CO <sub>3</sub>	Алт хайлуулах	1.5
12	Калийн нитрат	Potassium Nitrate /99%/	7757-79-1	KNO <sub>3</sub>	Алт хайлуулах	0.3
13	Сульфамын хүчил	Sulphamic Acid	5329-14-6	H <sub>3</sub> NSO <sub>3</sub>	Десорбци хэсэг	0.0
14	Азотын хүчил	Nitric acid /68%/	7697-37-2	HNO <sub>3</sub>	Фильтр цэвэрлэх	4.5
15	Антикслант	Antiscalant			Шугам хоолойн цэвэрлэгээ	3.7

**1.8.4. Химийн бодисын агуулах**

Химийн урвалж хадгалах агуулах нь 40.7 х 42.5 м хэмжээтэй хашаатай, химийн бодис хадгалах 4 агуулах, аюултай хог хаягдал түр хадгалах 1 цэг, хяналтын өрөө болон эмнэлгийн өрөөнөөс бүрдэх нийт 6 хэсэгтэй, 550 тн бодис хадгалах багтаамжтай. Химийн бодисын агуулахын гадна талбайг цементэлсэн, асгарсан химийн бодисыг цуглуулах зориулалт бүхий систем, 11 камер, 3 том гэрэлтүүлэгтэй ба агуулах тус бүрийн гадаа хаалганы дээр хөдөлгөөн мэдрэгч гэрэлтэй, галын болон ослын үеийн дохиоллоор бүрэн тоноглогдсон.

**1.8.5. Хаягдлын нэгдсэн сан**

Хүдэр боловсруулах үйлдвэрээс гарах хуурай хаягдлыг уурхайн хөрсний чулуулгийн овоолгод хамтад нь байршуулах, шингэн үл нэвчүүлэх суурь болон хур тунадасны усыг шүүрүүлж, цуглуулах байгууламжтай байхаар хаягдлын нэгдсэн санг төлөвлөсөн. Хөрсний овоолгын тогтворжилт, хөрсний овоолгын хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөлтөөс хамааруулж овоолгын доголын оновчтой өндрийг 35 м, доголын хажуугийн өнцгийг 27 градус, овоолгын ерөнхий налууг 20 градус байхаар төлөвлөсөн.

Төсөл хэрэгжих 7 жилийн хугацаанд хүдэр боловсруулах үйлдвэрээс 3.60 сая.м<sup>3</sup>, жилд дунджаар 0.41 сая.м<sup>3</sup> хуурай хаягдал гарна.



**Зураг 6. Хаягдлын нэгдсэн сан**

#### **1.8.6. Машин механизмын засварын газар**

Хүнд, хөнгөн машин механизмын засварын газар нь уулын үндсэн болон туслах машин тоног төхөөрөмжийг оношлох, задлах, засварлах, угсрах бүхий л тоног төхөөрөмж, хүнд, хөнгөн машин механизмын засвар өөрөө буулгагч орохуйц, 30 тн ба 5 тн-ын дэгээ бүхий гүүрэн кранаар тоноглогдсон байна. Түүнчлэн засварын оффисын өрөө, ажилчдын хувцасны өрөө, хооллох өрөө, багажийн өрөө, ариун цэврийн өрөө зэрэг ажилчдын ажлын тав тухыг хангасан байхаар төлөвлөн, баригдаж байна. Хүнд, хөнгөн машин механизмын засварын газарт нэгэн зэрэг 3 ш хүнд даацын техник болон 3 суудлын тэргэнд засвар үйлчилгээ явуулах хүчин чадалтай.

#### **1.8.7. Тэсэлгээний ажил, тэсрэх бодисын агуулах**

Ил уурхайн тэсэлгээний ажилд энгийн тэсрэх бодис анфо /ANFO/ болон усанд тэсвэртэй эмульсийн тэсрэх бодисыг хэрэглэхээр төсөлд тусгасан. Тэсэлгээний ажлыг хөрсөнд 7 хоногт 1 удаа, хүдэрт 3 хоногт 1 удаа явуулахаар тооцсон. Тэсэлгээний ажил явуулж байх үед хүн, барилга байгууламж, тоног төхөөрөмж зэрэгт нөлөөлж болох чичиргээ, агаарын цохилтын долгион, чулуулгийн шидэлтийн зайг тогтоон аюулгүй ажиллагааг ханган ажиллана.

Тэсрэх материалын агуулах болон тэсрэх материал хадгалах, бэлтгэх зориулалт бүхий байр нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм болон стандартын дагуу доторлож, тоноглож, төхөөрөмжилсөн байна.



**Зураг 7. Тэсрэх бодисын агуулах**

### **1.9. Шатахуун түгээх станц**

Уурхайн шатах тослох материалын жилийн дундаж хэрэглээ нь дизелийн түлшинд 3,000 тн, дизелийн масло 50 тн, бусад төрлийн шатах тослох материал 7 тн тус тус байна. Шатах тослох материалын 1 сарын нөөцтэй байна, түлш хадгалах 100 тн-ын багтаамжтай ган сав 10 ширхэг, дизелийн масло болон бусад материалыг зориулалтын савтай нь тус тус хадгалахаар төлөвлөсөн.

### **1.10. Цахилгаан хангамж**

Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа Баянхөндий төслийн талбай хүртэл 110кВ-ын 242 км урт цахилгаан дамжуулах агаарын шугам 110/11 кВ-ын 2\*16 МВА чадалтай Баянхөндий дэд станц, 2\*2750 кВА чадалтай дизель генератор, 7.7 км урттай 11 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажлыг М-Си-Эс Интернэйшнл ХХК гүйцэтгэсэн.

Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах төслийн 2021 онд батлагдсан БОННУ-ний тайланд: Уурхайн цахилгаан хангамжийг улсын төвлөрсөн цахилгаан шугамаас хангах боломжгүй, дизель цахилгаан эх үүсвэр болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хослуулан ашиглахаар төсөлд тусгасан байсан тул 110/11 кВ-ын 2\*16 МВА чадалтай Баянхөндий дэд станц, 2\*2750 кВА чадалтай дизель генератор, 7.7 км урттай 11 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажилд хуулийн нийцтэй байдлыг хангах зорилгоор гүйцэтгэгч аж ахуйн нэгж БОННУ-г мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн.



**Зураг 8. Баянхөндий-Нарийнсухайт 110 кВ-ын ЦДАШ**


Цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгчид нь:

- Ил уурхай (ус таталтын насосууд)
- Хүдэр боловсруулах үйлдвэр
- Уурхайн хотхон
- Засварын газар
- Уурын зуух.

Хүдэр боловсруулах үйлдвэрийн тээрмүүд, уурхайн ажилчдын хотхон 11/0.4 кВ-ын цахилгаан эрчим хүчээр, бусад хэрэглэгчид 0.4 кВ –ын цахилгаан эрчим хүчээр хангагдана. Кэмпийн 11/0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамаас салбарлаж 11/0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж гүний худгууд болон өргөлтийн насос цахилгаанаар хангасан.

### 1.11. Бохир ус цэвэрлэх байгууламж

Ажилчдын кемпийн цэвэрлэх байгууламж нь хоногт 80 м<sup>3</sup> бохир ус, хүдэр боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж нь хоногт 40 м<sup>3</sup> бохир ус цэвэрлэх хүчин чадалтай. Байгууламж нь газраас доош 2 давхар, төмөр бетон бүтээцтэй.



**Зураг 9. Бохир ус цэвэрлэх байгууламж**

### 1.12. Уурхайн дулаан хангамж

Уурхайн барилга байгууламжуудыг халаалтын уурын зуухаар халаана. Халаалтын усны дундаж температур 70-95°C, халаалтын систем нь түгээлтийн болон буцалтын ус битүү хэлхээнд байхаар зохион байгуулагдсан. Жил бүр 10-р сарын 01-ээс 5-р сарын 10-ны хооронд 194 хоног дулаанаар хангана, халаалтын ачаалал 2878 кВт, хэрэглээний халуун усны дулааны ачаалал 92 кВт байна.

Уурхайн бүсийг 14 мВт 1 ш, 28 мВт 1 ш халаалтын зуухаар, кэмпиийг 7 мВт 3 ш халаалтын зуухаар хэрэглээний халуун ус болон дулаанаар хангана.




Зураг 10. Уурхайн бүсийн уурын зуух

### 1.13. Ус хангамж

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “Усны нөөц батлах тухай” А/640 тушаалаар “Хүрэн цавын худгийн” ордын нөөцийг С зэргээр 10 л/с буюу 864м<sup>3</sup>/хоногоор, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Усны нөөц батлах тухай” А/11 тушаалаар “Баянхөндий газрын доорх усны орд”-ын нөөцийг 15 жилийн хугацаатай С зэргээр 8.7 л/сек буюу 751.68м<sup>3</sup>/хоногоор баталсан. Усны газрын 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 158 тоот дүгнэлтэд “төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах 861.58м<sup>3</sup>/хон усыг нийт 10 л/сек буюу 950.4м<sup>3</sup>/хон газрын доорх усны орд болон шүүрлийн усыг хуримтлуулан хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй” гэж тусгасан.

#### Хүснэгт 8. Ус хангамжийн эх үүсвэр

№	Худгийн дугаар	Гүн, м	Ундарга, л/сек	Зориулалт
1	ВКW-21	66	0.8	Унд ахуй
2	ВКW-48	200	3.6	Технологийн хэрэгцээнд
3	ВКW-54	61.5	4.73	Усалгаанд
4	NCW-01	102	1	Технологийн хэрэгцээнд
5	Шүүрлийн ус	92	1	Технологийн хэрэгцээнд



Зураг 11. Ус хангамжийн системийн схем


## 1.14. Тээвэрлэлт

Тээвэрлэлтийн үйл ажиллагааг Улаанбаатар хот Баянхонгор аймгийн төв хооронд улсын чанартай автозамаар, Баянхонгор аймгийн төв төслийн талбай хооронд Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны “Замын чиглэл тогтоох тухай” А/396 дугаар захирамжаар батлагдсан чиглэлээр гүйцэтгэж байна.

Олон салаа зам гаргах, замыг өргөсгөх, тоосжилтоос сэргийлэх зорилгоор батлагдсан маршрутын дагуу шаардлагатай цэгүүдэд замын тэмдэг тэмдэглэгээг байршуулахын зэрэгцээ жолооч нарт тогтоосон маршрутын дагуу тээвэрлэлт хийхийг тогтмол анхааруулж, тогтоосон маршрутаас өөр замаар зорчсон тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажилладаг.

### 1.14.1. Дотоод зам

Тусгай зөвшөөрлийн талбай дотор хүн тээвэр, хөнгөн тэрэг зорчих болон барилгын материал зөөх зориулалт бүхий 7.9 км урт шороон сайжруулсан замыг ашиглаж байна.



**Зураг 12. Төслийн дотоод замын трасс болон хөндлөн огтлол**

### 1.14.2. Агаарын харилцаа

Хөндий талбай нь Улаанбаатар хотоос авто замаар 1000 км, агаарын замаар 698 км зайд байрладаг. Улаанбаатар – Шинэжинст /тусгай зөвшөөрлийн талбай/ чиглэлийн агаарын нислэгийг “Геосан” ХХК 9 хүний суудалтай онгоцоор 7 хоногт 4 удаагийн давтамжтай гүйцэтгэж байна.

### 1.15. Холбоо харилцаа

Интернет, харилцаа холбооны найдвартай байдлыг хангах үүднээс үүрэн телефоны оператор “Юнител” ХХК-тай хамтран ажиллаж байгаа бөгөөд төслийн талбай дээр тус үүрэн телефоны операторын сүлжээ бүрэн орсон.

Уурхайн дотоод холбоонд боловсруулах үйлдвэрийн операторууд, экскаватор, өрмийн машин, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдсан.

#### **1.16. Хүний нөөцийн бодлого**

Баянхонгор аймаг нь 20 сумтай, ойролцоогоор 88,166 хүн амтай ба үүнээс 2,565 нь Шинэжинст сумд оршин суудаг. Төсөл хэрэгжүүлэгч нь орон нутагтай хуулийн хүрээнд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор ашиглалтын хугацаанд нийт ажилтны 30 хувийг орон нутгаас бүрдүүлэх зорилготой ажиллаж байна.

Төсөлд нутгийн иргэдийг ажлын байраар хангах ажлын хүрээнд “Энержи ресурс” ХХК-тай хамтран хүнд машин механизмын операторын сургалтыг 2023 оны 05 сараас хойш 8 удаа зохион байгуулж, Баянхонгор аймгийн 17 сумын 160 иргэнийг хамруулан, чадамжийн гэрчилгээ олгосон ба 105 иргэн нь Ухаа худаг уурхайд үргэлжлүүлэн ажиллаж байсан. Ухаа худаг уурхайд ажиллаж байсан иргэд Баянхөндий төслийн олборлолтын олборлолтын үйл ажиллагаа эхэлж байгаатай холбогдон “Эрдэнэ Монгол” ХХК-руу шилжин, орон нутгаасаа үргэлжлүүлэн ажиллаж байна.

## **БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

### **2.1. Физик газарзүй**

Физик газарзүйн мужлалын хувьд Монгол Алтайн их мужид, газарзүйн хэлбэр гадаргуугийн хэв шинжээр уулс хоорондын хөндийн хэв шинжид багтаан үздэг. Газрын гадаргын хувьд 1850-2010 м өргөгдсөн мөлгөрдүү оройтой намхан толгодтой, эдгээр нь өөр хоорондоо 25-40 метрийн өргөн хуурай сайраар тусгаарлагдсан, элэгдэл хуримтлалын рельеф зонхилно (Ш.Цэгмид 1967 он). Ашиглалтын талбай нь Эдрэнгийн нурууны зүүн төгсгөлд оршино.

### **2.2. Уур амьсгал**

Ашиглалтын талбайн нутаг дэвсгэр нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай. Агаарын урсгал үүсэхэд уул зүйн нөхцөл болон орон нутгийн бичил салхи нөлөөлж, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар, зундаа халуун дулаан, өвөлдөө хахир хүйтэн нөхцөлтэй бичил бүс нутгийг бүрдүүлдэг. Өвлийн улиралд цас бага ордог бөгөөд агаар нь хуурайвтар, чийг багатай, харин хавар салхи шуурга ихтэй, зарим үед 40 м/сек-ээс их хурдтайгаар шуурдаг. Үнэмлэхүй бага температур нь  $-37.4^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй их температур нь  $44.9^{\circ}\text{C}$  хүрдэг бөгөөд үнэмлэхүй их, бага температурын агууриг нь ( $82.3^{\circ}\text{C}$ ) эрс ялгаатай байдаг. Жилийн дундаж температур нь  $0.7^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 01 сарын дундаж температур  $-15.5^{\circ}\text{C}$  байхад хамгийн дулаан буюу 07 сарын дундаж температур  $16.8^{\circ}\text{C}$  байдаг.

### **2.3. Гадаргын ус**

Хөндий тусгай зөвшөөрөлтэй талбай нь Алтайн өвөр говийн сав газарт багтах бөгөөд энэ сав газар дахь ихэнх голдрил нь түр урсацтай, жилийн ихэнх хугацаанд хуурай байдаг. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайг түр урсацтай, хуурай сайрууд дайран өнгөрөх бөгөөд эдгээр сайрууд зун, намрын эрчимшил ихтэй хур борооны үед түр урсацтай болдог.

### **2.4. Газрын доорх ус**

Баянхөндийн талбай нь гидрогеологийн дүүрэгчлэлээр улирлын хомс тэжээлтэй Монголын Өмнөдговийн хэсгийн дэд мужид багтана. Харин төслийн ойр орчмын дэвсгэр талбай нь Монгол орны гидрогеологийн мужлалаар (Н.Жадамбаа ба болон бусад, УБ 1988) хувирмал, терриген, вулканоген чулуулгаас бүрдсэн антиклиналь атираажилтай гидрогеологийн массивт хамаарна. Төслийн үйл ажиллагаа эрчимжиж эхэлсэн 2023 оны II улирлаас эхлэн улирал бүр үйлдвэрлэлийн зориулалтаар ус авч байгаа худгуудын усанд тогтмол шинжилгээ хийлгэж байна.

Усны чанарын 2019, 2022 - 2025 онуудын шинжилгээний үр дүнгээр Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд кальци, хлор, сульфат, ерөнхий хатуулаг, стронци, Хүрэнцав, Өргөө, Босго, Майхан хүрэнгийн хойд худгуудад магни, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Хүрэнцав, Майхан хүрэнгийн хойд, Босго худгуудын усанд никель, Майхан хүрэнгийн хойд худгийн усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгуудын усанд төмрийн

агууламж тус тус Ундны усны стандарт (MNS 0900:2018)-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан байна.

Майхан хүрэн (хойд, урд), Хүрэн цав, Өргөө, Босго худгуудын усанд хлор, сульфат, Гүн заг худгийн усанд хөнгөн цагаан, Өргөө, Босго худгуудын усанд манган, Гүн заг, Майхан хүрэн урд, хойд худгуудын усанд молибден, Хүрэнцав, Гүн заг, Майхан хүрэн хойд, Босго худгуудын усанд хүнцэл, Гүн заг, Майхан хүрэн хойд худгуудын усанд уран, Өргөө худгийн усанд төмөр гэсэн элементүүд тус тус Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 6148:2010) стандартаас тус тус давсан үзүүлэлттэй байна.

### **2.5.Хөрсөн бүрхэвч**

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбай орчмын бүс нутагт цөлийн бор саарал хөрс зонхилон тархсан. Төслийн талбай орчимд тархсан бор саарал хөрс нь элсэнцэр, хэврэг бүтэцтэй, үржил шим багатай, эмзэг хөрс тархсан.

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн талбайд ил уурхай, гадаад овоолгууд, Боловсруулахүйлдвэр, уурхайн үйлчилгээ, хангамжийн барилга байгууламжуудыг 117.44 га талбайд байгуулахаар төлөвлөсөн. Барилга байгууламжуудыг барихаас өмнө хөндөгдөх талбайн өнгөн хөрсийг хуулж шимт хөрс хадгалах талбайд байршуулна. Нийт хөндөгдөх талбайгаас 0.8 тн ялзмагийн агууламжтай 228.4 мян.м<sup>3</sup> шимт хөрс хуулагдана. Шимт хөрсний овоолгын үржил шимийг тогтвортой байлгах зорилгоор орой болон хажууг ургамжлуулна. Энэхүү шимт хөрсийг уурхайн ашиглалтын хугацаанд болон хаалтын үе шатанд эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд ашиглана.

### **2.6.Ургамлан нөмрөг**

Баянхөндий ордын байрлаж буй бүс нутаг нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Алтайн өвөр говийн цөлийн тойрог, цөлийн хээрийн бүсэд хамаарагддаг. Ургамалжилтын хувьд сийрэг, чулуут цөлийн хэвшинжид хамаарна. Энэ тойргийг ургамлын зүйлийн бүрдлийн хувьд их ядмаг боловч Алашаа говиос арай илүү гэж үздэг. Тус ордын талбайд гүйцэтгэсэн 3 удаагийн хээрийн судалгаагаар 57 зүйл ургамал тэмдэглэгдсэн бөгөөд ургамлын зүйлийн бүрдэлд сөөг, сөөгөнцөр (бүйлс, зээргэнэ, хармаг, хотир, бударгана, ортууз гэх мэт) зонхилсон. Мөн 2 зүйлийн мод (сухай, заг), 1 зүйлийн хагас шимэгч (Цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо) болон олон наст өвслөг ургамлууд ургадаг. Үүнээс гадна тухайн жилийн хур тундасны хэмжээнээс хамааран ургадаг эсвэл өнждөг нэг наст ургамлууд тохиолдоно.

Тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн байгаль орчны судалгаануудаар 57 зүйл ургамлаас нэн ховор 3 зүйл (Регелийн будраа, Толбот бэрээмэг, Потанины Хотир), ховор 2 зүйл (Монгол бүйлс, Өргөст ортууз) бүртгэгдсэн. Харин цөлийн аргамжин цэцэг буюу цагаан гоёо Майхан хүрэнгийн худгаас Алтан нар орох зам дагуу загийн ёроолоор шимэгчлэн ургадаг.

### **2.7.Амьтны аймаг**

Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд хөхтөн амьтдаас хар сүүлт, махчдаас чоно, үнэг шавж идэштнээс зараа, мэрэгчдээс алаг даага, шар чичүүл, бор шигшүүхэй жигүүртнээс цэгцгий, сар, хэрээ, хулан жороо, тас, цөлийн чогчиго мөлхөгчдөөс хонин ба нохой гүрвэл, сум могой тархсан.

## **2.8. Нийгэм - Эдийн засаг**

Төслийн талбай нь манай орны дэд бүтэц сул хөгжсөн бүс нутагт байрлана. Хүн амын суурьшил маш багатай. Гол төлөв Халх ястан амьдардаг бөгөөд сумын хүн амын 90 орчим хувь нь мал аж ахуй эрхэлдэг. Хөндий талбай нь Шинэжинст, Баян-Өндөр сумдаас 130 орчим км зайтай оршино. Хамгийн ойр орших Шинэжинст сум нь талбайгаас 85 км-т байдаг бөгөөд энэ сум нь 2015 онд төвийн нэгдсэн цахилгаан сүлжээнд холбогдсон. Хүн эмнэлэг, холбооны салбартай, 9 жилийн дунд сургууль, ШТС-тай. Тээврийн үндсэн төрөл нь автомашин бөгөөд харилцдаг бүх газруудтайгаа шороон замаар холбогдоно. Шинэжинст сумын унд ахуйн усыг цэнгэгжүүлэх байгууламж, ус хангамжийн системд урвуу осмосын системийг нэмэлтээр суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор худаг гаргаж Шинэжинст сумд хүлээлгэн өгсөн.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ҮНДСЭН БОЛОН БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-02144 дугаартай “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн барилгын үе шатны үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн хураангуйг доорх хүснэгтэд тоймлон үзүүлэв.

#### Хүснэгт 9. Баянхөндий төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр				
	Барилгажилтын үе шат				
	Барилга байгууламж барих талбайн хөрс хуулагт	Зам ашиглалт/Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	Барилгын материал тээвэрлэх, хадгалах, ашиглах	Барилга байгууламж, түр суурин барих	Хог хаягдал цуглуулах, устгах талбай байгуулах
<b>Газрын гадарга, хэвлий</b>					
<b>Үндсэн</b>					
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 117.44 га газрын гадарга эвдрэлд орж, гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх, байгалийн үзэмжийг доройтуулах	Т	Т	Т	Т	У
<b>Болзошгүй</b>					
Уурхайн ажилчдын хотхоноос гарсан хог хаягдал, уурхайн бусад барилга байгууламжуудын хатуу хог хаягдлын менежментийг хангалтгүй хийснээр тухайн орчны газрын гадаргыг бохирдуулах					У
<b>Уур амьсгал</b>					
<b>Үндсэн</b>					
Энэ төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс жилд хамгийн ихдээ 61,599 тн нүүрсхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг дээр дурдсан хэмжээгээр нэмэгдүүлнэ.		Д			
<b>Агаарын чанар</b>					
<b>Үндсэн</b>					
117.44 га эвдэгдсэн талбайгаас цагт 39.24 кг тоос дэгдэн агаарын чанарт нөлөөлнө. Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.		Б			
Тээврийн хэрэгслүүд болон дизель цахилгаан генераторуудаас жилд 61599 тн нүүрстөрөгчийн хий ялгарна.		Б			
<b>Гадаргын ус</b>					
<b>Үндсэн</b>					
Ил уурхай, хүдрийн овоолго, авто зам байгуулснаар Хүрэн цавын сайрын голдирол өөрчлөгдөх				Б	

Шимт хөрсний овоолго, авто зам, автомашины зогсоол, ШТС, дулаан хангамжийн байгууламж, хаягдлын нэгдсэн байгууламж, хаягдлын талбайг байгуулснаар сайрын голдирол өөрчлөгдөх				Б	
<b>Газрын доорх ус</b>					
<b>Үндсэн</b>					
Газрын доорх усны тэжээмжийн талбай багасах				Б	
<b>Болзошгүй</b>					
Химийн бодисоор бохирдсон ус асгарч алдагдаж болзошгүй;			б		
ШТМ асгаралт бий болж болзошгүй.		б			
<b>Хөрсөн бүрхэвч</b>					
<b>Үндсэн</b>					
Ил уурхайг ашиглах, барилга байгууламжуудыг барих явцад хөндөгдөх 117.44 га талбайгаас 0.8 тн ялзмагийн нөөц бүхий 320.4 мян.м3 шимт хөрс хуулагдана.	У			Д	
<b>Болзошгүй</b>					
ШТМ алдагдсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох		Д			
Ашиглалт дууссан аккумуляторын шингэн, Боловсруулах үйлдвэрт ашиглаж буй химийн бодис гоожиж, асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.					Б
<b>Ургамлан нөмрөг</b>					
<b>Үндсэн</b>					
Барилгажилтын үе шатанд уурхайн овоолго, зам бусад дэд бүтцийн барилга байгууламжийг байгуулах 39.26 га талбайгаас 4 хэв шинжийн ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдана.	б	б	б	б	
<b>Болзошгүй</b>					
Барилгажилтын үеийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, газар хөндөх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурч, ургамлан нөмрөг доройтох.	б	б	б	б	
Ашиглалтын үед ил уурхай, хөрсний овоолгуудаас салхиар, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилтын улмаас ургамлан нөмрөгийн фотосинтезийн эрчим ургалтын хугацаанд буурснаар, ургамлын биомасс багасах.					У
<b>Амьтны аймаг</b>					
<b>Болзошгүй</b>					
Барилгын газар шорооны ажлын үед шувуудын үүр устах, тэр дундаа Жороо тоодог ( <i>Chlamydotis undulata</i> ), Хулан жороо ( <i>Podoces hendersoni</i> )	б	б	б	б	
Барилгын ажилтнууд хууль бус ан хийх		б	б	б	
Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас зэрлэг амьтад тэр дундаа нүүдлийн том туруутан амьтад (хар сүүлт зээр) дайжсанаар амьдрах орчноо шууд бусаар алдах		б	б	б	
<b>Тусгай хамгаалалттай газар нутаг</b>					
<b>Болзошгүй</b>					
Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тэсэлгээ хийх зэргээс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар Говийн их ДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд тархан амьдрах амьтад үргэж дайжих		б			
<b>Дуу шуугиан, доргион чичиргээ</b>					

<b>Үндсэн</b>				
Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс дуу шуугиан үүсэж, уурхайн 419 ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.		б		
<b>Нийгэм эдийн засаг</b>				
<b>Болзошгүй</b>				
Баянхөндийн алтны үндсэн ордын ашиглах бүх үе шатанд барилгын материал, хүнс, хүн тээвэрлэх маршрутаар тээврийн хэрэгслүүд зорчих явцад үүссэн тоосжилт, дуу шуугианаас ойролцоо нутаглаж буй малчдад тавгүй байдал үүсэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.		Т		

Нөлөөллийн эрчим		Нөлөөллийн үргэлжлэх хугацаа		
		Т	Түр зуурын	1 сар хүртэл
	Их	б	Богино	сар хүртэл
	Дунд	Д	Дунд	1-3 жил хүртэл
	Бага	У	Урт	Төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл
		Б	Байнгын	Хаалтын дараа ч үргэлжлэх

## **БҮЛЭГ 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

### **4.1. Зорилго, зорилт**

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Грийн Ассесмент” ХХК-ний 2026 онд боловсруулсан Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөлтэй алтны үндсэн ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд (2026-2030) тусгагдсан байгаль хамгаалах арга хэмжээний заалтуудаас 2026 онд хэрэгжүүлэх Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хөндий ордын 2026 оны уулын ажлын, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах уулын ажлын, 7 дахь жилд гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан шинэчлэн боловсрууллаа.

#### **4.1.1. Баримтлах зарчим**

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, холбогдох төрийн захиргааны байгууллагын тусгай дансанд төслийн үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “Эрдэнэ Монгол” ХХК байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

#### **4.1.2. Хамрах хүрээ**

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшдэг Хөндий нэртэй MV-02144 дугаар Ил уурхайгаас 2026 онд уулын цулаар 4.98 сая.м<sup>3</sup> уулын ажил хийгдэнэ. Үүнээс 3.98 сая.м<sup>3</sup> хөрс хуулалт, 370.4 мян.м<sup>3</sup> буюу 978.0 мян.тн үйлдвэр тэжээх хүдэр олборлолтын ажил хийгдэнэ. Мөн 2026 онд нөөцийг борлуулахгүй, зөвхөн дотооддоо 125.0 мян.м<sup>3</sup> дайрга, 75.0 мян.м<sup>3</sup> шавар ашиглах тул ТТАМ-аас олох борлуулалтын орлогогүй болно. ТТАМ-ын нөөц хаягдал, бохирдол тооцсоноор Төвийн дайрганы ордоос 95.95 мян.м<sup>3</sup>, Тойгийн дайрганы ордоос 30.24 мян.м<sup>3</sup>, Ангийн шаврын ордоос 75.37 мян.м<sup>3</sup> нийт бохирдол тооцсоноор 201.56 мян.м<sup>3</sup> нөөц ашиглана. Тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг үргэлжлүүлэн 17,650 т.м баганат, 30,000.0 т.м цохилтот өрөмдлөг, суваг малталт 3,000 т.м буюу 7200 куб метр ажлыг гүйцэтгэхээр хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан. Гэсэн хэдий ч эдийн засаг, хил гаалийн хүндрэл, бэрхшээл болон бусад урьдчилан таамаглах боломжгүй асуудлууд төслийн үйл ажиллагаанд нөлөөлж болох тул 2026 онд төлөвлөсөн уул, барилга, хайгуулын ажлуудад өөрчлөлт орж болзошгүй юм.

Бид хайгуулын үе шатнаас эхлэн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн холбогдох дүрэм, журмуудыг баримтлан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг

бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилгоо биелүүлж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн орон нутгийн хамтын ажиллагааг хангаж ажилласаар ирсэн.

#### 4.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон тусгасан. Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд 2026 онд 300,000,000.00 (Гурван зуун сая) төгрөг, “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд 82,500,000.00 (Наян хоёр сая таван зуун мянган) төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Төслийн БОМТ хэрэгжүүлэхэд зарцуулах зардлуудын хураангуйг доор харуулав.

#### Хүснэгт 10. БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2026 он

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, сая.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө	103.3
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	20.0
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	148.7
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардлаас
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардлаас
6.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14.0
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18.0
8.	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	20.5
9.	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардлаас
10.	Уадитын зардал	20.0
<b>Нийт</b>		<b>344,5</b>
<b>Тэрбум мод хөтөлбөр</b>		<b>123</b>

### 4.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг Хүснэгт 9 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг бүрэн эхээр нь харуулав. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү **төлөвлөгөөг** бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

**Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
<b>НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
Төслийн дэд бүтцийн байгууламжийг барьж байгуулах явцад гадаргын төрх өөрчлөгдөх зэргээр ландшафтын хэвшинжид нөлөөлнө.	Бүх тээврийн хэрэгслүүд батлагдсан авто замын трассаар зорчих, цаашид ашиглахгүй болсон замыг тэмдэгжүүлэх.	Баяжуулах үйлдвэр, хотхон, дотоод зам, дагалдах дэд бүтцийн байгууламж	-	1.5	-	1,500.0	Барилгажилт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед 2026 оны туршид	
Газар хөндөх зөвшөөрлийн дотоод журам боловсруулан газар шорооны бүхий л ажлын үед мөрдөн ажиллах.	Хяналтгүйгээр газар шорооны ажил гүйцэтгэхээс сэргийлж аливаа газар шорооны ажил эхлүүлэхийн өмнө Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Хүссэн, олгосон талбайн тоо, хэмжээ, га	Зардал шаардлаг агүй	Зөвшөөрөл олгогдсон талбайн хэмжээгээр, га	-	Барилгажилт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед 2026 оны туршид	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, “Эрдэнэ” - ийн бодлого журмын гарын авлага
Овоолгуудын төлөвлөлтийг хаягдлын нэгдсэн байгууламжийг боловсруулсан зураг төслийн дагуу байршуулах ба	Овоолгыг төлөвлөлтийн дагуу хийж гүйцэтгэх маркшейдерын хэмжилтийн зургаар баталгаажуулах.	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	Олборлосон талбайн хэмжээ, га	Зардал шаардлаг агүй	-	-	2026 оны турш, улирал бүр	

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
овоолгоос том бул чулуу өнхрөхгүйгээр хөмсөг хийх								
Төслийн хүрээнд шимт хөрсний овоолгыг 6 байршилд, 5 хүртэл метрийн өндөртэй, овоолго үүсгэн хадгалах ба ашиглалтын нийт хугацаанд 764.21 мян.м3 (сийрэгжсэнээр 917.05 мян.м3) шимт хөрс хуулагдаж, нийт 20.46 га талбайн газрын гадарга нөлөөлөлд өртөнө	Уулын ажлын хүрээнд гарсан шимт хөрсний хэмжээг БОННУ-нд тусгагдсан шимт хөрс хадгалах талбайд MNS 5917:2008 стандартын дагуу 1-р овоолгыг хэлбэржүүлэх.	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	м <sup>3</sup>	-	Уулыг ажлын төлөвлөгөөний дагуу	Үйл ажиллагааны зардал	2026 оны турш	MNS 5917:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
<b>ХОЁР. УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
Уурхайн ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс нүүрхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн	Баянхөндийн уурхайн хүлэмжийн хийн SCOPE 1 тодорхойлон эх үүсвэрийг тодорхойлон бүртгэх	Нүүрс, шатахууны хэрэглээ	Tn / CO2	Зардал шаардагд ахгүй	Хэрэглэсэн нүүрс, шатахууны хэмжээгээр	-	2026 оны турш, сар бүр бүртгэх	*MNS ISO 14064-1 - 2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж) *Уур

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
хийн агууламжийг нэмэгдүүлнэ.								амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06)
Үйл ажиллагаанаас хүлэмжийн хий ялгарснаар агаар мандал дахь хүлэмжийн хийн ялгаруулалтыг нэмэгдүүлнэ.	Уурын зууханд тогтмол мониторинг хийх, үр дүнд үндэслэн шүүлтүүр суурилуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх.	Дулааны төв станц	-	-	Сар бүр	Үйл ажиллагаа, хяналт шинжилгээний хөтөлбөрт	2026 оны Сар бүр хуваарийн дагуу /	Монгол Улсын Агаарын тухай хууль; MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага
Цаг агаарын хүчин зүйлсээс хамааран химийн бодисын хадгалалтын горим хангахгүй нөхцөлд хадгалбал хэт хөрснөөс талсжих, халснаас ууршиж дотоод даралт нэмэгдэх, дулаанд тогтворгүй бүтээгдэхүүн үүсэх, нарны гэрэл болон хэт ягаан туяанаас исэлдэх	Химийн хортой болон аюултай бодисуудыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу шаардлага хангасан агуулахад хадгалах,	Химийн бодисын агуулах	кг	-	Хадгалсан хортой болон аюултай бодис	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны турш улиралд нэг удаа	*MNS ISO 14064-1 - 2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж) *Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06)
	Химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх.	Химийн бодисын агуулах	кг	-	Хадгалсан хортой болон аюултай бодис	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны турш улиралд нэг удаа	

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
<b>ГУРАВ. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
Эвдрэл, элэгдэлд өртсөн, хөрсөн бүрхэвч талхлагдсан хэсгүүдээс тоос шороо агаарт дэгдэх	Нисэх зурвас кэмп хоорондох, кэмп уурхай хоорондох, технологийн замуудыг услах	Шороон зам, тээврийн хэрэгслүүд	Усалгаа хийсэн өдрийн тоо	347,5	200	69,500.0	2026 оны 04 сарын 10-аас 10 сарын 30 дуустал	Усны тухай хууль (2012) 32.8 дугаар зүйл
	Тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцох хурдны дээд хязгаарыг 40 км/цагаас хэтрүүлэхгүй байх	Тээврийн хэрэгсэл, шороон замууд	Өдөрт хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн тоо	Зардал шаардагд ахгүй	-	-	-	2026 оны туршид өдөр бүр мөрдөх
Тээврийн хэрэгсэл хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Замаас үүссэн тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар арчилгаа тогтсон хуваарийн дагуу хийх	Ил уурхайн хаягдлын сан болон түүний орчимд ашиглагдаж буй замууд, дэд бүтцийн дагуух замууд	Км/ мото.цаг	-	12	Үйл ажиллагааны зардал	2026 оны турш хуваарийн дагуу	Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"

Гол болзошгүй нөлөөллүүд	болон сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийг арга	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
Тээврийн хэрэгсэл хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Мазаалай кемпээс үзүүр худаг хүртэлх сайжруулсан шороон замын усалгаа, Арчилгааг хийх		Уурхайгаас үзүүр худаг хүртэлх сайжруулсан шороон зам	Нэгж усалгаа, арчилгаа засвар	-	Тодорхойлох боломжгүй	7,300.0	2026 оны турш /батлагдсан хуваарийн дагуу /	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008
Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдсанаас ууршимтгай, дэгдэмхий бодисууд агаарт уурших, исэлдэн урвалдах зэргээр агаарын чанар найрлагад нөлөөлөх	Химийн бодисын агуулахын хадгалах нөхцөлийг стандартын шаардлагын түвшинд тохижуулах, хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсан зааврын дагуу хадгалах, химийн бодисын агуулахад хор аюулын лавлах мэдээлэлд тусгагдсаны дагуу хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байхад хяналт үзлэг хийх .		Химийн бодисын агуулах	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны турш улиралд нэг удаа	

Гол болзошгүй нөлөөллүүд	болон сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийг арга	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
Баянхөндий алтны үндсэн орд ашиглах төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник хэрэгслүүдээс ялгарах бохирдуулагч хийн нөлөөлөл	Тээврийн хэрэгслээс ялгарч буй Бохирдуулагч хийн ялгарлыг бууруулахын тулд техникийн үзлэгт хугацаанд нь оруулах, ашиглагдаж буй машин техникт засвар үйлчилгээг тогтмол хугацаанд чанартай хийх, техникийн хэвийн ажлын горимыг хангах	Техник хэрэгслүүдээс ялгарах бохирдуулагч хий	Км/ мото.цаг	-	Төлөвлөгөөт мото.цаг	1,000.0	2026 оны турш хуваарийн дагуу	MNS 4585 :2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2007, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм Агаарын тухай хууль MNS 5013 :2001 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ	
<b>ДӨРӨВ. ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>									
Газрын доорх усны нөөц багасгах	Ус авах худаг нэмэгдсэн тохиолдолд тухайн ус хангамжийн эх үүсвэрийг тоолууржуулах	Ус хангамжийн худгууд	Тоо ширхэг	-	5	Үйл ажиллагааны зардлаас	2026 онд III – IV улиралд	Усны тухай хууль 30.1.4; Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны "Журам батлах тухай" 156 тоот тушаал	
	Мониторингийн цооногт логгер суурилуулах	Ус хангамжийн худгууд	Тоо ширхэг	-	1	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны III улиралд	Усны тухай хууль	

Гол болзошгүй нөлөөллүүд	болон сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийг арга	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
	Ус хангамжийн худгуудын тоолуурын заалтыг өдөр бүр бүртгэх, сумын БОХУБ эсвэл байгаль хамгаалагчаар баталгаажуулах		Ус хангамжийн худгууд	Улиралд нэг удаа	Зардал шаардагд ахгүй	9	-	2026 оны турш улирал бүрийн дараагийн сарын 15-ны дотор	Усны тухай хууль
	Усыг хэмнэлттэй, зохистой ашиглах зааварчилгааг ерөнхий зааварчилгаагаар дамжуулан ажилтнуудад олгох		Төслийн ажилтнууд	Ажилтны тоо	Зардал шаардагд ахгүй	Ерөнхий зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо	-	Төслийн талбайд шинээр ажилд орох ажилтан ирсэн тухай бүрт	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.
	Ил уурхайд ус шүүрсэн тохиолдолд усыг зам усалгаанд ашиглах		Баянхөндий ил уурхай	м <sup>3</sup>	-	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны I – IV улиралд	Усны тухай хууль
Усны нөөцийн саванд гадны биет орох, амьтан унах	Ус нөөцлөх 50 м <sup>3</sup> багтаамжтай хос усан сангийн орчим хяналтын камераар хянах		Кэмгийн усан хангамж	Тоо ширхэг	-	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны турш	Усны тухай хууль
Хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас химийн бодис агуулсан ус алдагдаж газрын доорх усныг бохирдуулж болзошгүй	Боловсруулах үйлдвэрт химийн бодис гоожиж, асгарсан тохиолдолд хуримтлуулах сантай байх хяналт үзлэг хийх		Боловсруулах үйлдвэр	Хуримтлуулах савны эзэлхүүн	-	12	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны турш	Хүдэр боловсруулах үйлдвэрийн зураг PCDP ХХК, 2021 он

Гол болзошгүй нөлөөллүүд	болон сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийг арга	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
<b>ТАВ. ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>									
Засварын газрын ШТМ-ын асгаралт, алдагдлаас хамгаалах арга хэмжээг хангалтгүй хэрэгжүүлснээр хөрс, газрын гадарга бохирдох.	Засварын газраас гарсан хаягдал тос, болон тосоор бохирдсон материалыг тусгай саванд хуримтлуулан нэгдсэн хогийн цэгийн аюултай хог хаягдлын цэгт түр хуримтлуулан аюултай хог хаягдал тээвэрлэн устгах эрх бүхий компанид шилжүүлэн устгуулж актаар баталгаажуулах	Уурхайн хог хаягдлын нэгдсэн цэг дээр ялган ангилж энгийн хог хаягдлыг зориулалтын зууханд шатааж устгах	м3/ акт	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 оны турш	Хог хаягдлын тухай хууль 2017 он
Шимт хөрс хуулалтыг MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт стандартыг баримтлан хуулж, хадгалах	Мазаалай кемп урд талын шимт хөрсний талбайг хэлбэржүүлэн ургамалжуулах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	-	-	1	2,500.0	2026 оны турш	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан. Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл, 2012, 2019	
Шатахуун түгээх станцаас шатахуун түгээх, шатахуун нөөцлөх танканд шатахуун дүүргэх	Шатахуун түгээх станцын талбайг хатуу хучилттай болгох, асгаралтын үед хэрэглэх шингээгч	Засварын газар	ш	Зардал шаардагд ахгүй	1	-	2026 оны турш	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”	

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
үед болон нөөцийн танкны битүүмж алдагдсанаас шатахуун асгарч гоожиж, газрын гадарга хэвлийг бохирдуулах.	материалын иж бүрдлийг байршуулах.							Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал
Баянхонгор аймгийн төвөөс Баянхөндий төслийн талбай хүртэл байгалийн шороон замаар зорчино. Тус замаар ачаа тээвэр болон хүн тээврийн машинууд зорчсоноос замын эвдрэл үүсэх, сул хөрстэй хэсгүүдэд газрын гадаргын эвдрэл үүсэх эрсдэлтэй.	Авто замын маршрутын дагууд тэмдэг, тэмдэглэгээ байршуулах;	Орон нутгийн зам	ш	-	Замын эвдэрсэн хэсгүүд	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны I-III улиралд	Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны “Замын чиглэл тогтоох тухай” А/396 захирамж
	Шаардлагатай тээврийн хэрэгслүүдэд байршил тогтоогч суурилуулан хянах;	Дотоод зохион байгуулалт	-	-	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны I-III улиралд	
	Замын эвдрэл үүсэхээр, хүнд нөхцөлтэй хэсгүүдийг урьдчилан тодорхойлж арчилгаа, засварыг хийж гүйцэтгэх	Орон нутгийн зам	км	10.0	Замын эвдэрсэн хэсгүүд	10.0	2026 оны I-III улиралд	

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
Химийн бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтыг горим алдагдсанаар хөрсөнд их хэмжээгээр шингэх, хөрсөн бүрхэвчинд сөрөг нөлөөлөх, химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглалтын үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх	Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлыг хогийн саванд ангилах ба уурхайн хогийн цэгт түр хадгалан АХХ-тээвэрлэн устгах эрх бүхий аж ахуй нэгжид шилжүүлэн устгуулах	Химийн бодисын агуулах	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 оны турш улиралд нэг удаа	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3307 : 1991 Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга Шалгах хуудас (үүрэг ба үйл ажиллагааны жагсаалт, тоног төхөөрөмжийн шалгах хуудас); Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль. 2012 оны 5 сар.
Алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах явцад овоолго, барилга байгууламж барих болон зам тээврийн хөдөлгөөний үед тоосжилт үүсэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулж үржил шимийг алдагдуулах	Дулааны улиралд хуурайшилт ихтэй нөхцөлд шимт хөрсний овоолгын усалгааг батлагдсан төлөвлөгөөний дагуу тогтмол хийж гүйцэтгэх	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	м <sup>3</sup>	5.0	Батлагдсан төлөвлөгөөний дагуу	5.0	Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2026 оны II-III улиралд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ “Газрын тухай” хууль /шинэчилсэн найруулга/ Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
<b>ЗУРГАА. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
Ил уурхайн хөрс хуулах, зам засах үед ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдах	Газар шорооны ажил эхлэхээс өмнө тухайн талбайд ургамлын бичиглэл хийх	Олборлолтод өртөх талбай, өргөсгөх технологийн зам, ТТАМ олборлох карьерь	удаа	Зардал шаардагд ахгүй	Олгогдсон газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн тоогоор	-	2026 оны турш	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3 );
Түр байгууламжууд, агуулах барих, зам засахад ховор ургамлууд нөлөөлөлд өртөх	Газар шорооны ажил эхлэхийн өмнө тухайн талбай дахь нэн ховор, ховор ургамлыг бүртгэх	Потанины хотир, Регелийн будраа	Талбайн хэмжээ, м <sup>2</sup>	Зардал шаардагд ахгүй	Газар шорооны ажил эхлэхээс өмнө	-	2026 оны турш	Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл, 2012, 2019
	Газар шорооны ажил эхлэхийн өмнө талбайн үзлэгээр нэн ховор, ховор ургамал бүртгэгдсэн тохиолдолд нөлөөлөлд өртөх ургамлыг шилжүүлэн тарих, Газарзүйн мэдээллийн системт бүртгэж зураглал гаргаж байх	Потанины хотир, Регелийн будраа	Бодгалийн тоо	-	Шилжүүлэн тариалсан нэн ховор, ховор ургамал	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны турш	
Байгаль орчны чиглэлээр туршилт, судалгаа явуулах	БНХАУ-д судалсан өвсөн дөрвөлжийг турших	Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутаг дэвсгэрт	га	20,000	0.3	20,000	2026 оны 04 – 05 саруудад	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3 );
Байгаль орчны мэдлэг дутуугаас ургамал тасдаж болзошгүй	Байгалийн ургамлыг тасдахгүй байх урьдчилан сэргийлэх сургалтыг Хэсгийн ажилтнуудад зохион байгуулах	Төслийн ажилтнууд	Ажилтны тоо	Зардал шаардагд ахгүй	Ерөнхий зааварчилга анд хамрагдсан ажилтны тоо	-	2026 оны турш, улирал бүр	“Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр”

Гол болзошгүй нөлөөллүүд болон сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийг арга	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
								Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.
<b>ДОЛОО. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
Хүн амын суурьшил, тээврийн хэрэгслийн дуу чимээ, гэрэл зэргээс амьтад байршиж буй газар нутгаасаа үргэж дайжихаас гадна, тээврийн хэрэгсэлд дайруулж болзошгүй	Батлагдсан замын маршрутаар зорчих	Замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслүүд	Замын маршрут	Зардал шаардагд ахгүй	-	-	2026 оны туршид өдөр бүр мөрдөх	“Баянхөндий ордыг ил аргаар олборлох ТЭЗҮ” Глобекс консалтинг ХХК 2025
	Төслийн талбайд амьтан орж ирсэн тохиолдолд шилжүүлэх	Уурхайн талбай, түүний орчимд	Шилжүүлсэн бодгалийн тоо	-	Шилжүүлсэн амьтан	Үйл ажиллагааны зардлаас	2026 II - IV улирал	Монгол орны хөхтөн, шувуу, мөлхөгчдийн улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл, 2012, 2019
Байгаль орчны мэдлэг дутуугаас амьтныг үргээж, элдэж, алж болзошгүй	Байгалийн амьтныг үргээх, элдэж хөөхгүй байх зааварчилгааг уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөрийн дагуу олгох	Төслийн ажилтнууд	Ажилтны тоо	Зардал шаардагд ахгүй	Ерөнхий зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо	-	Төслийн талбайд шинээр ажилд орох ажилтан ирсэн тухай бүрт	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.
Шувууд эрсдэж болзошгүй	Шувууд (элдэв идэшт) цуглах таатай орчин бүрдүүлэхээс зайлсхийж хоол хүнсний үлдэгдлийг ил задгай хаяхгүй байх, холбогдох хяналт тавих	Хүнсний хаягдал булшлах цэг	Удаа	Зардал шаардагд ахгүй	Сард 1 удаа	-	2026 оны турш, сар бүрийн 25-ны өдөр	“ОНСЕ.ЕМ.604 Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журам”

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт стандарт, туршлага
<b>НАЙМ. ДУУ ШУУГИАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР</b>								
Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугианы нөлөөлөх үүсэх ба ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй	Хэт өндөр дуу шуугиантай (80dBA-аас дээш) орчинд ажилладаг ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл тогтмол ашиглуулах	Засварын газар, Хүдэр боловсруулах үйлдвэр	Ажилтны тоо	-	Сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглэх ажлын байрны тоогоор	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны турш өдөр бүр	OHSE.EM. 417, Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох, ашиглах тухай журам OHSE.EM.100, БОХАБЭА-н эрсдлийн удирдлага зохицуулалтын журам
Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугиан үүсэж, ойролцоо орших нутгийн 1 малчин өрхийн тав тухад сөргөөр нөлөөлж болзошгүй.	Энэ айл өвөлжөөндөө өвөлжиж байгаа үед сард 1 удаа дуу шуугианы хэмжилт хийх, үр дүнгээс хамааран давтамжийг өөрчлөх	1 малчин өрх П.Нямсүрэн (3.2 км)	удаа	-	2	ОХШТ-нд туссан	2026 оны I, II, улиралд	IMS.EM.04 “Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх, оролцогч талуудын хэрэгцээ шаардлага тодорхойлох журам”

#### 4.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төслийн явцад элэгдэл, эвдрэл, бохирдол орсон талбайнуудыг цэвэрлэн, аль болох байгалийн унаган төрхөд нь дөхүүлэн хөдөө аж ахуйн чиглэлээр нөхөн сэргээхээр ТЭЗҮ-д тусгагдсан. Нөхөн сэргээлтийг БОНХАЖС-ын 2015 оны А-138 тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэнэ. Нөхөн сэргээлт хийх объектуудад ашигт малтмалын хайгуул, олборлолт хийх, уурхайн барилга байгууламж, ажилчдын хотхон боловсруулах үйлдвэр, хаягдлын сан байгуулах үйл ажиллагаанд өртөж эвдэрсэн газрууд хамаарна.

Нөхөн сэргээлтийн техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн тодорхой зориулалтаар үргэлжлүүлэн ашиглах зорилгоор ухаж эвдэрсэн газарт дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, талбайг засаж тэгшлэх, бэлтгэсэн талбайг биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулж, шимт хөрсөөр хучих зэрэг үндсэн ажлыг гүйцэтгэнэ. ТЭЗҮ-д техникийн нөхөн сэргээлтийг ашиглалтын 2 дахь жилээс эхлүүлэхээр тусгагдсан.

Төслийн үйл ажиллагаанаас нийт 254.7 га талбай эвдрэлд өртөх бөгөөд үүнээс дунджаар 764.2 мян.м<sup>3</sup> шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгална. Техникийн нөхөн сэргээлтийг “Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008”-ын дагуу 23.23 га талбайд нийт 345.29 мян.м<sup>3</sup>, биологийн нөхөн сэргээлтийг “Байгаль орчин, Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023”-ын дагуу 157.5 га талбайд нийт 764.2 мян.м<sup>3</sup> ажил хийж гүйцэтгэнэ.

Төлөвлөгөөт онд 2024 онд ГТАМ олборлосон BF-06 карьерт 1 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийх ба ил уурхайгаас нөхөн сэргээлтэнд хэрэглэх шимт болон шимэрхэг хөрсийг хөрсний зүсэлтэд үндэслэн 30 хүртэлх см зузаантай хуулж, стандартын дагуу хадгална. Түүнчлэн, нөхөн сэргээлтийн ажилд бэлдэх үүднээс байгалийн ургамал үржүүлгийн газарт өнгөрсөн онд түүж, хадгалсан нутгийн ургамлын үрээр тарилт хийх, өнгөрсөн онд тариалсан тарьц суулгацыг үргэлжлүүлэн арчлах, шилжүүлэн тариалалтад бэлдэх, тодорхой хэмжээний нутгийн ургамлын үр бэлдэх, нөлөөлөлд өртөх ховор, нэн ховор ургамлыг шилжүүлэн тариална. Мөн геологийн хайгуулын цооног өрөмдөх, суваг нэвтрэлтийн ажлын үед эвдэгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж, анхны төрхөнд ойртуулна.

**Хүснэгт 12. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага
Шимт хөрсийг овоолгод тогтвортой байршуулж, нөхөн сэргээлтэд ашиглахад бэлтгэх	Ил уурхайн 2026 онд олборлолтод болон эвдрэлд өртөх талбайгаас зохистой хэмжээний зузаантай хуулсан шимт болон шимэрхэг хөрсний овоолгыг үүсгэх	м <sup>3</sup>	120,000	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны I – IV улиралд	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хөндий ордын 2026 оны уулын ажлын төлөвлөгөө
	Мазаалай кэмийн урд талын шимт хөрсний овоолгын хөрсний үржил, шимт чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор хэсэгчилсэн байдлаар үрээр тарилт хийж эхлэх	м <sup>2</sup>	2500	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны III улиралд	MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
Нөхөн сэргээлтэд хэрэглэх тарьц суулгац бэлтгэх	Нутгийн ургамлын үрийн судалгаа хийлгэх	Тайлан	-	10,000	20,000	2026 оны II-III улиралд	Байгалийн ургамлын тухай хууль 13.3
	Үрсэлгээ бэлтгэх	ш	10,000	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны 04 сарын 15-аас 05 сарын 15	“Эрдэнэ Монгол” ХХК-ны “Баян Хөндий” төслийн хүрээнд “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнийг дэмжин 1 сая мод тарьж ургуулах техник, эдийн засгийн үндэслэл
	Салхины нөмөрлөгчийн зориулалтаар ургамал үржүүлгийн талбайд мод тарих	ш	5000	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны II улиралд	
	Төслийн эзэмшлийн талбайд суулгац шилжүүлэн тарих	ш	2,000	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны III улиралд	

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага
	Модны усалгааг дэмжих хувинг туршилтаар хэрэглэх	ширхэг	800	105,0	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны 05 – 06 саруудад	Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл НҮТББ 2024 он
Газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах	Хайгуулын ажлын үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийн стандартыг баримтлан анхны төрхөд ойртуулах	га	Тодорхойлох боломжгүй	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны III – IV улиралд	“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны “Аргачлал батлах тухай” А/138 тушаал

## **4.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

### **4.5.1. Дүйцүүлэн хамгааллын талаар баримтлах бодлого**

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн бүс нутгийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэх зорилготой ажиллаж байгаа билээ. Энэхүү зорилгодоо уурхайн хаалтын үед хүрсэн байхаар зорьж байгаа хэдий ч төсөл хэрэгжих хугацаанд аль болох эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно. Үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох нөлөөллийг шатлалтайгаар багасгах зарчмыг баримтална. Энэ нь биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа юун түрүүнд тэрхүү нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх арга замаар хийгдэнэ.

Бид нийгмийн хариуцлагын хүрээнд “Үйл ажиллагааны сайн дурын кодекс”-г 2016 онд нэгдсэн орсон ба МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг дэмжин нэг сая мод тарихаар төлөвлөж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд 26.02 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн Баянхонгор аймгийн нөхөн сэргээлт хүлээж авах байнгын комисст хүлээлгэн өгсөн.

### Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалалт зорилт	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ, ширхэг	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага
Бүс нутгийн биологийн төрөл зүйлийн судалгаа	Баянхонгор аймгийн говийн гурван суманд зүйлийн бүрдэлийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх	1	15,000.0	15,000.0	2026 оны 05 сараас 8 сар дуустал	Байгаль орчны 2025 оны БОМТБТ-н дүгнэх хуудсын зөвлөмж, албан тоот
Байгаль орчны аудит	Байгаль орчны аудитыг хоёр жил тутам хийлгэх хуулийн хугацаанд аудит хийлгэж холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх	1	-	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны II улиралд	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10.1, 10.2, 10.3 зүйл
Байгалийн амьдрах орчныг нөхөн сэргээх	Тарьц, суулгац бэлдэх	2,000	5,0	10,000.0	2026 оны II улиралд	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод тарих" үндэсний хөдөлгөөн
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	Нутгийн иргэдтэй хамтран мод тарих	5000	-	22,500.0	2026 оны II, III улиралд	
	Бэлчээрийн ус хангамжийг сайжруулах (худаг засварлах)	3	-	60,000.0	2026 оны 08 сард	
	Шинэжинст сумын нутаг дэвсгэрт зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх	1	9,000	9,000	2026 оны I улиралд	
Техникийн нөхөн сэргээлт	Шинэжинст сумын нутаг дэвсгэр дээр хүний буруутай үйл ажиллагаанаас эвдэрсэн 4 га газар техникийн нөхөн сэргээлт хийх	1	-	32,200.0	2026 оны II-III улиралд	<ul style="list-style-type: none"> <li>• MNS 5915:2008,</li> <li>• MNS 5917:2008,</li> <li>• MNS 5918:2008</li> <li>• MNS 17.5.1.19-92,</li> <li>• Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн</li> </ul>

						нөхөн сэргээлт хийх аргачлал (2015 оны А-138)
Орон нутгийн иргэд болон хүүхэд залуучдын экологийн боловсролыг нэмэгдүүлэх	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, орон нутгийн иргэдийн экологийн болосвролыг нэмэгдүүлэх 02 -р сарын 28 нд мазаалай хамгаалах үндэсний өдөр, 03-р сарын 22 усны өдөр,	2	-	Үйл ажиллагааны зардал	2026 оны I-II улиралд	Усны тухай хууль, Нэн ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 277 дугаар

#### 4.6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

“Эрдэнэ Монгол” ХХК нь 2025 оны II улирлаас эхлэн оффис, кэмп, хүдэр боловсруулах үйлдвэр зэрэг шинэ барилгууд ашиглалтад орсон. Газрын тухай хуульд заагдсны дагуу гадна талбайд мод тарих зэргээр орчныг тохижуулна. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг 2026 оны II-III улиралд хэрэгжүүлнэ.

#### Хүснэгт 14. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Талбайн хэмжээ, м <sup>2</sup>	Нэгжийн зардал (мян. төгрөг)	Нийт зардал (мян. төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага
Кемпийн тохижилт, өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Тариалсан суулгацыг арчилж ургуулах, нэг наст цэцэг тарих	60	10.0	600.0	2026 оны II-III улиралд	Газрын тухай хууль 56.6
	Орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зүлэг тарих	300	-	Үйл ажиллагааны зардал	2026 оны II-III улиралд	

#### 4.7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

БОННУ-нд 2026 онд Төсөл хэрэгжих талбай болон лизенцийн талбайд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө тусгагдаагүй.

#### 4.8. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёлын өв олоход магадлалтай. Хэрэв барилгын болон олборлолтын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд газар шорооны ажлыг зогсоож дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Өмнө нь судалж тогтоож чадаагүй палеонтологи болон археологийн үнэт олдвор илэрвэл илэрсэн даруйд ажлаа зогсоож, олдворын талаар сум/аймгийн Засаг даргад мэдэгдэнэ.
- Бүртгэсэн соёлын өв, түүхийн үнэт олдворын эргэн тойронд эрх бүхий байгууллагын зөвлөмжийн дагуу хамгаалалтын бүс байгуулах ба хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий байгууллага бүртгэгдсэн тэдгээр зүйлсийг нүүлгэн шилжүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.
- Чухал ач холбогдол бүхий түүх соёлын олдвор, үнэт зүйлс олдсон тохиолдолд зөөвөрлөнө. Ингэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралт “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ыг баримтална.

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлнэ.

#### Хүснэгт 15. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримталх стандарт, аргачлал
Газар шорооны ажлын үед том оврын техник хэрэгслээр хөрс хуулах, суваг шуудуу ухах зэрэг ажил хийгдэх явцад өмнөх судалгааны явцад илрээгүй, хөрсөнд хадгалагдан үлдсэн байж болзошгүй археологи, палеонтологийн олдвор санамсаргүй байдлаар тохиолдож, нөлөөлөлд өртөх	Археологи, палентлогийн олдвор үед хэрэгжүүлэх зааварчилгааг уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөрийн дагуу ажилтнуудад олгох	Шинээр ажилд орж байгаа ажилтнууд	Зардал шаардагдахгүй	-	Уурхайн талбайд ажиллахаар анх удаа ирж буй ажиллагсад болон зочлод ажил эхлүүлэхээс өмнө сургалтыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулах	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.
Олдвор илэрсэн тохиолдолд орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, туслалцаа үзүүлэн хамтарч ажиллах		Төслийн талбайд	-	Үйл ажиллагааны зардал	2026 оны туршид олдвор илэрсэн тохиолдолд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 27.8

#### 4.9.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Эрдэнэ монгол” ХХК нь үндсэн болон гэрээт аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, олон улсын стандарт, конвенц, ил уурхайн аюулгүй байдлын дүрэмд зааснаар хангаж ажилладаг.

Бид зөвхөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-шаардлага, хэрэглэх заавар ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлээд зогсохгүй чанарын менежментийн тогтолцоо-шаардлага ISO 9001:2015, байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар ISO 14001:2015 стандартыг цогцоор нь 2027 оноос хэрэгжүүлж, Монгол улсын уул уурхайн компаниудын дунд үлгэр жишээ менежментийн тогтолцоог системтэйгээр бий болгож ажиллах зорилготой.

Хүдэр боловсруулах үйлдвэр ашиглалтад орсноор химийн бодисыг лаборатори, үйлдвэрлэлийн технологи, хяналтын лаборатори гэсэн үндсэн гурван хэсэгт химийн урвалж,

бодис ашиглана. Уусгалтад цианид натрийн зарцуулалт 1 тн хүдэрт 0.7 кг, адсорбцийн процесст идэвхжүүлсэн нүүрс ашиглах бөгөөд 1 тн хүдэрт 0.02 кг зарцуулах ба уусгалтын процессын орчныг шохой ашиглан рН-ийг 11 үед уусгалтыг гүйцэтгэнэ. Уусгалтын орчин тохируулагчаар СаО-ийн агуулга 90%-с дээш найрлагатай шохой ашиглах ба нийт зарцуулалт 1 тн хүдэрт 0.98 кг байна.

“Химийн бодис захиалгаар худалдах, худалдан авах тухай” ЕМС/25110/000 дугаартай гэрээг Цэцүүх трейд ХХК-тай 2025 оны 04 сарын 29-нд байгуулсан. Гэрээгээр химийн хорт болон аюултай бодис худалдаж авах, тэдгээрийг болон сав баглаа боодлыг тээвэрлэх, устгах харилцааг зохицуулсан.

**Хүснэгт 16. Осол эрдэлийн менежментийн төлөвлөгөө**

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Гал түймэр гарах	Галын идэвхитний бүлэгт тодотгол хийж, бүлгийн ажилтнуудыг сургалт дадлагад хамруулах	Төслийн талбай дахь барилга, байгууламжууд	-	2	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны 06, 10 дугаар саруудад	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4.
	Гал унтраах шуурхай төлөвлөгөөнд өөрчлөлт орсон хэсэгт нэмэлт тодотгол хийж дагаж мөрдөж ажиллах		Зардал шаардагдахгүй	1	-	2026 онд батлуулан, өдөр бүр мөрдөх	
	Бүх ажлын талбайд галын дохиолол, аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавих	Төслийн талбай дахь барилга, байгууламжууд	-	Бүх ажлын байранд	Үйл ажиллагааны зардлаас	Барилгыг ашиглалтад оруулахад байршуулсан байх бөгөөд хэвийн ажиллагааг улирал тутам шалгах	
Байгалийн гамшигт үзэгдэл	Гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийж батлуулж бэлэн байдлыг хангах	Төслийн талбай	Зардал шаардагдахгүй	1	-	2026 оны 05 сард багтаан батлуулах	Гамшигаас хамгаалах тухай хууль

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Химийн хортой болон аюултай бодисын хадгалалт	Химийн хортой болон аюултай бодисуудыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хадгалах, хадгалалтад хяналт тавих	Химийн бодисын агуулах	-	Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаас	2026 онд	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал
Химийн хортой болон аюултай бодисын ашиглалтаас сөрөг нөлөөлөл үзүүлэх	Хүдэр боловсруулах үйлдвэрт ашиглах зөөврийн болон суурийн хэмжигч багажуудыг баталгаажуулалтад бүрэн хамруулсан байх	Хүдэр боловсруулах үйлдвэр	-	Хэмжигч багажны тоогоор	14,000.0	2026 оны III улиралд	Хэмжил зүйн тухай хуулийн 2019.05.09 шинэчилсэн найруулга
	Хаягдал дахь химийн бодисын агуулгыг тогтмол хянах	Хүдэр боловсруулах үйлдвэр	-	12 удаа	Үйл ажиллагааны зардлаас	Сар бүр	“MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
Тэсэлгээний үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, чичирхийлэл	Тэсэлгээний ажлын аюултай бүсийг чөлөөлөх /хүн, техникийн аюултай бүсээс гаргах/	Тэсэлгээний ажил	Зардал шаардагдахгүй	Тэсэлгээний ажил хийгдэх бүрт	-	Тухай бүр	Засгийн газрын 2019 оны “Дүрэм батлах тухай” 313 тогтоол “Тэсэлгээний Ажлын Аюулгүй Ажиллагааны Нэгдсэн дүрэм”
	Тэсэлгээнээс үүсэх чичирхийлэлтийг хэмжих		-	Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Тэсрэх бодисыг буруу хадгалалтаас үүдэн гал гарах	Тэсрэх бодисыг зориулалтын агуулахад хадгалж, бодисын нөөц, хэрэглээг бүртгэх	Тэсрэх бодисын агуулах	Зардал шаардагдахгүй	8 удаа	-	Сар бүр	
Хүний эрүүл мэнд муудах	Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Анхан шатны тусламж үзүүлэх сургалт”-нд хамруулах шинэ ажилтны сургалтаар Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа	Үндсэн болон гэрээт ажилчид	-	Сургалт авсан ажилчдын тоо	Үйл ажиллагааны зардлаас	Уурхайн талбайд ажиллахаар анх удаа ирж буй ажиллагсдад ажил эхлүүлэхээс өмнө	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.
	Ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	2025 оны 06 сарын 01-ээс өмнө ажилд орсон ажилтнууд	-	Үзлэгт хамрагдсан ажилчдын тоо	Үйл ажиллагааны зардлаас	Хуваарийн дагуу	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг
	Хүний эрүүл мэнд муудахад анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бол хамгийн ойрын дараагийн шатны эмнэлэг рүү нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах	Төслийн хэмжээнд	-	Анхан шатны үзлэгээр дараагийн шатны эмнэлэгт үзүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны туршид	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг
	Химийн бодисын хордолгын үед яаралтай тусламж үзүүлэх сургалт байгуулах	Төслийн хэмжээнд	-	Шаардлагатай тохиолдолд	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны III улиралд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг мян. төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Тээврийн хэрэгслийн осол гарах	“Төслийн талбайд жолоодох эрх олгох” сургалт зохион байгуулах, шалгалтанд тэнцсэн ажилтанд жолоодох эрх олгох	Төслийн талбайд жолоодох эрхтэй жолооч	Зардал шаардагдахгүй	Төслийн талбайд жолоо барих эрх авсан ажилтны тоогоор	-	Батлагдсан хуваарийн дагуу 7 хоног бүрийн лхагва гарагт	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.

#### 4.10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Эрдэнэ Монгол ХХК нь холбогдох хууль дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг удирдлага зохицуулатын журмыг боловсруулан мөрдөн ажилладаг. Хог хаягдлыг дараах байдлаар ангилан цуглуулж, боломжит хог хаягдлыг зориулалтын цэгт устгах, уурхайн талбайгаас зохих газарт шилжүүлэх, дахин боловсруулалтанд илгээх зэрэг арга хэмжээг авч ажиллана.

Хог хаягдлын тухай хуулийн дагуу АХХ үүсгэгчийн дугаар (Ү-001587), Энгийн хог хаягдал үүсгэгчийн дугаар (Ү-000088) дугаар авсан бөгөөд холбогдох журмын дагуу тайланг хүргүүлдэг.

#### Хүснэгт 17. Хог хаягдлын ангилал, тэдгээрийг устгах аргууд

№	Хог хаягдлын төрөл	Устгах арга	Хаана
1.	Энгийн хог хаягдал	Гэрээний дагуу	Зориулалтын зууханд шатаах
2.	Үйлдвэрлэлийн болон ахуйн бохир ус	Байгальд нийлүүлэх хаягдал усны стандартад нийцүүлэн цэвэрлэх	Зам, талбайн усалгаанд хэрэглэх
3.	Хуванцар	Дахин боловсруултад шилжүүлэх	Хоёрдогч түүхий эд авах төвд нийлүүлэх
4.	Метал	Дахин ашиглалтад шилжүүлэх	Хоёрдогч түүхий эд авах төвд нийлүүлэх
5.	Хаягдал дугуй	Дахин ашиглалтад шилжүүлэх	Иргэдийн хүсэлтийн дагуу олгох, хоёрдогч түүхий эд авах төвд нийлүүлэх
6.	Химийн бодисын сав, баглаа боодол	Устгалд шилжүүлэх	Цэцүүх трейд ХХК
7.	Хаягдал тос	Дахин боловсруулалтад шилжүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан шилжүүлэх
8.	Ашигласан хаягдал батерей	Дахин боловсруулалтад шилжүүлэх	Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан шилжүүлэх
9.	Эмнэлэгийн хог хаягдал	Устгуулахаар шилжүүлэх	Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвд нийлүүлэх

“Эрдэнэ Монгол” ХХК нь “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хог хаягдал түр хадгалах цэгт хуримтлуулж байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2023 оны “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай” А/728 дугаар захирамжийн дагуу хог хаягдлыг булшлах, устгах үйл ажиллагааг явуулдаг. Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад **53.2 сая төгрөгийг** төсөвлөсөн. Эдгээрт:

1. Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ангилан ялгаж, хуулийн шаардлагад нийцсэн хогийн цэгт хадгалах;
2. Оффис, гэр, контейнер сууцуудад, гадна талбайн шаардлагатай байршлуудад хог ангилан хаях зориулалттай хогийн савыг байрлуулах;
3. Хогийн савнуудын битүүмжлэл, бүрэн бүтэн байдлыг хангах;
4. Хог хаягдлыг журмын дагуу, ангилан хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, ажлын байрны шалгалт тогтмол явуулах, ажилчдад заавар зөвлөмж өгөх;
5. Тогтмол давтамжтайгаар цугларсан хогийг зориулалтын байгууламжид шатааж устгах
6. Хогийг эх үүсвэр дээр нь ангилан, ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлыг эргүүлэн ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлэх;
7. Орон нутагт жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор хог хаягдлыг тээвэрлэх, устгах зэрэг ажлуудыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гэрээлэн гүйцэтгүүлэх;
8. Бүрэн цэвэрлээгүй шатах тослох материалын болон химийн бодисын сав баглаа боодлыг аюултай хог хаягдал гэж үзэх тул “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ыг мөрдөх.

**Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

Хог хаягдлын ангилал	Хаягдлын эх үүсвэр	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян. төгрөг	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ахуйн гаралтай хатуу хог хаягдал	Уурхайн тосгон, оффис, барилга байгууламж	Хог хаягдал шатаах зориулалтын зууханд энгийн хог хаягдлыг шатаах	Хог хаягдлын цэг	ш	2	Зардал шаардагдахгүй	-	Жилийн туршид Гурав хоногт 1 удаа	Хог хаягдлын тухай хууль 2017 он
		Хог хаягдлыг ангилан, зөвшөөрөгдсөн цэгт хадгалах	Хог хаягдлын цэг	кг	Гаргасан хог хаягдлын хэмжээгээр	-	-	Үйл ажиллагааны туршид	Хог хаягдлын тухай хууль 2017 он
		Хоолны хог хаягдлыг зориулалтын талбайд булшлах	Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж	удаа	24	-	-	Жилийн туршид сард 2 удаа	Хог хаягдлын тухай хууль 2017 он
		Төслийн талбайн нийтийн цэвэрлэгээг Ням гараг бүр зохион байгуулах	Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж	Удаа	52	Зардал шаардагдахгүй	-	Долоо хоногт 1 удаа	Хог хаягдлын тухай хууль 2017 он
Ахуйн гаралтай шингэн хог хаягдал	Уурхайн тосгон, оффис	Хог хаягдлын ангилах, ашиглах сургалт	Төслийн бүх ажилтан	Удаа	4	-	2,000.0	Жилийн туршид улиралд 1 удаа	Усны тухай хууль 2012 он

Хог хаягдлын ангилал	Хаягдлын эх үүсвэр	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян. төгрөг	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Аюултай хог хаягдал	Яаралтай тусламжийн нэгж	Эмнэлгийн хог хаягдлыг зааврын дагуу хадгалан, Шинэжинст сумын эмнэлэгт нийлүүлэх	Яаралтай тусламжийн нэгж	удаа	12	468.0	6,000.0	Жилийн туршид сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/505 тушаал, Шинэжинст сумын Хүн эмнэлэгтэй байгуулсан хог хаягдал нийлүүлэх гэрээ 2024
	Машин механизмын засварын цэг барьж, ашиглалтад орсны дараа	Шингэн тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалан, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Засварын газар	м <sup>3</sup>	Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	-	5,000.0	Жилийн туршид	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг 23-р зүйл
		Тосоор бохирдсон арчих материал зэрэг аюултай хог хаягдлыг зориулалтын цэгт хадгалах, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид нийлүүлэх	Засварын газар	кг	Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	-	5,000.0	Жилийн туршид	Хог хаягдлын тухай хууль 2017.

Хог хаягдлын ангилал	Хаягдлын эх үүсвэр	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян. төгрөг	Нийт зардал, мян. төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	Химийн бодисын агуулах, хүдэр боловсруулах үйлдвэр	Химийн бодисын сав баглаа аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, устгуулах	Химийн бодисын агуулах	Удаа	Нийлүүлсэн хог хаягдлын хэмжээгээр	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль 2017.
Талбайн Хяналт	Үзлэг шалгалт	Хог хаягдал ангилан цуглуулах талбайд үзлэг шалгалт хийж, засч залруулах арга хэмжээ авах (орчныг цэвэрлэх, дахин ялгах гэх мэт)	Төслийн талбай	Удаа	26	Зардал шаардагдахгүй	-	2026 оны туршид сард 2 удаа	“ОНСЕ.ЕМ.604 Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журам”
Мэдээллийн сан бүрдүүлэлт		Ялгаруулж байгаа хог хаягдлыг өдөр бүр ангилан бүртгэх	Катеринг туслан гүйцэтгэгч	кг	Гаргасан хог хаягдлын хэмжээгээр	Зардал шаардагдахгүй	-	Өдөр бүр	Хог хаягдлын тухай хууль 2017. 11 дүгээр зүйл,

#### 4.11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.4, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.7 заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад “Эрдэнэ Монгол” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

Баянхөндий төслийн 2026 онд хэрэгжүүлэх ОХШХ-ийг хэрэгжүүлэхэд **20,5 сая төгрөг** зарцуулахаар төлөвлөв.

### Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян. төгрөг	Нийт зардал мян. төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
<b>Газрын гадарга, хэвлий</b>							
Хөрсний чанар - Хими, физикийн үзүүлэлтүүдийг шинжлүүлэх	6 цэг	03, 09 саруудад	2	150.0	1,800.0	Итгэмжлэгдсэн лабораториар шинжлүүлэх	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам MNS 2305:1994
Хөрсний чанар нефьт бүтээгдэхүүний үзүүлэлт шинжлүүлэх	ШТС-ын орчим 1 цэг	05, 09 дугаар саруудад	2	200.0	400.0		
Тогтсон цэгүүдээс хөрсний хүнд металын шинжилгээ хийлгэх	6 цэг	03, 09 саруудад	2	200.0	2,400.0		
Хаягдлын нэгдсэн сангийн хаягдал кекнээс нийт цианид, чөлөөт цианид болон сул хүчилд уусдаг (WAD) цианидын шинжилгээ хийлгэх	1 цэг	Сар бүр	12	200	2,400.0		
<b>Уур амьсгал</b>							
Цаг уур (агаарын хэм, салхины хурд, харьцангуй чийгшил)	Төслийн талбайд	Өдөр бүр	1	Зардал шаардагдахгүй	-	<a href="http://www.windy.com">www.windy.com</a>	Цаг уур, орчны хяналт шинжилгээний заавар ШЗ.П.01.03.2014 (Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар XIV дэвтэр. Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур орчны шинжилгээний газар)
Шатахууны хэрэглээг бүртгэх	Тээврийн хэрэгсэл, цахилгаан эх үүсгүүрүүд	Сар бүрийн сүүлийн өдөр	12	Зардал шаардагдахгүй	-	ШТС	MNS ISO 14064-1-2015. Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингэлтийг тооцоолох, тайлагнах
Нүүрсний хэрэглээг бүртгэх	Түр кэмп, халаалтын зуух	Сар бүрийн сүүлийн өдөр	12	Зардал шаардагдахгүй	-	Кемп, уурхай	

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян. төгрөг	Нийт зардал мян. төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
							тухай зааварчилсан удирдамж
<b>Агаарын чанарын хяналт</b>							
Зөөврийн багажаар: Агаар дахь том болон жижиг ширхэглэгт тоосонцор	7 цэг	Сар бүрийн 10-аас 17	12	Зардал шаардагдахгүй	-	Tsi dusttrak drx 8533багаж хэрэглэх	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Нөлөөллийн бүсэд айл өвөлжих тохиолдолд айлын ойр орчимд дуу шуугиан, агаар дахь тоосонцорыг хэмжих	Айлын өвөлжөөний орчим	Айл өвөлжсөн тохиолдолд	3	-	-	Tsi dusttrak drx 8533багаж хэрэглэх	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаарын чанарын шинжилгээг хийлгэх	Тусгай зөвшөөрлийн талбайн зүүн урд зах	06, 11 саруудад	2	-	Үйл ажиллагааны зардлаас	Итгэмжлэгдсэн лабораториор хийлгэх	
<b>Газрын доорх ус</b>							
Тусгай зөвшөөрлийн талбайн 20 км радиус доторх малчдын худгуудад усны түвшний хэмжилт	Сонгосон худгууд	Тэгш тоотой сар бүрийн 28 – 30-ны өдрүүдэд	6	-	1,000.0	Нутгийн иргэдтэй хамтран	Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/561 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт
Ус хангамжийн худгуудад усны чанарын шинжилгээ хийлгэх	BKW -48, BKW-54, NCW-01	Улиралд 1 удаа 03, 06, 09, 12 саруудад	4	-	Үйл ажиллагааны зардлаас	Итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюудгүй байдлын үнэлгээ
Хаягдал усанд шинжилгээ хийлгэх	Кэмп, үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламж	Улиралд 1 удаа 03, 06, 09, 12 саруудад	4	-	Үйл ажиллагааны зардлаас	Итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх	MNS 4943:201 Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян. төгрөг	Нийт зардал мян. төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
Хаягдлын нэгдсэн сангийн мониторингийн цооногийн усны түвшиний хэмжилтийг хийх	ВН1, ВН2, ВН3, ВН4, ВН5, ВН6, ВН7	Сар бүрийн 28-аас 30-ны хооронд	12	-	Үйл ажиллагааны зардлаас	Мониторингийг хэрэгжүүлэх	Усны тухай хууль
Хаягдлын нэгдсэн байгууламжийн 7 мониторингийн цооногийн нийт цианид, чөлөөт цианид болон сул хүчилд уусдаг (WAD) цианидын шинжилгээ хийлгэх		Улиралд 1 удаа 03, 06, 09, 12 саруудад	4	-	Үйл ажиллагааны зардлаас	Улирал бүрийн сүүлийн сарын 15-аас хойш	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюудгүй байдлын үнэлгээ
<b>Ургамлан нөмрөг</b>							
10 x 10 м талбай дахь ургамлын зүйлийн бүрдэл, ургамлын тусгаг бүрхэцийг үнэлэх	БОННУ-нд заагдсан 9 цэгт	2026 оны 3 улиралд	1 удаа	1,000.0	1,000.0	Ургалтын хугацаанд	Тухайн бүлгэмдэлд ургаж буй ургамлын зүйлийн баялагийг тодорхойлох; Ургамлын зүйлүүдийн (элбэгшил-abundance) арвийг Drude’s scale-ээр үнэлэх; 10x10 м талбайн ургамал, хагд, халцгай газар гэх мэт газрын бүрхэцийг Браун-Бланке-ийн аргаар нүдэн баримжаагаар үнэлэх; 1x1 м талбай байгуулан ургамлын бүрхэцийг (Раменский, 1938) үнэлэх; 2019 оны ургамлан нөмрөгийн хээрийн судалгааны үр дүн
<b>Амьтны аймаг</b>							

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал мян. төгрөг	Нийт зардал мян. төгрөг	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
Сээр нуруутан амьтны бүртгэл хөтлөх	Тусгай зөвшөөрлийн талбайд	2026 оны туршид	Амьтан ажиглагдах тохиолдол бүрт	Зардал шаардагдахгүй	Үйл ажиллагааны зардлаас	Төслийн талбайд тохиолдох мөлхөгч, шувуу, хөхтний зүйлийн бүрдэл, тохиолдсон бодгалийн тоо	Баянхөндий төслийн БОННУ, БОМТ 2026-2030
Жороо тоодог (Chlamydotis undulata) бүртгэгдсэн цэгийн орчимд ажиглалт хийх	БОННУ-д заасан цэгүүдэд	05, 09 дүгээр саруудад	2	500.0	1,000.0	2019 оны хээрийн судалгаагаар 1 бодгаль тохиолдсон.	Монгол орны шувууны Улаанданс, 2011 болон шувуу судлаачдын судалгааны бүтээл
<b>Хамтын оролцоотой мониторинг</b>							
Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх	Тусгай зөвшөөрлийн талбайн 20 км радиус доторх худгууд	Жилийн туршид улиралд 1 удаа	4	480.0	960.0	Хамтын оролцоотой мониторингийг хэрэгжүүлэх	Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/561 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт
<b>Хөндлөнгийн байгууллагаар Орчны хяналт шинжилгээ хийлгэх</b>							
ОХШ хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Тусгай зөвшөөрлийн талбай	1	-	-	9,540.0	ОХШ -г мэргэжлийн байгууллагаар хийлгэх	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд,

#### 4.12. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Байгаль орчны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүхий л бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлж байгаа болзошгүй сөрөг нөлөөллүүдийг үе шаттайгаар хянах, гол нөлөөллүүдийг бууруулах, үйл ажиллагаагаа тогтмол сайжруулах, хууль эрх зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлэхийг зорин ажиллана.

#### Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв мян. төгрөг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан
Шаардлагатай тохиолдолд компанийн байгаль орчны журмуудад зохих шинэчлэл, өөрчлөлт оруулах	Зардал шаардагдахгүй	2026 он, шаардлагатай тохиолдолд	Компанийн удирдлага, БО-ны хэсэг, Нийцлийн нэгж
Хүлэмжийн хийн тооллого хийх зөвлөн туслах үйлчилгээ авах	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны 05 – 07 сард	Компанийн удирдлага, БО-ны хэсэг, Нийцлийн нэгж
“Сайжруулалтын сар” уралдаан зарлах	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны 04, 09 саруудад	Салбарын захиргааны алба
Бүтэц орон тоог нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны зардлаас	2026 оны II улиралд	Салбарын захиргааны алба
Ажилтнуудыг НБХХ-ээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаас	Төслийн нийт хугацаанд	Компанийн удирдлага, ХАБЭА-н хэсэг
Үрсэлгээ бэлтгэх хугацаанд 10 иргэнийг түр гэрээгээр ажиллуулах	Үйл ажиллагааны зардлаас	2026.04.15 – 2026.05.15	Салбарын захиргааны алба, хүний нөөцийн хэсэг

#### 4.13. БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэ Монгол” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулж Баянхонгор аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэх ба мэдээллийн санд цахимаар байршуулна. Баянхонгор аймгийн Байгаль орчны газраас төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлт гармагц Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлж, хянуулна. Мөн төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хурал эсвэл нөлөөллийн бүсийн иргэдийн төлөөлөлд БОМТ-ний тайланг батлагдсны дараа танилцуулна.

**Хүснэгт 21. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь**

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацаа	Тайлагнах зардал, мян. төгрөг	Хариуцах эзэн	Зохион байгуулах газар
БОМТ-г олон нийтэд нээлттэй байлгах	Компанийн вэб сайт www.erdene.com -д батлагдсан менежментийн төлөвлөгөөг байршуулах	БОМТ	Төлөвлөгөө батлагдмагц	-	Төв оффис	www.erdene.mn вэбсайт
Баянхонгор аймгийн Байгаль орчны газар	Тайланг хүргүүлэх	Байгаль орчныг хамгаалах талар хэрэгжүүлсэн ажил	Улирал тутам	Зардал шаардагдахгүй	Байгаль орчны хэсэг	Баянхонгор аймгийн БОГазар
Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр арга хэмжээ зохион байгуулах	Танилцуулга, илтгэл бэлтгэж, орон нутгийн иргэдэд танилцуулах	БОМТ-ний хэрэгжилт эсвэл усны түвшний хэмжилтийн үр дүн	1 удаа	Зардал шаардагдахгүй	Байгаль орчны хэсэг, Орон нутгийн харилцааны хэсэг	Талбайд нутгийн иргэд ирэх эсвэл нутгийн захиргааны байгууллагаас хүсэлт уламжилсан тохиолдолд

---oOo---

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. CITES-ийн хавсралтад бүртгэгдсэн амьтан, ургамлын зүйлийг таних бичиг. 2004. Улаанбаатар хот, Монгол улс.
2. E. L. Clark., Ж. Мөнхбат., Е.М. Monks., С. Дуламцэрэн., J.E.M. Baillie., Н. Батсайхан., Л.Я. Боркин., Р. Самъяа., М. Stubbe (Эмхэтгэгчид, редакторууд) 2006. *Монгол орны хөхтөн амьтны улаан данс*. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
3. Gombobaatar S. And Monks E. M. (compilers), Seidler R., Sumiya D., Tseveenmyadag N., Bayarkhuu S., Baillie J. E. M., Boldbaatar Sh., Uuganbayar Ch., (editors) 2011. *Regional Red List Series Vol.7. Birds*. Zoological Society of London, National University of Mongolia and Ornithological Society.
4. Gombobaatar, S. 2009. A Dictionary of Vertebrate Animals of Mongolia. Admon print. Ulaanbaatar.
5. Terbish., Н. Munkhbayar., Н. Munkhbaatar., М. 2013. A Guide to the Amphibians and Reptiles of Mongolia (*Second Edition*). Admon print. Ulaanbaatar city, Mongolia.
6. Бадамханд, Ж. 2011. Монгол орны агнуурын амьтдын лавлагаа. Хүст хэвлэл. Улаанбаатар хот, Монгол улс.
7. Батсайхан, Н., Самъяа, Р., Шар, С., Кинг, С.Р.Б. 2010. Монгол орны хөхтөн амьтад таних гарын авлага. Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
8. Болдбаатар, Ш. 2008. Монгол орны шувууны фото лавлах (125 зүйл). Улаанбаатар хот, Монгол улс.
9. Болормаа нар., 2011. Монгол орны гуурст дээд ургамлын хураангуйлсан нэрийн жагсаалт. Сэлэнгэпресс ХХК-ийн хэвлэх үйлдвэр. Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо. Улаанбаатар хот.
10. Лхагвасүрэн, Б., нар. 2012. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS)-ын үндэсний тайлан. Улаанбаатар хот, Монгол улс.
11. Мөнхбаяр, Х., Тэрбиш, Х., Мөнхбаатар, М. 2009. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчид. Улаанбаатар хот, Монгол улс.
12. Нямбаяр, Д., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р. (эмхэтгэгчид), Ц. Жамсран, Ч. Санчир, С. Бахман, Н. Сонинхишиг, С. Гомбобаатар, Ж.Е.М. Баиллие, Ц. Цэндээхүү (редакторууд) (2012). Монголын ургамлын Улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 10. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль.
13. БОАЖ Сайдын 2020 оны А/59 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлал”
14. Х. Тэрбиш., Х. Мөнхбаяр., E. L. Clark., Ж. Мөнхбат., Е.М. Monks., М. Мөнхбаатар., J.E.M. Baillie., Н. Батсайхан., Л.Я. Боркин., Р. Самъяа., Д.В. Семенов. (Эмхэтгэгчид, редакторууд) 2006. Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
15. Шийрэвдамба, Ц. (ерөнхий ред). 2013. Монгол улсын улаан ном. Улаанбаатар хот, Монгол улс
16. “Эко трейд” ХХК. 2021. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ. Улаанбаатар хот, Монгол улс

Хавсралтын жагсаалт

№	Хавсралтын нэр	Нүүрний тоо
1.	Улсын бүртгэлийн гэрчилгээ	2
2.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	3
3.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудас	9
4.	АМГТГ-ын даргын 2025 оны Т/56 тушаал	1
5.	2025 оны БОМТ-ний биелэлтийг хүлээж авах дүгнэх хуудас	5
6.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нүүр	1



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ  
СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭРДЭНЭ  
МОНГОЛ” ХХК-ИЙН МУ-021444 ТООТ  
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ  
БАЯНХӨНДИЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ  
АШИГЛАХ ТӨСӨЛ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ  
АУДИТЫН ТАЙЛАН - 2024**

**Улаанбаатар хот  
2024 он**



**“НОГООН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” ХХК**  
Байгаль орчны аудит, байгаль  
орчны менежментийн зөвлөх  
үйлчилгээ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ  
ОРШИХ “ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН MV-021444 ТООТ  
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “БАЯНХӨНДИЙН  
АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ АШИГЛАХ ТӨСӨЛ”-ИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН ТАЙЛАН – 2024 ОН**

**ГҮЙЦЭТГЭСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:**

“НОГООН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ АУДИТОР

Д.БАТБОЛД

УЛААНБААТАР ХОТ  
2024 ОН

## АГУУЛГА

### ОРШИЛ

#### 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЛИЙН БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

- 1.1. Удиртгал
- 1.2. Аудитын зорилго
- 1.3. Аудитын үйлчлүүлэгч
- 1.4. Аудитын аргазүй
- 1.5. Аудит хийлгэгч ба түүний оролцоо
- 1.6. Аудитын төрөл
- 1.7. Байршил ба хугацаа
- 1.8. Аудитын хамрах хүрээ
- 1.9. Аудитад хамрагдаагүй хэсэг
- 1.10. Аудитын шалгуур
- 1.11. Баталгаажсан нотолгоо
- 1.12. Аудитын үнэлэмж
- 1.13. Санал зөрөлдөөн, саад бэрхшээл, тодорхой бус байдал
- 1.14. Аудитын ерөнхий дүгнэлт
- 1.15. Ерөнхий зөвлөмж
- 1.16. Эргэн шалгалтын төлөвлөгөө
- 1.17. Аудитын нууцлал
- 1.18. Тайлан түгээлт

#### 2. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил
- 2.2. Ордын нөөц
- 2.3. Ашиглалтад хамаарах хүдрийн нөөц
- 2.4. Төслийн хүчин чадал, хэрэгжих хугацаа
- 2.5. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт

#### 3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГҮЙЦЭТГЭЛ, АУДИТЫН ҮР ДҮН

- 3.1. ХУУЛИЙН НИЙЦЭЛ
- 3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, МОНИТОРИНГИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, БИЕЛЭЛТ
  - 3.2.1. УСАН ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ
  - 3.2.2. АГААР ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ
  - 3.2.3. ХӨРСӨН БҮРХЭВЧ БА ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ
  - 3.2.4. УРГАМЛАН НӨМРӨГ БА БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ
  - 3.2.5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТ
  - 3.2.6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ
    - 3.2.6.1. АХУЙН ХОГ ХАЯГДАЛ
    - 3.2.6.1. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ
  5. АУДИТЫН НЭГДСЭН ДҮГНЭЛТ
  6. ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ
  7. АУДИТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
  8. АУДИТЫН ТАЙЛАНГ ТАРААХ
  9. АУДИТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ
- АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

## ОРШИЛ

“Ногоон гэрэлт ирээдүй” ХХК болон “Эрдэнэ Монгол” ХХК-ийн хооронд 2024 оны 5-р сарын 15-ны өдөр байгуулсан EMC/29074/00 тоот “Байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших “Эрдэнэ Монгол” ХХК-ийн MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл”-ийн үйл ажиллагаанд нийцлийн болон гүйцэтгэлийн аудитыг “Ногоон гэрэлт ирээдүй” ХХК-ийн Байгаль орчны аудитын баг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн 10<sup>1</sup> зүйлийн дагуу, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар 25-ны өдрийн А/809 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал” болон компанийн өөрийн боловсруулсан нарийвчилсан арга зүйг мөрдлөг болгон ажиллав.

Аудитын үр дүнг үнэлэхдээ нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай болон хугацаа болоогүй гэсэн 4 үнэлэмжийг ашигласан. Аливаа нотолгоогоор гүйцэтгэл нь батлагдсан тохиолдолд нийцэл, батлагдаагүй тохиолдолд үл нийцэл, хууль эрх зүйн хүрээнд болон гүйцэтгэлийн шатанд үр дүн нь тодорхойлогдох болоогүй эсвэл тухайн шалгуур бодит шалтгааны улмаас гүйцэтгэл нь түр хойшлогдсон тохиолдолд хугацаа болоогүй гэсэн үнэлэмжид хамааруулав.

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг үндсэн 8 чиглэлд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Хуулийн нийцэл;
2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, мониторингийн ажлын гүйцэтгэл;
  - 2.1. Усан орчны менежмент;
  - 2.2. Агаар орчны менежмент;
  - 2.3. Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент;
  - 2.4. Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент;
  - 2.5. Биологийн олон янз байдлын менежмент;
  - 2.6. Хог хаягдлын менежмент;
    - 2.6.1. Ахуйн хог хаягдал
    - 2.6.2. Аюултай хог хаягдал зэрэг болно.

## 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЛИЙН БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

### 1.1. Удиртгал

"Ногоон гэрэлт ирээдүй" ХХК болон "Эрдэнэ Монгол" ХХК-ийн хооронд 2024 оны 5-р сарын 15-ны өдөр байгуулсан EMC/29074/00 тоот "Байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажил гүйцэтгэх гэрээ"-ний дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших "Эрдэнэ Монгол" ХХК-ийн MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл"-ийн үйл ажиллагаанд нийцлийн болон гүйцэтгэлийн аудитыг "Ногоон гэрэлт ирээдүй" ХХК-ийн Байгаль орчны аудитын баг Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 10<sup>1</sup> зүйлийн дагуу, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар 25-ны өдрийн А/809 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал" болон компанийн өөрийн боловсруулсан нарийвчилсан арга зүйг мөрдлөг болгон ажиллав.

Аудитын үр дүнг үнэлэхдээ нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай болон хугацаа болоогүй гэсэн 4 үнэлэмжийг ашигласан. Аливаа нотолгоогоор гүйцэтгэл нь батлагдсан тохиолдолд нийцэл, батлагдаагүй тохиолдолд үл нийцэл, хууль эрх зүйн хүрээнд болон гүйцэтгэлийн шатанд үр дүн нь тодорхойлогдох болоогүй эсвэл тухайн шалгуур бодит шалтгааны улмаас гүйцэтгэл нь түр хойшлогдсон тохиолдолд хугацаа болоогүй гэсэн үнэлэмжид хамааруулав.

### 1.2. Аудитын зорилго

"Эрдэнэ Монгол" ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл"-ийн Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийгдсэнээр байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад туслах, тэднийг учирч болох алдагдал, хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөхөд аудитын зорилго оршино. Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг үндсэн 8 чиглэлд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Хуулийн нийцэл;
2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, мониторингийн ажлын гүйцэтгэл
  - 2.1. Усан орчны менежмент;
  - 2.2. Агаар орчны менежмент;
  - 2.3. Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент;
  - 2.4. Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент;
  - 2.5. Биологийн олон янз байдлын менежмент;
  - 2.6. Хог хаягдлын менежмент;
    - 2.6.1. Ахуйн хог хаягдал
    - 2.6.2. Аюултай хог хаягдал зэрэг болно.

Дээрх чиглэлүүдэд байгаль орчны аудит хийж, дүгнэлт гаргахын зэрэгцээ үл нийцсэн шалгуурт мэргэжлийн зөвлөмж боловсруулах зорилготой ажиллав.

### 1.3. Аудитын үйлчлүүлэгч

"Эрдэнэ Монгол" ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл

### 1.4. Аудитын аргазүй

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг гүйцэтгэхдээ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/809 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны аудит хийх аргачлал"-ыг удирдлага болгон ашигласнаас гадна гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, үйл ажиллагааны тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглалаа.

### 1.5. Аудит хийлгэгч ба түүний оролцоо

Аудитын үйлчлүүлэгч ба хийлгэгч нь нэг хуулийн этгээд бөгөөд түүний оролцоо нь:

- ❖ Холбогдох бичиг баримттай танилцуулах
- ❖ Газар дээрх аудитын үед хөтөч хийх
- ❖ Үл нийцлийг зөвшилцөх
- ❖ Амлалтын хугацааг хэлэлцэх
- ❖ Аудитын үл нийцлийн биелэлтийг өөрсдийн дотоод хяналтаар гүйцэтгэх
- ❖ Тайлан түгээх зэргээр хязгаарлагдсан болно.

### 1.6. Аудитын төрөл

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг үндсэн 2 чиглэлээр гүйцэтгэсэн. Үүнд:

1. Байгаль орчны нийцлийн аудит
2. Байгаль орчны гүйцэтгэлийн аудит зэрэг болно.

### 1.7. Байршил ба хугацаа

Төсөл хэрэгжиж буй газар буюу "Эрдэнэ Монгол" ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл"-ийн үйл ажиллагаа хамрагдав.

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг дараах үе шат, хуваарийн дагуу гүйцэтгэв. Үүнд:

**I үе шат:** Аудитын төлөвлөлт буюу бэлтгэл ажил: 2024.05.15 – 2024.05.25 хүртэл;

1. Аудитын зорилго ба хамрах хүрээг тодорхойлох
2. Аудитын шалгууруудыг олж тогтоох
3. Аудитын асуулга авах чиглэлийг тодорхойлох
4. Аудитын дэлгэрэнгүй төлөвлөгөө, хөтөлбөрийг бэлтгэх

**II үе шат:** Аудитын хэрэгжилт буюу хээрийн судалгааны ажил 2024.05.25 - 2024.05.30 хүртэл;

1. Аудитын нотлох зүйл олж авах
2. Аудитын нотлох зүйлийг баримтжуулах
3. Аудитын нотлох зүйлд дүн шинжилгээ хийх
4. Аудитын дүгнэлт гаргахад бэлтгэх

**III үе шат:** Аудитын тайлан боловсруулах - 2024.05.30-2024.06.01 хүртэл;

1. Аудитын урьдчилсан дүгнэлтийг гаргах
2. Захиалагч, үйлчлүүлэгчийн удирдлагатай санал солилцох
3. Аудитын тайлангийн эцсийн хувилбарыг бэлтгэх
4. Аудитын бэлэн болсон эцсийн тайланг бусдад тараах

**IV үе шат:** Аудит хийлгэгчид аудитын үр дүнг танилцуулах, санал авах, эцсийн тайланг хүлээлгэн өгөх зэрэг болно.

### 1.8. Аудитын хамрах хүрээ

Цаг хугацааны хувьд:	Нийт 45 хоног
Орон зайн хувьд:	Уурхайн барилгын ажлын үе шат
Бичиг баримтын хувьд:	Үйлчлүүлэгч байгууллагаас хангасан бичиг баримтуудын хүрээнд ажилласан. Гуравдагч этгээдээс бичиг баримт аваагүй, аудитын шалгуурт тооцоогүй.
Объектын хувьд:	Уурхай, баяжуулах үйлдвэр бүхэлдээ /барилгын ажлын үе шат/
Хууль тогтоомжийн хүрээнд:	Монгол Улсын хууль тогтоомж болон стандартыг аудитын шалгуур тогтооход ашигласан. Байгаль орчны багц хуулиудын томоохон өөрчлөлтүүд 2012 оны 5 дугаар сард орж, 2012 оны 6 дугаар сараас хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аудитын үйл ажиллагааны хууль тогтоомжийн хүчин төгөлдөржилтийн цаг хугацааны хамрагдалт нь 2012 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаагаар хязгаарлахаар тохиролцсон. Энэ удаагийн Байгаль орчны төлөвлөгөөт аудит нь 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгохгүй. Гэхдээ аудит хийлгэгч байгууллагын аливаа үйл ажиллагааг тухайн үед хүчин төгөлдөр байсан хууль тогтоомжтой харьцуулах ба үйл ажиллагааг хийснээс хойш бий болсон хууль тогтоомжийн шалгууртай харьцуулж үнэлэмжийг гаргаагүй болно.
Хуулийн этгээдийн хүрээнд:	Зөвхөн үйлчлүүлэгч байгууллагын хүрээнд хийгдэх ба туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгээгүй. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгч байгууллагад аливаа бараа материал нийлүүлдэг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагаа хамаарахгүй ба тухайн байгууллагын

үйлчлүүлэгчид нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээ, бичиг баримтын бүрдэл, нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний тайлан гэх мэтийг үзээгүй. Дээрх зүйлст аливаа үл нийцэл илэрвэл түүнийг цаашлуулан гэрээлэгч байгууллагад аудит хийгээгүй тул зөвхөн үл нийцлийг тайландаа тусгаж, түүнд аудит хийлгэхийг зөвлөмж хэлбэрээр оруулж болно.

### 1.9. Аудитад хамрагдаагүй хэсэг

Тус аудитад дараах зүйлс хамрагдаагүй. Үүнд:

Цаг хугацааны хувьд:	Газар дээрх аудит хийснээс хойш хугацаанд болсон аливаа үйл ажиллагаа
Орон зайн хувьд:	Ил уурхай, баяжуулах үйлдвэрийн барилгын ажлын үе шатаас өөр газарт болсон аливаа үйл ажиллагаа
Бичиг баримтын хувьд:	Гуравдагч этгээдээс бичиг баримт аваагүй, аудитын шалгуурт тооцоогүй.
Объектын хувьд:	Ил уурхай, баяжуулах үйлдвэрийн болон туслах үйл ажиллагаанд хамааралгүй аливаа объект
Хууль тогтоомжийн хувьд:	2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгоогүй.
Хуулийн этгээдийн хүрээнд:	Үйлчлүүлэгчээс бусад этгээд хамаарахгүй, мөн үйлчлүүлэгчийн туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгээгүй.

### 1.10. Аудитын шалгуур

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг гүйцэтгэхэд ашигласан үндсэн шалгуур үзүүлэлтүүдэд төслийн техник эдийн засгийн үндэслэл, шийдвэр, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт, өмнө нь гүйцэтгэсэн байгаль орчны аудитын тайлан болон хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, норм, норматив, эрхийн актууд, зөвшөөрөл, гэрээ, дүгнэлтэд үндэслэсэн болно.

Байгаль орчны төлөвлөгөөт аудитын хүрээнд нийт 631 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны аудитыг гүйцэтгэв. Эдгээрээс 160 нь хамааралгүй, 185 нь хуулийн нийцэл, 21 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, 335 нь үндэсний хууль тогтоомж, 165 нь холбогдох дүрэм журам, аргачлал, 57 нь стандартад, 53 нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчны мониторингийн гүйцэтгэлийн хувьд давхардсан байдлаар тусгалаа олсон болно.

Хүснэгт 1. Байгаль орчны аудитын шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хуулийн нийцэл	Усан орчин	Агаар орчин	Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлт	Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлт	Биологийн олон янз байдал	Ахуйн хог хаягдал	Аюултай хог хаягдал	Нийт дүн
1.	Төрийн бодлого, үндэсний хөтөлбөр	0	9	2	1	2	1	4	2	<b>21</b>
2.	Үндэсний хууль тогтоомж	185	27	12	9	10	8	40	44	<b>335</b>
3.	Дүрэм, журам, аргачлал	0	59	7	7	9	6	32	45	<b>165</b>
4.	Стандарт	0	12	13	9	2	8	7	6	<b>57</b>
5.	БОННУ болон БОМТ	0	9	6	11	7	7	9	4	<b>53</b>
<b>Нийт дүн</b>		<b>185</b>	<b>116</b>	<b>40</b>	<b>37</b>	<b>30</b>	<b>30</b>	<b>92</b>	<b>101</b>	<b>631</b>
<b>Үүнээс:</b>										
Нийцэл		171	94	19	22	13	16	57	70	<b>462</b>
Сайжруулах шаардлагатай		2	1	0	1	1	0	1	1	<b>7</b>
Үл нийцэл		0	0	0	0	0	0	1	1	<b>2</b>
Хамааралгүй		12	21	21	14	16	14	33	29	<b>160</b>

**1.11. Баталгаажсан нотолгоо**

Аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан бичиг баримтыг үндэслэл болгон газар дээрх аудит, аудитын явцад албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, үйл ажиллагааны тайлантай танилцах, судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр нотолгоог цуглуулсан болно.

**1.12. Аудитын үнэлэмж**

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан. Нийт нийцлийн болон гүйцэтгэлийн 631 шалгуурыг цуглуулсан нотолгоонууд дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Шалгуур үзүүлэлтийн хувийг тооцохдоо хамааралгүй гэсэн үзүүлэлтийг хасаж тооцсон болно.

Аудитын үр дүнгийн үнэлэмжийн бүртгэл:

- ❖ Нийцэл 462
- ❖ Сайжруулах шаардлагатай 7
- ❖ Хугацаа болоогүй 0
- ❖ Үл нийцэл 2
- ❖ Хамааралгүй 0

Үнэлэмжийн бүтцийг дараах графикт үзүүлэв.



График 1. Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын үнэлэмжийн бүтэц

### 1.13. Санал зөрөлдөөн, саад бэрхшээл, тодорхой бус байдал

Байгаль орчны аудитын үед ямар нэгэн санал зөрөлдөөн, саад бэрхшээл, тодорхой бус байдал үүсээгүй.

### 1.14. Аудитын ерөнхий дүгнэлт

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл”-ийн Байгаль орчны төлөвлөгөөт аудит гүйцэтгэсэн үр дүнг үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэлээс үзэхэд нийт 431 асуулгын 462 (98.1%) асуулгад хангалттай буюу хэрэгжилт маш сайн гэсэн үнэлгээ авсан бол нийт 7 (1.5%) асуулгад сайжруулах шаардлагатай, 2 (0.4%) асуулгад үл нийцэл, харин 160 асуулгад хамааралгүй гэсэн үнэлэмжийг авсан бол тодорхойгүй буюу үнэлэх боломжгүй асуудал гараагүй байна. Байгаль орчны аудитын үр дүн 98.1%-тай байгаагаас дүгнэхэд уурхайн, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хуулийн нийцэл болон гүйцэтгэлийн үр дүн **“Маш сайн”** байгааг харуулж байна.
2. “Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл”-ийн байгаль орчны үйл ажиллагааны 98.1% нь үндэсний хууль тогтоомжид нийцтэй буюу гүйцэтгэлтэй байна. Хугацаа болоогүй буюу тухайн шалгуурыг гүйцэтгэх цаг хугацаа болоогүй байгаа тул тэдгээрийг шууд үл нийцэл гэж ойлгохгүй бөгөөд тус байгууллага ирээдүйд түүнийг гүйцэтгэнэ гэдэг итгэлтэй байна. Үл нийцэл нь 0.4% байна. Сайжруулах шаардлагатай буюу аудитын явцад хангалттай мэдээ баримт цуглаагүй, аудит хийлгэгч талаас нотлох баримтаар хангаагүй шалгууруудыг дараагийн төлөвлөгөөт аудит гүйцэтгэх хүртэл хугацаанд нийцэлтэй болгож залруулах боломжтой.
3. Байгаль орчны аудитын эрсдэлийн нэгтгэлээс үзэхэд нийт 471 асуулгын 462 (98.1%) асуулгад эрсдэл байхгүй, 9 (1.9%) асуулгад бага зэрэг эрсдэл үүсэж болзошгүй байгааг цаашид үйл ажиллагаандаа анхаарч ажиллах шаардлагатай.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн А/809 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал"-ын дагуу дүгнэвэл: Тус байгууллагын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, үр дагавар онц уршигтай бус бөгөөд удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ болон хууль тогтоомжийн зохих заалтуудыг хангах шаардлагатай. Цаашид сайжруулах шаардлагатай гарсан шалгууруудыг нийцэлтэй болгохын тулд амлалтын хугацаа тогтоож, холбогдох хүмүүст үүрэг ногдуулах хэрэгтэй. Төслийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжтой.
5. Уурхайн "Сайжруулах шаардлагатай", "Үл нийцэл" гэж үнэлэгдсэн шалгууруудыг тус компани өөрийн амлалтын хугацаанд залруулах боломжтой ба түүнийхээ биелэлтийг дотоод шалгалтаараа гаргаж, биелэлтийн тайланг Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 1-р заалтыг үндэслэн Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор хүргүүлнэ.

#### **1.15. Ерөнхий зөвлөмж**

Аудит хийгдсэн үндсэн 8 чиглэл тус бүрийн зөвлөмжүүд тайлангийн үл нийцлийг арилгах төлөвлөгөөнд туссан бөгөөд "Эрдэнэ Монгол" ХХК-ийн зүгээс дараагийн аудитыг хийлгэхдээ чиглэлээ улам өргөжүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын Байгаль орчны багц хууль 2012 онд шинэчлэгдэн батлагдсан, тэдгээрийг биелүүлэх журмууд 2012-2024 онуудад батлагдан гарч байгаа бөгөөд тус компанийн хувьд эдгээр журмын заалтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Аливаа хийсэн ажлыг баримтжуулах, түүнийг архивлан хадгалах асуудлыг анхааралдаа авч, үүнийг байгаль орчны мэргэжилтэнд бүрэн хариуцуулах хэрэгтэй.

#### **1.16. Эргэн шалгалтын төлөвлөгөө**

Байгаль орчны аудитын шалгуурын явцад сайжруулах шаардлагатай гарсан үнэлэмжүүдийг засаж сайжруулах амлалтын хугацааг үйлчлүүлэгч, аудитын байгууллагатай зөвшилцөж, тогтоосон бөгөөд аудитын эргэн шалгалтыг үйлчлүүлэгч дотоодын хянан шалгалтаар гүйцэтгэж, биелэлтийг тооцохоор тохиролцов.

#### **1.17. Аудитын нууцлал**

Байгаль орчны аудитын ёс зүй, хөндлөнгийн хараат бус байх, мөн үйлчлүүлэгчийн нууцыг дараагийн аудит хийх хүртэл хадгалах зарчмыг баримтлан аудитын үеийн мэдээлэл, тайлан, нотолгоо зэргийг гуравдагч этгээдэд танилцуулахгүй бөгөөд шүүхийн шийдвэрээр үйлчлүүлэгч талд мэдэгдсэний үндсэн дээр эсвэл уг мэдээлэл аудитын байгууллагаас бусад этгээдээр дамжин олон нийтэд ил болж, нууц биш болох нь нотлогдсон тохиолдолд аудитын үеийн мэдээллийг задруулж болно.

#### **1.18. Тайлан түгээлт**


Байгаль орчны аудитын үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан аудитын тайланг зөвхөн үйлчлүүлэгч талд хоёр хувь хэвлэмэл болон файл хэлбэрээр хүлээлгэн өгсөн. Уг тайланг цааш гуравдагч этгээдэд түгээх эсэхээ үйлчлүүлэгч өөрөө шийдэх

эрхтэй. Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 1-р заалтыг үндэслэн аудитын үл нийцлийн биелэлтийн тайланг Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор хүргүүлнэ.

## 2. УURХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн ашигт малтмал ашиглах MV-021444 тусгай зөвшөөрөлтэй Баянхөндийн алтны үндсэн ордын талбай нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт Хөндий нэртэй газар байрладаг. Тус талбай нь Улаанбаатар хотоос 1000 км, Баянхонгор аймгийн төв Баянхонгор хотоос баруун урагш 350 км, Шинэжинст сумын төвөөс баруун урагш 85 км зайтай.



Зураг 1. Баянхөндийн алтны үндсэн ордын талбайн байршлын зураг

Тус компани нь Хөндий нэртэй талбайд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнг 2019 онд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж нөөцийг батлуулсан бөгөөд “Эрдэнэ Монгол” ХХК-д АМГТГ-аас 2019 оны 8 дугаар сарын 05-нд ашигт малтмал ашиглах MV – 021444 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий 2308.62 га талбайг 30 жилийн хугацаатай олгосон байна.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн газарзүйн солбицол

Эргэлтийн цэг	Уртраг	Өргөрөг
1	98° 48' 00.40"	43° 53' 00.50"
2	98° 47' 18.81"	43° 53' 00.50"
3	98° 46' 33.93"	43° 57' 36.11"
4	98° 50' 00.34"	43° 57' 36.11"
5	98° 50' 00.34"	43° 55' 00.30"
6	98° 48' 00.40"	43° 55' 00.00"

## 2.2. Ордын нөөц

Ордын нөөцийг ЭБЭХЯ, АМГ-ын дэргэдэх ЭБМЗ-ийн хуралдаанаар Баянхөндийн алтны үндсэн ордын бодитой (В) нөөцийг 6,705.79 мян.тн, боломжтой (С) нөөцийг 15,987.88 мян.тн, илрүүлсэн баялаг (Р1) нөөцийг 9,774.135 мян.тн гэж улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн байна.

## 2.3. Ашиглалтад хамаарах хүдрийн нөөц

Ордыг ил аргаар олборлоход ашиг, алдагдал тэнцэж байх захын (үйлдвэрлэлийн доод) агуулгыг 0.2 г/т, дэлхийн зах зээл дээрх унц алтны урт хугацааны үнэ \$1,500 ам.доллар байх ба металл авалт нь 95% байна хэмээн тооцоолж ашиглалтын нөөцийг тогтоожээ.

Баянхөндийн алтны үндсэн ордын ашиглалтын хугацаанд хаягдал (3.919%), бохирдол (9.78%) байх тооцоогоор 39,896,732 тн хөрс хуулж, 3.82 гр/т дундаж агуулгатай 2,929,492 тн хүдэр олборлоно.

## 2.4. Төслийн хүчин чадал, хэрэгжих хугацаа

Баянхөндийн алтны үндсэн ордын ашиглалтын нөөцийг 5 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна. Ашиглалтын хугацаанд 40.05 сая тонн хөрс хуулалтын ажил хийж, хаягдал бохирдол тооцоогүй дүнгээр нийт 2.26 сая тонн исэлдсэн хүдэр, 0.51 сая тонн анхдагч хүдэр, 5.32 сая тонн ядуу хүдэр (Ядуу хүдэр гэж өнөөгийн эдийн засгийн нөхцөлд үр ашиггүй нөөцийг нэрлэсэн) олборлоно.

Баяжуулах үйлдвэр нь жилд 600 мян.тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай. Ил уурхайгаас олборлосон 2.93 сая тонн хүдрийг 5 жилийн хугацаанд боловсруулахаар төлөвлөжээ.


## 2.5. Төслийн талбайн ерөнхий төлөвлөлт

Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах хугацаанд ил уурхай, гадаад овоолгууд, баяжуулах үйлдвэр, уурхайн ажилчдын хотхон болон засвар, үйлчилгээний барилга байгууламжууд баригдана. Эдгээр барилга байгууламжуудыг 117.44 га талбайд барихаар зураг төслийг боловсруулсан бөгөөд одоогоор уурхайн дэд бүтцийн байгууламж, баяжуулах үйлдвэрийн барилгын ажил явагдаж байна.

Хүснэгт 3. Баянхөндийн алтны үндсэн ордыг ашиглах төслийн үндсэн барилга байгууламжууд

№	Барилга байгууламж	Талбай, га	Эзлэхүүн, мян.м <sup>3</sup>
1	Авто зам	20.48	
2	Авто машины зогсоол	2.52	
3	Баяжуулах үйлдвэр	2.94	
4	Дулаан хангамжийн байгууламж	0.50	
5	Засварын газар	0.22	
6	Ил уурхай	30.16	
7	Тэсрэх бодисын агуулах	0.13	
8	Уурхайн ажилчдын хотхон	1.40	
9	Уурхайн оффис	0.19	
10	Халаалтын зуух	0.50	
11	Хаягдлын нэгдсэн байгууламж	48.02	19,500.0
12	Хаягдлын талбай	5.04	



55.	31.4.	31 дүгээр зүйл. Газар эзэмшүүлэхэд тавигдах шаардлага	Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.	√	-	-	-	-	-
56.	34.1.	34 дүгээр зүйл. Газар эзэмших гэрээ, түүнийг	Энэ хуулийн 33.1-д <sup>11</sup> заасан газар эзэмшүүлэх тухай шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба	√	-	-	-	-	-

<sup>10</sup> 9.15.Энэ хуулийн 9.9, 9.10-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

<sup>11</sup> 33.1.Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг дараахь журмыг баримтлан шийдвэрлэнэ:

		байгуулах журам	тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.						
57.	34.2.		Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 90 хоногт багтаан байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний дараа тэдгээртэй газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.	√	-	-	-	-	-
58.	34.3.		Хэрэв тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхийн гэрчилгээгээр эзэмших газарт хийсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр сөрөг дүгнэлт гарсан бол эрхийн гэрчилгээг олгохоос татгалзаж, дуудлага худалдааны үнийг буцаан олгоно.	√	-	-	-	-	-
59.	34.7.		Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшилд олгож байгаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээг тухайн газар эзэмших гэрээний хавсралт болгоно.	√	-	-	-	-	-
60.	34.8.		Газар эзэмших гэрээ нь эрхийн гэрчилгээний хамт хүчин төгөлдөр байх бөгөөд гэрээний биелэлтийг талууд жил бүр дүгнэнэ.	√	-	-	-	-	-
61.	34.9.		Газрыг дундаа эзэмшиж байгаа тохиолдолд газар эзэмших нэг гэрээтэй байж болно.	√	-	-	-	-	-
62.	34.10.		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ нь тухайн газар дээрх тэдгээрийн үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх үндэслэл болно.	√	-	-	-	-	-
63.	34.11.		Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газар эзэмших гэрээ байгуулахаас өмнө уг газарт палеонтологи, археологи, угсаатны урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авсан байна.	√	-	-	-	-	-
64.	35.3.1.		Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;	√	-	-	-	-	-
65.	35.3.2.	35.3. Газар эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:	Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;	√	-	-	-	-	-
66.	35.3.3.		Газрын төлбөрийг хуульд заасан хугацаанд төлөх;	√	-	-	-	-	-
67.	35.3.4.		Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх;	√	-	-	-	-	-
68.	50.1.1.	50 дугаар зүйл. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах нийтлэг	Газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах;	√	-	-	-	-	-

69.	50.1.2.	шаардлага 50.1.Газар эзэмшигч, ашиглагч нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах талаар дараахь шаардлагыг биелүүлнэ:	Ашигт малтмал олборлох, барилгын материал бэлтгэх, төмөр зам, авто зам тавих, эрэл хайгуул, сорилт туршилт, шинжилгээний ажил хийх болон бусад хэрэгцээнд зориулан ухаж ашигласнаас эвдэрч гэмтсэн газрыг тухай бүр өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээж, засаж тохижуулж байх;	√	-	-	-	-
70.	50.1.3.		Газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;	√	-	-	-	-
71.	50.1.4.		Ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах;	√	-	-	-	-
72.	50.1.5.		Бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газарт байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулахгүй байх.	√	-	-	-	-
73.	51.1.	51 дүгээр зүйл. Газрыг ашиглах эрүүл ахуйн шаардлага	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар ашиглахтай холбогдолтой зураг төсөл боловсруулах, шинэ технологи нэвтрүүлэх, Монгол Улсад өмнө нь сорьж, шалгаагүй химийн бодис, бордоог газарт хэрэглэхдээ мэргэжлийн эрх бүхий байгууллагаар байгаль орчны нөлөөллийн үнэлгээг өөрийн зардлаар хийлгэнэ.	√	-	-	-	-
74.	51.2.		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэнэ.	√	-	-	-	-
75.	51.3.		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 51.2-т <sup>12</sup> заасан ажлыг гүйцэтгэхийн өмнө энэ тухайгаа тухайн шатны Засаг даргад урьдчилан мэдэгдэж, хүн амд мэдээлэн, уг газрын заагийг тэмдэгжүүлж, сэрэмжлүүлэх байнгын дохио тэмдэгтүүд өөрийн хөрөнгөөр байрлуулна.	√	-	-	-	-
76.	55.2.	55 дугаар зүйл. Газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах	Газрын хэвлийг ашиглагч нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөлтэй байна.	√	-	-	-	-
77.	55.3.		Газрын хэвлийг ашиглагч нь үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгүүлнэ.	√	-	-	-	-
78.	55.4.		Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, түүнд үндэслэсэн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулна.	√	-	-	-	-
79.	55.5.		Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дүгнүүлнэ.	√	-	-	-	-
80.	56.6.	56 дугаар зүйл. Хот, тосгон, бусад суурины газрыг зохистой ашиглах,	Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай	√	-	-	-	-

<sup>12</sup> 51.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр гүйцэтгэнэ.

		хамгаалах	байлгана.					
81.	58.4.		Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллага хийж, дүгнэлт гаргана.	√	-	-	-	-
82.	58.5.	58 дугаар зүйл. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, түүнийг гаргах	Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулах бөгөөд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх дуусгавар болоход энэхүү баталгааг гаргана.	-	√	-	-	-
83.	58.7.		Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.	√	-	-	-	-
<b>1.4. Газрын төлбөрийн тухай</b>								
84.	-	<b>3 дугаар зүйл. Газрын төлбөр төлөгч</b>	Хууль тогтоомжийн дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулахаар шийдвэрлэсний үндсэн дээр газрыг эзэмшиж, ашиглаж байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, газар ашиглаж байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн газрын төлбөр төлөгч байна.	√	-	-	-	-
<b>1.5. Ашигт малтмалын тухай / шинэчилсэн найруулга /</b>								
85.	7.1.	7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглахад тавигдах ерөнхий шаардлага	Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын журмаар олгоно.	√	-	-	-	-
86.	7.2.		Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх бүх хугацаанд энэ хуулийн 7.1-д <sup>13</sup> заасан нөхцөлийг хангасан байна.	√	-	-	-	-
87.	7.3.		Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.	√	-	-	-	-
88.	27.1.1.	27 дугаар зүйл. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг	Тухайн уурхайн эдэлбэрт оршиж байгаа ашигт малтмалыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу ашиглах;	√	-	-	-	-
89.	27.1.5.		Уурхайн талбайд ашигт малтмалын хайгуул явуулах;	√	-	-	-	-
90.	27.1.11.	27.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:	Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар, ус ашиглах.	√	-	-	-	-
91.	27.1.12.		Энэ хуулийн 48.6.1-д <sup>14</sup> заасан тухайн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгасан байх;	√	-	-	-	-

<sup>13</sup> 7.1.Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгон шалгаруулалтын журмаар олгоно.

<sup>14</sup> 48.6.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь мэдээ, тайланг дор дурдсан хугацаанд төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ: 48.6.1.тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор;

92.	27.1.13.		Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын асуудлаар тогтмол мэдээлэх үүрэг бүхий ажилтантай байх;	√	-	-	-	-
93.	32.1.	32 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн төлбөр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг энэ хуулийн дагуу жил бүр төлнө.	√	-	-	-	-
94.	35.3.1.	35 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг үүрэг 35.3.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах баримт бичгийг уурхай дээр байлгана:	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар;	√	-	-	-	-
95.	35.3.2.		Ашигт малтмал ашиглах техник, эдийн засгийн үндэслэл болон зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө;	√	-	-	-	-
96.	35.3.3.		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;	√	-	-	-	-
97.	35.3.4.		Байгаль орчны менежментийн төлөвлөгөө;	√	-	-	-	-
98.	35.3.5.		Хөрөнгө түрээслэх болон бүтээгдэхүүн борлуулах гэрээ;	√	-	-	-	-
99.	35.3.6.		Уурхайн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан акт;	√	-	-	-	-
100.	35.3.7.		Газар, ус ашиглах тухай гэрээ.	√	-	-	-	-
101.	35.4.		Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхайг хүлээн авсны дараа ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг уурхайг ажиллуулж эхэлнэ.	√	-	-	-	-
102.	35.5.		Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно.	√	-	-	-	-
103.	35.10.		Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техникийн гэнэтийн осол, саатал, давагдашгүй хүчин зүйл, шүүхийн шийдвэр, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь зогсоосон болон бусад шалтгаанаар уурхайн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоохдоо геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлнэ.	√	-	-	-	-
104.	35.11.	Олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлнэ.	√	-	-	-	-	
105.	36.1.	36 дугаар зүйл. Уурхайн талбайн хил тогтоох, шав тэмдэг тавих	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 26.5-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн бүртгэлд бүртгүүлснээс хойш 3 сарын дотор мэргэжлийн хяналтын албаны тавьсан техникийн шаардлагын дагуу уурхайн талбайн хилийг тогтоолгож, байнгын шав тэмдэг тавих бөгөөд уурхайн талбайн хилийн хэмжилтийг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан этгээдээр хийлгэж, хил тогтоосон тухай актыг тус албанд ирүүлнэ.	√	-	-	-	-
106.	39.1.1.	39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн	Энэ хуулийн 24.1-д <sup>15</sup> заасан этгээд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө, сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах;	√	-	-	-	-

<sup>15</sup> 24.1.Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэж өргөдөл гаргах эрхтэй.



		асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлэх бөгөөд уг тайланд дараах зүйлийг тусгах:	захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.5 <sup>20</sup> , 39.1.7.3-т <sup>21</sup> заасан баримт бичгийг хүлээн авснаасаа хойш 30 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.						
121.	39.3.		Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д <sup>22</sup> заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.	√	-	-	-	-	-
122.	39.4.		Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 39.1.9-д <sup>23</sup> заасан хөрөнгийг түүнд уурхайн хаалтын үе шатанд буцааж өгнө.	√	-	-	-	-	-
123.	39.5.		Энэ хуулийн 39.3-т <sup>24</sup> заасан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн олборлолтын ажил эхлэхийн өмнө шилжүүлэх бөгөөд энэхүү шилжүүлэг хийгдсэн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ.	√	-	-	-	-	-
124.	39.6.		Энэ хуулийн 39.5-д <sup>25</sup> заасан хугацаанд мөн хуулийн 39.1.9-д <sup>26</sup> заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг зогсоох эрхтэй.	√	-	-	-	-	-
125.	39.7.		Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй.	√	-	-	-	-	-
126.	39.8.		Энэ хуулийн 38.1.8 <sup>27</sup> , 39.1.9-д <sup>28</sup> заасан тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	√	-	-	-	-	-
127.	39.9.		Тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаанд түүнийг эзэмшигч нь шинэ техник, технологи нэвтрүүлснээс байгаль орчинд сөргөөр нөлөөлөх шинэ нөхцөл, байдал үүсвэл байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардана.	√	-	-	-	-	-

<sup>20</sup> 39.1.5.энэ хуулийн 39.1.1-д заасны дагуу боловсруулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

<sup>21</sup> 39.1.7.3.үйлдвэрийг өргөтгөж хүчин чадлыг нь нэмэгдүүлсний улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнтэй холбогдуулан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал.

<sup>22</sup> 39.1.9.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасны дагуу зохицуулна.

<sup>23</sup> 39.1.9.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасны дагуу зохицуулна.

<sup>24</sup> 39.3.Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

<sup>25</sup> 39.5.Энэ хуулийн 39.3-т заасан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн олборлолтын ажил эхлэхийн өмнө шилжүүлэх бөгөөд энэхүү шилжүүлэг хийгдсэн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ

<sup>26</sup> 39.1.9.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасны дагуу зохицуулна.

<sup>27</sup> 38.1.8.байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх.

<sup>28</sup> 39.1.9.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасны дагуу зохицуулна.

128.	40.2.	40 дүгээр зүйл. Байгаль орчны нөлөөллийн шинэчилсэн үнэлгээ, менежментийн төлөвлөгөөг хянуулах	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.	√	-	-	-	-
129.	40.3.	40 дүгээр зүйл. Соёлын өвийг хамгаалах	Энэ хуулийн 40.1 <sup>29</sup> , 40.2-т <sup>30</sup> заасан төлөвлөгөө, үнэлгээг мөн хуулийн 38.2, 39.2-т заасны дагуу батална.	√	-	-	-	-
130.	40 <sup>1</sup> .2.	40 <sup>1</sup> дүгээр зүйл. Соёлын өвийг хамгаалах	Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно.	√	-	-	-	-
131.	40 <sup>2</sup> .1.2.	40 <sup>2</sup> дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 40 <sup>2</sup> .1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:	Ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ.	√	-	-	-	-
132.	41.1.	41 дүгээр зүйл. Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.	√	-	-	-	-
133.	42.1.	42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.	√	-	-	-	-
134.	42.2.	42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д <sup>31</sup> заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.	√	-	-	-	-
135.	42.3.	42 дугаар зүйл. Нутгийн захиргааны байгууллагатай харьцах	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.	√	-	-	-	-
136.	44.1.	44 дүгээр зүйл.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зохих хууль	√	-	-	-	-

<sup>29</sup> 40.1.Хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө сум, дүүргийн Засаг даргад батлуулахаар хүргүүлнэ.

<sup>30</sup> 40.2.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

<sup>31</sup> 42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

		Эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй ажиллагааг хангах	тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон тухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагаа явуулна.					
137.		45 дугаар зүйл. Уурхайг хаах үед тавигдах шаардлага	45.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол төрийн захиргааны төв байгууллагад нэгээс доошгүй жилийн өмнө мэдэгдэж, энэ хуулийн 10.1.14-д <sup>32</sup> заасан журмын дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:	√	-	-	-	-
138.	45.1.1.	Энэ хуулийн 10.1.14-д <sup>33</sup> заасан журмын дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:	Уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгох, байгаль орчныг нөхөн сэргээх талаар холбогдох арга хэмжээг бүрэн авах;	√	-	-	-	-
139.	45.1.2.	Уурхайн эдэлбэр байсан газрыг нийтийн зориулалтаар ашиглахад аюул учирч болзошгүй бол түүнээс сэргийлэх арга хэмжээ авах;	Уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюул учирч болзошгүй бол түүнээс сэргийлэх арга хэмжээ авах;	√	-	-	-	-
140.	45.1.3.	Тухайн нутгийн захиргааны байгууллага, эсхүл мэргэжлийн хяналтын албанаас талбайд үлдээхийг зөвшөөрснөөс бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг талбайгаас гаргах.	Тухайн нутгийн захиргааны байгууллага, эсхүл мэргэжлийн хяналтын албанаас талбайд үлдээхийг зөвшөөрснөөс бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг талбайгаас гаргах.	√	-	-	-	-
141.	45.2.	-	Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас үүсч бий болсон, аюул учруулж болзошгүй газруудыг зохих масштабын газрын зураг дээр нарийвчлан тэмдэглэж, шаардлагатай тэмдэг, дохио, сануулгыг уурхайн эдэлбэрийн орчинд байрлуулах бөгөөд газрын зургийг мэргэжлийн хяналтын алба болон тухайн сум, баг, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.	√	-	-	-	-
142.	48.6.1.	48 дугаар зүйл. Мэдээ, тайлан гаргах	Тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор;	√	-	-	-	-
143.	48.6.2.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайланг дор дурдсан хугацаанд төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:	Дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд, уулын ажлын төлөвлөгөөг батлагдсан зааврын дагуу 12 дугаар сарын 01-ний дотор;	√	-	-	-	-
144.	48.6.3.	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн зэрэглэлийг ахиулах ашиглалтын хайгуулыг тухай бүр хийж, ажлын төлөвлөгөө, тухайн жилийн болон хайгуулын ажлын үр дүнгийн тайланг энэ хуулийн 48.1.2-т <sup>34</sup> заасны дагуу.	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нөөцийн зэрэглэлийг ахиулах ашиглалтын хайгуулыг тухай бүр хийж, ажлын төлөвлөгөө, тухайн жилийн болон хайгуулын ажлын үр дүнгийн тайланг энэ хуулийн 48.1.2-т <sup>34</sup> заасны дагуу.	√	-	-	-	-
145.	48.8.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 38 <sup>35</sup> , 39 <sup>36</sup> дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 38 <sup>35</sup> , 39 <sup>36</sup> дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.	√	-	-	-	-
<b>1.6. Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/</b>								
146.	7.1.	7 дугаар зүйл.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн	-	√	-	-	-

<sup>32</sup> 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.14.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

<sup>33</sup> 10.1.Ашигт малтмалын асуудлаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.14.уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

<sup>34</sup> 48.1.2.хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

<sup>35</sup> 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

<sup>36</sup> 39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

		Гамшгийн эрсдэлийг үнэлэх	болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ.						
147.	7.2.		Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ.	√	-	-	-	-	-
148.	8.1.	8 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна.	√	-	-	-	-	-
149.	8.2.		Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.	√	-	-	-	-	-
150.	34.2.1.	34 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн эрх, үүрэг 34.2. Хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшгаас хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх;	√	-	-	-	-	-
151.	34.2.2.		Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;	√	-	-	-	-	-
152.	34.2.3.		Үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн мэргэжлийн анги байгуулах, шаардагдах техник, материал, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх;	√	-	-	-	-	-
153.	34.2.5.		Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах;	√	-	-	-	-	-
<b>1.7. Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/</b>									
154.	17.2.1.	17 дугаар зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг 17.2. Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага дараах үүрэг хүлээнэ:	Холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлэх, галын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтныг томилох;	√	-	-	-	-	-
155.	17.2.2.		Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах;	√	-	-	-	-	-
156.	17.2.3.		Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах;	√	-	-	-	-	-
157.	17.2.4.		Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	√	-	-	-	-	-
158.	17.2.5.		Гал түймэр унтраах үйл ажиллагаанд шуурхай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;	√	-	-	-	-	-
159.	17.2.6.		Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангах;	√	-	-	-	-	-
160.	17.2.7.		Барилга байгууламж, үйлдвэрийн технологид хэрэглэх бодис, материалын гал түймрийн аюулын зэрэглэлийг итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулах;	√	-	-	-	-	-
161.	17.2.8.		Гал түймрийн улмаас аж ахуйн нэгж,	√	-	-	-	-	-

			байгууллагад учирсан хохирлын хэмжээг эрх бүхий үнэлгээний байгууллагаар тогтоолгох;						
162.	17.2.9.		Гал түймрийн аюулын үнэлгээг энэ хуулийн 18.5 <sup>37</sup> , 18.6 <sup>38</sup> , 18.7 <sup>39</sup> , 18.8-д <sup>40</sup> заасны дагуу хийлгэх;	√	-	-	-	-	-
163.	17.2.10.		Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулах;	√	-	-	-	-	-
164.	17.2.11.		Галын аюулгүй байдлыг хангах талаар байгууллагын хэмжээнд галын сайн дурын бүлгэм ажиллуулах.	√	-	-	-	-	-
165.	17.3.		Аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хяналтын бүртгэлтэй байна.	√	-	-	-	-	-
166.	18.3.		Барилга байгууламж, гэр хорооллыг гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлсан талбайтай, гал түймэр унтраах үед ашиглах усан хангамжтай байхаар төлөвлөнө.	√	-	-	-	-	-
167.	18.5.	18 дугаар зүйл. Галын аюулгүй байдлыг хангах үндэслэл	Барилга байгууламж болон үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдалд гал түймрийн аюулын үнэлгээ хийлгэнэ.	√	-	-	-	-	-
168.	18.7.		Гал түймрийн аюулын үнэлгээ хийх журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	√	-	-	-	-	-
169.	19.1.		Барилга байгууламжийн хийц, бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд хүн амын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байна.	√	-	-	-	-	-
170.	19.2.	19 дүгээр зүйл. Галын аюулгүй байдлыг хангах талаар тавих нийтлэг шаардлага	Гал түймрийн аюултай болон тэсэрч дэлбэрэх бодис, материал үйлдвэрлэх, хадгалах /газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун болон шатах хий түгээх станц зэрэг/, ашиглах, тээвэрлэх зөвшөөрлийг олгох эрх бүхий төрийн захиргааны байгууллага нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын галын аюулгүй байдлын дүгнэлтийг үндэслэнэ.	√	-	-	-	-	-
171.	19.3.		Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл гал түймэр унтраах анхан шатны багаж, хэрэгслээр хангагдсан байна. Анхан шатны багаж, хэрэгслийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.	√	-	-	-	-	-
172.	19.4.		Барилга байгууламж галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичигт заасан гал түймрээс хамгаалах автомат тоног төхөөрөмжтэй байна.	√	-	-	-	-	-
173.	19.5.		Аж ахуйн нэгж, байгууллага гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, ажилтнаа сургаж, дадлагажуулсан байна.	√	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>				<b>171</b>	<b>2</b>	-	-	-	-

<sup>37</sup> 18.5.Барилга байгууламж болон үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдалд гал түймрийн аюулын үнэлгээ хийлгэнэ.

<sup>38</sup> 18.6.Гал түймрийн онц аюултай болон гал түймрийн аюултай нэг, хоёрдугаар зэргийн барилга байгууламж нь заавал, бусад аж ахуй нэгж, байгууллага нь сайн дурын үндсэн дээр гал түймрийн аюулын үнэлгээ хийлгэнэ.

<sup>39</sup> 18.7.Гал түймрийн аюулын үнэлгээ хийх журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

<sup>40</sup> 18.8.Дараах шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад гал түймрийн аюулын үнэлгээ хийх эрхийг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно:

### Аудитын үнэлэмж:

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан бөгөөд дараах дөрвөн хэлбэрээр илэрхийлэв.

- ❖ **Нийцэл.** Аудитын шалгуурыг хангасан. Шаардлагатай тохиолдолд сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Сайжруулах шаардлагатай.** Аливаа мэдээлэл дутуугаас тухайн шалгуурыг үнэлэх боломжгүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Хугацаа болоогүй.** Шалгуурыг гүйцэтгэх хугацаа болоогүй. Ирээдүйд хийгдэх ажлууд тул зөвхөн тайлбар бичсэн.
- ❖ **Үл нийцэл.** Аудитын шалгуурыг хангаагүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.

Нийт 185 шалгуурт тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

✓ Нийцэл	171
✓ Сайжруулах шаардлагатай	2
✓ Хугацаа болоогүй	0
✓ Үл нийцэл	0
✓ Хамааралгүй	12

Үнэлэмжийн бүтцийг зургаар үзүүлбэл:



График 2. Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ

### Үл нийцлийн эрсдэл:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, хүрээлэн буй орчны байгалийн бүрдэл хэсгүүд, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ буюу шаардлагуудыг тухайн төсөл хэрэгжүүлэгч биелүүлээгүйгээс аливаа эрсдэл үүсэх бөгөөд үүнээс улбаалан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, байгаль орчин бохирдож, доройтох ба хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Эрсдэлийг үнэлэхдээ дараа хэлбэрүүдийг ашиглав.

- ❖ **Их.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл өндөр. Аудитын багийн ахлагчид даруй мэдэгдэнэ.

- ❖ **Дунд.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл дунд зэрэг.
- ❖ **Бага.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл бага.

Нийт 173 шалгуурын эрсдэлийг тогтооход дараах байдалтай үнэлэгдэв. Эрсдэлийн бүртгэл:

✓ Их	0
✓ Дунд	0
✓ Бага	2
✓ Үгүй	171

Аудит хийлгэгч байгууллага эрсдэлийг хооронд нь ялгалгүйгээр бүгдэд нь анхаарал хандуулан ажиллах шаардлагатай.

Байгаль орчны аудитын явцад дараах эрсдэлүүд ажиглагдлаа. Үүнд:

1. Тус компани нь уурхайн хэмжээнд Гамшгаас хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ" хэмээн заасны дагуу Гамшгийн эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий Мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлээгүй ажиллаж байна.
2. Уурхайн хэмжээнд Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлтийг "Эко Трэнд" ХХК 2018 онд боловсруулж, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраар батлуулж байсан боловч хуульд заасан хугацаа дууссан байна.

### **Зөвлөмж:**

Хуулийн нийцлийн аудитын үр дүнд дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, түүнд үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх.
2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын тайланг Мэргэжлийн байгууллагаар хийлгэж, холбогдох төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулан хэрэгжүүлж ажиллах зэрэг болно.

### **Аудитын дүгнэлт:**

Нийцлийн аудитын үр дүнгээс үзвэл үйлчлүүлэгч байгууллагад хууль, тогтоомжийн хувьд дараах нийцлүүд байна. Үүнд:

1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Мэргэжлийн байгууллагаар хуулийн дагуу хугацаанд нь хийлгүүлж, БОАЖЯ-аар батлуулсан.

2. Төслийн техник эдийн засгийн үндэслэлийг хуулийн хугацаанд боловсруулж, Эрдэс баялгийн Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалаар хүлээн авсан.
3. Тус компани нь уурхайн ашиглалтын үйл ажиллагааны тайланг боловсруулж Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, судалгааны хэлтэст жил бүр тайлагнадаг бөгөөд түүнийг үндэслэн тухайн жилийн ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.
4. Тус компани нь жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын ажлын хэсэгт тайлагнаж биелэлтийг хүлээн авах, дүгнэх хуудсаар баталгаажуулдаг, улмаар Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлж, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан ажиллаж байна.

## 3.2. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, МОНИТОРИНГИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, БИЕЛЭЛТ

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг гүйцэтгэхдээ төслийн хүрээнд боловсруулсан Байгаль орчны төлөв байдлын болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан [35, 36, 37], төслийн техник эдийн засгийн үндэслэл [22], ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлан [38, 39, 40, 41], байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайлан, түүний биелэлтийн тайлан [29]-г удирдлага болгон биелэлт, гүйцэтгэлийг үнэлсэн болно.

### 3.2.1. УСАН ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

#### Баталгаажсан нотолгоо:

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгон аудитын явцад цуглуулсан болно. Үүнд:

#### 1. Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл


- ✓ Түр байгууламж, уурхайн доторх замыг сайрууд дээр байгуулснаар сайрын голдирол өөрчлөгдөх
- ✓ Газрын доорх усны нөөц багасгах
- ✓ ШТМ, аюултай болон хортой бодис асгарч, хаягдсан тохиолдолд газрын доорх усыг бохирдуулах зэрэг болно.

#### 2. Ус хангамжийн эх үүсвэр

Уурхайн усны хэрэглээг хангах зорилгоор 2019 онд гүйцэтгэсэн газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны үр дүнд Хүрэнцавын талбай, Хүрэнцавын зүүн талбай, Шинэ кемпийн талбай гэсэн усжилт өндөртэй 3 талбайг ялгаж газрын доорх усны ашиглалтын тогтоожээ. Газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлаар усны нөөцийн тооцоонд 6 цооног сорилын шавхалт явуулж уст үеийн параметруудийг тодорхойлон тухайн цооногт урт хугацааны ашиглалтын үеийн ундаргын нөөцийн тооцоог хийсэн байна.



Зураг 6. Гүний худгийн харагдах байдал



Зураг 7. Газрын доорх усны цооногуудын байршил

Тус компани нь “Газрын доорх усны ордын нөөц батлах тухай” БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 12-р сарын 30-ны өдрийн №А/640 тоот тушаалаар Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт дахь Баянхөндийн алтны үндсэн ордыг түшиглэн байгуулах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон “Хүрэн шанд худаг”-ийн ордын нөөцийг технологийн усны зориулалтаар үйлдвэрлэлийн С зэргээр 10 л/с буюу 864 м<sup>3</sup>/хоногоор батлуулсан байна [43].

**3. Усны эх үүсвэр, нөөц.** Унд, ахуйн болон технологи, зам, талбайн болон мод ургуулахад ашиглах усыг “Эрдэнэ Монгол” ХХК-ийн эзэмшлийн талбайд 2019-2020 онуудад “Охь-Ус” ХХК-ийн гаргасан өрөмдмөл 6 ш худаг (худгуудын нийлбэр ундарга 11.9 л/сек)-аас хангана. Харин унд, ахуйн усыг зөөврөөр хангадаг.

“Охь-Ус” ХХК 2019 онд төслийн талбайд БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 4-р сарын 17-ны өдөр баталсан “Газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын даалгавар”-ын дагуу гидрогеологийн хайгуул, судалгаа хийж гаргасан “Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дахь Баянхөндийн алтны үндсэн ордыг түшиглэн байгуулагдах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын тайлан” I дэвтэр “БИЧВЭР”-ийн зөвлөмж, дүгнэлтэд: “Газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн ус хангамжийн зориулалтаар 10.0 л/с буюу 950.4 м<sup>3</sup>/хоног хэмжээгээр үнэлжээ. Энэхүү нөөцийг үйлдвэрлэлийн С зэргийн түвшинд үнэлэгдсэн гэж үзсэн” гэжээ.

Усны нөөцийн зөвлөлийн 2019 оны 12-р сарын 27-ны өдрийн 8-р хурлын шийдвэрийг үндэслэн "Усны нөөц батлах тухай" БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 12-р сарын 30-ны өдрийн А/640 дугаар тушаалаар "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дахь Баянхөндийн алтны үндсэн ордыг түшиглэн байгуулагдах уулын баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон "Хүрэн цавын худгийн" ордын нөөцийг технологийн усны зориулалтаар үйлдвэрлэлийн С зэргээр 10 л/с буюу 864 м<sup>3</sup>/хоногоор баталсан байна.

Усны газрын 2019 оны 9-р сарын 28-ны өдрийн 04/835 тоот албан бичгээр "Эрдэнэ Монгол" ХХК-д гаргаж өгсөн усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд: "Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах 861.58 м<sup>3</sup>/хон усыг нийт 11 л/сек буюу 950.4 м<sup>3</sup>/хон газрын доорх усны орд болон шүүрлийн усыг хуримтлуулан хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна" гэсэн байна. Унд, ахуйд хоногт дунджаар 13.7 м<sup>3</sup> усыг хэрэглэдэг байна.

**4. Усны хэрэглээ.** Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм"-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн жилийн хэрэгцээнд тооцоход:

*Хүснэгт 6. Жилд ашиглах усны хэмжээ*

$21,500.0 \text{ тууш.м} \times 10 \text{ м}^3 : 100 \text{ тууш.м} = 2,150.0 \text{ м}^3$	Хайгуулын өрөмдлөгт ашиглах ус
$22,108.0 \text{ м}^2 \times 2 \text{ л/м}^2 \times 2 \text{ удаа} \times 100 \text{ хон} = 8,843.2 \text{ м}^3$	Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах ус
$62,532 \text{ ш.мод} \times 45.0 \text{ л/ш.мод} \times 14 \text{ удаа} = 39,395.16 \text{ м}^3$	Урд жилүүдэд тарьсан модыг услахад ашиглах ус
$10,000.0 \text{ ш.мод} \times 45.0 \text{ л/ш.мод} \times 18 \text{ удаа} = 8,100.0 \text{ м}^3$	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах ус
$39,395.16 \text{ м}^3 + 8,100.0 \text{ м}^3 = 47,495.16 \text{ м}^3$	Мод ургуулахад ашиглах нийт усны хэмжээ
$9,081.12 \text{ м}^3 \times 0.3 \text{ м}^3 = 2,724.34 \text{ м}^3$	Бетон зуурмагийн үйлдвэрт ашиглах усны хэмжээ
$378 \text{ хүн} \times 150 \text{ л/хон} \times 180 \text{ хон} = 10,206.0 \text{ м}^3$	Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах
$2,150.0 + 8,843.2 + 47,495.16 + 10,206.0 = 68,694.36 \text{ м}^3$	Жилд ашиглах нийт усны хэмжээ

**5. Усан орчны гүйцэтгэлийн үр дүн**

**Гадаргын усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан**

Үерийн усны байгууламжийн зураг төслийг "Хидро инженеринг" ХХК 2021 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд дахин зураг төсөл хийлгэх ажлыг барилгын ерөнхий гүйцэтгэгч хариуцан ирэх онд дуусгахаар төлөвлөсөн байна. "Дат консалтинг" ХХК Гамшгийн эрсдэлийн урьдчилсан үнэлгээг 2021 онд хийсэн, эрсдэлийн үнэлгээгээр төслийн талбайн үерийн аюулын түвшин "Дунд" гэж үнэлэгдсэн байна. Төслийн талбайн нэгдсэн хогийн цэгт үер усны аюулаас сэргийлсэн 2 м өндөртэй 4 м өргөнтэй 50 м

урттай түр даланг барьж байгуулсан байна. Барилга угсралтын үе шаттай уялдуулан түр үерийн даланг барьж гүйцэтгэсэн байна.

### **Газрын доорх усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан**

Төслийн ахуйн хэрэглээний ус авч ашигладаг Уртын гол /ВКW-21/ худагт 2023 оны 08 дугаар сарын 06-нд LGX 40мм голчтой, хүйтэн усны, үйлдвэрийн ус авдаг Уртын гол /ВКW-30/ LGX 40мм голчтой, хүйтэн усны, Шинэ кэмпийн худагт 2023 оны 06 дугаар сарын 20-нд LGX 32мм голчтой, хүйтэн усны баталгаат тоолуурыг суурилуулсан байна.



*Зураг 8. Гүний худгийг тоолууржуулсан байдал*

Байгаль орчны мэдлэг олгох сургалтын төлөвлөгөөний дагуу “Ус хэмнэх” сургалтыг 05 дугаар сарын 04-нд зохион байгуулсан ба “Ус хэмнэх аян”-ыг 10 дугаар сарын 11-ээс 18- ны өдрүүдэд зохион байгуулсан байна. Аяны хүрээнд ажилтнуудад “Ус хэмнэх” сургалт явуулж, АХА тэмцээн зохион байгуулан аянд идэвх санаачилгатай оролцсон шилдгүүдийг шалгаруулж, мөнгөн урамшууллаар шагнасан байна.



*Зураг 9. АХА тэмцээн, Ус хэмнэх зөвлөмж*

Үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрт газрын доорх усны ордын гидрогеологийн нэмэлт судалгааны ажилтай холбогдуулан, ордын нөөц шинэчлэгдэн батлагдсаны дараа байршлыг мэргэжлийн байгууллага, Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай хамтран тодорхойлж, холбогдохоор төлөвлөж байна.

Шинэ кэмпийн худагт хамгаалалтын хашааг 50 м радиустай татсан ба усны сан бүхий газар хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий тэмдгийг байршуулсан. Үйлдвэрийн ус авдаг ВКW-30 худгаас 100 м зайд усны сан бүхий газар хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий тэмдгийг байршуулсан.



Зураг 10. Усны сан бүхий газар хог хаяхыг хориглох тэмдэг

Үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрт газрын доорх усны ордын гидрогеологийн нэмэлт судалгааны хийгдэж байгаатай холбоотойгоор, ордын нөөц шинэчлэгдсэн батлагдсаны дараа ашиглалтын худгуудад хяналтын цооног суурилуулахаар төлөвлөж байна. Автомат усны түвшин хэмжигчийн үнийн саналыг судалж, бэлтгэл ажлыг хангаж байна. Автомат түвшин хэмжигчийн үнийн саналыг КРМ ХХК-аас 2023 оны 10 дугаар сарын 09-нд авч, 2024 оны компанийн төсөвт зардлыг суулгуулсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын А/561 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын үр дүнд үндэслэн орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу 2 мониторингийн цооногийг шинээр гаргах, цооног өрөмдөх ажлыг нутгийн гидрогеологитой хамтран гүйцэтгэсэн байна. Цооног өрөмдөх ажлыг Шинэжинст сумын иргэн Чинзоригийн компани болох “Гео инженеринг” ХХК-аар гүйцэтгүүлэн Баянхонгор аймагт хүлээлгэн өгсөн байна.

**6. Усны дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл, тайлан.** Тус компани нь 2023-2024 оны Ус ашиглуулах дүгнэлтийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газраар [44, 47], Ус ашиглах зөвшөөрлийг Алтайн өвөр говийн сав газрын захиргааны даргын тушаалаар [45, 48], Ус ашиглах гэрээг Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай [46, 49], Ус ашиглах эрхийн бичгийг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын тамгын газартай [50] тус тус байгуулан ажиллаж байгаа бөгөөд тухайн жилийн ус ашиглалтын тайлан [55]-г жил бүр холбогдох төрийн захиргааны байгууллагад тайлагнан ажиллаж байна.

Тус компани нь 2024 оноос Хаягдал усны дүгнэлтийг Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай [53], Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргын захирамж [54]-аар тус тус байгуулан ажиллаж байна.

### Аудитын шалгуур:

Хууль тогтоомжийн хүрээнд 116 шалгуур үзүүлэлтээр усан орчны аудитыг гүйцэтгэв. Нийт 116 шалгуурын 9 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөрт, 27 нь үндэсний хууль тогтоомж, 59 холбогдох дүрэм журам, аргачлалд, 12 нь стандартад, 9 нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгалаа олсон байна.

Аудитын шалгуураар тодорхойгүй болон хамааралгүй гэж үнэлэгдсэн үзүүлэлтийг хасаж, аудитын нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7. Усан орчны менежментийн нийцэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэгтгэл

№	Хуулийн заалт	Хамрах хүрээ	Шалгуур үзүүлэлт	Үнэлэмж				
				Нийцэл	Сайжруулах шаардлагатай	Үл нийцэл	Тодорхойгүй	Хамааралгүй
<b>1. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ</b>								
<b>1.1. Усны тухай хууль / шинэчилсэн найруулга /</b>								
1.	24.2.	24 дүгээр зүйл. Усны нөөцийг бохирдохоос хамгаалах	Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоометрээс их, эсхүл энэ хуулийн 10.1.12-д <sup>41</sup> заасан аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.	√	-	-	-	-
2.	24.4.		Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулсан байна.	√	-	-	-	-
3.	25.1.	25 дугаар зүйл. Ус бохирдуулсны болон хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөр тогтоох	Ус бохирдуулагч нь хаягдал усныхаа тоо хэмжээ, найрлагад хяналт тавих, хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн бохир усыг цэвэрлэж зайлуулах, ус бохирдуулсны төлбөр төлөх үүрэг хүлээнэ.	√	-	-	-	-
4.	27.3.	27 дугаар зүйл. Ус хэрэглэгчид олгох зөвшөөрөл	Аймаг, нийслэлийн байгаль орчны алба ус хэрэглэгчийн худаг, цооногийг усны мэдээллийн санд бүртгэж, худгийн паспорт олгоно.	√	-	-	-	-
5.	28.4.	28 дугаар зүйл. Ус ашиглагчид олгох зөвшөөрөл	Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн Байгаль орчны алба тус тус гаргана.	√	-	-	-	-

<sup>41</sup> 10.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага усны харилцааны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.12. Ус бохирдуулах аюултай бодисын жагсаалтыг батлах;

6.	28.6.		Энэ хуулийн 28.4-т <sup>42</sup> заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоомтрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоомтр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоомтрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.	✓	-	-	-	-
7.	28.7.		Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна.	✓	-	-	-	-
8.	28.8.		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ус ашиглах зөвшөөрлийг 10 хүртэл жилийн хугацаагаар олгож, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ирсэн ус ашиглагчийн эрхийг тухай бүр 5 хүртэл жилээр сунгана.	✓	-	-	-	-
9.	28.11.		Энэ хуулийн 28.6-д <sup>43</sup> заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ.	✓	-	-	-	-
10.	29.1.	29 дүгээр зүйл. Ус ашиглах гэрээ байгуулах, цуцлах	Энэ хуулийн 28.6 <sup>44</sup> , 28.7-д <sup>45</sup> заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна.	✓	-	-	-	-
11.	30.1.2.	30 дугаар зүйл. Ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлага 30.1. Ус ашиглагч дараах үүргийг хүлээнэ:	Хоногт 50 шоомтрээс их ус ашиглагч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-д <sup>46</sup> заасны дагуу дотоод хяналтын цэг, техник хэрэгсэлтэй байх ба усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах;	✓	-	-	-	-
12.	30.1.3.		Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах;	✓	-	-	-	-
13.	30.1.4.		Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах;	✓	-	-	-	-
14.	30.1.5.		Ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх;	✓	-	-	-	-
15.	31.1.		31 дүгээр зүйл. Ус ашигласны төлбөр	Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө.	✓	-	-	-
16.	32.4.	32 дугаар зүйл. Усны барилга байгууламж	Усны барилга байгууламж эзэмших, ашиглах эрхийг тав хүртэл жилийн хугацаагаар олгож, сунгана.	✓	-	-	-	-
17.	32.7.		Хүн амын төвлөрсөн ус хангамж, ариутгах татуурга, усны нөөцөд тохируулга хийх, хуваарилах зориулалт бүхий толгойн барилга байгууламж төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын өмчлөлд байна.	✓	-	-	-	-
18.	32.9.		Усны барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр усаар хангана.	✓	-	-	-	-
19.	32.10.		Усны аливаа барилга байгууламж нь паспорттай	✓	-	-	-	-

<sup>42</sup> 28.4. Хоногт 100 шоомтрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоомтр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоомтр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.

<sup>43</sup> 28.6. Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоомтрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоомтр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоомтрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

<sup>44</sup> 28.6. Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоомтрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоомтр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоомтрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.

<sup>45</sup> 28.7. Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна.

<sup>46</sup> 31 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг. 31.7. Бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, өөрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд ялгаруулж байгаа хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгжтэй байх.

			байна.						
<b>1.2. Ус бохирдуулсны төлбөрийн тухай</b>									
20.	4.1.		Ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсны төлбөр төлөгч байна.	√	-	-	-	-	-
21.	4.2.	4 дүгээр зүйл. Ус бохирдуулсны төлбөр төлөгч, түүнийг бүртгэх	Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг даргатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулсан хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээд нь ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэнэ.	-	√	-	-	-	-
22.	9.1.	9 дүгээр зүйл. Төлбөрийг төлөх, тайлагнах	Төлбөр төлөгч нь тухайн улиралд байгаль орчинд шууд хаясан болон ариутгах татуургын байгууламжид нийлүүлсэн хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.	√	-	-	-	-	-
<b>2. ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ</b>									
<b>2.1. "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам батлах тухай Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 5 сарын 16-ны өдрийн А/156 тоот тушаал</b>									
23.	2.1.1.	Хоёр. Тоолууржилтад тавих ерөнхий шаардлага 2.1. Тоолуур нь дараах шаардлагыг хангасан байна.	Техникийн болон ашиглалтын баримт бичигтэй байхын зэрэгцээ загварын туршилтад орж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, хэмжил зүйн хяналтад хамрагдсан байх;	√	-	-	-	-	-
24.	2.2.1.	2.2. Тоолуурын суурилалт	Газрын доорх ус ашигладаг бол ус авах цэг, цооног, худаг, ус дамжуулах шугамын оролт тус бүр дээр тоолуур суурилуулна.	√	-	-	-	-	-
25.	2.3.1.	2.3. Тоолуурын хамгаалалт	Усны тоолуурыг түүний заалтыг харах боломжтой, үзлэг, үйлчилгээ хийхэд тохиромжтой, гэрэлтүүлэгтэй, агаарын температур +5°C-аас багагүй дулаан өрөөнд, ус хэмжих цахилгаан хэрэгсэл /ISO 4064/ стандартын дагуу суурилуулна.	√	-	-	-	-	-
26.	2.3.2.		Тоолуур нь хөлдөлт ба механик гэмтлээс хамгаалагдсан байна.	√	-	-	-	-	-
<b>2.2. "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам батлах тухай" Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 тоот тушаал</b>									
27.	2.1.	Хоёр. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс ба түүний дэглэм	Усны эх, ундарга, нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, хүн амыг үер усны аюулаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтооно.	√	-	-	-	-	-
28.	2.3.1.	2.3. Онцгой хамгаалалтын бүсийг дараах байдлаар тогтооно:	Гол мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт түүний эргээс усны хагалбарын хил хүртэлх зайд;						
29.	2.3.2.		Гол мөрөн, горхи, булаг, шандын эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж;	√	-	-	-	-	-
30.	2.3.3.		Нуур, урсцын тохируулгатай усан сангийн эргээс 100 метрээс доошгүй зайд, гол мөрөн дээр байгуулсан усан сангийн хувьд түүний эргээс тухайн гол мөрний онцгой хамгаалалтын бүсийн өргөнтэй тэнцүү хэмжээний зайд;	√	-	-	-	-	-
31.	2.3.4.		Хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 100 метрээс доошгүй, үерийн хамгаалалтын далангаас 50 метрээс доошгүй зайд;	√	-	-	-	-	-
32.	2.3.5.		Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд;	√	-	-	-	-	-
33.	2.3.6.		Үерийн хамгаалалтын суваг, түүний хамгаалалтын далангаас 30 метр хүртэлх зайд	√	-	-	-	-	-

34.	2.4.		Улс ардын аж ахуйд онц ач холбогдолтой мега төслийн байгууламж барих, үерийн хамгаалалт, тохируулгын далан боомт, үерийн ус хуримтлуулах нөөцлүүр зэрэг усны барилга байгууламж болон зам, гүүр, усан зогсоол, ус, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламж бүхий газарт онцгой хамгаалалтын бүс тогтоохгүй.	✓	-	-	-	-
35.	2.5.1.	2.5.Онцгой хамгаалалтын бүсэд дор дурдсанаас бусад бүх төрлийн үйл ажиллагаа явуулахыг болон зуслан, суурьшлын бүс байгуулахыг хориглоно:	Ус хангамжийн эх үүсвэрийн байгууламж барих, ашиглах;	✓	-	-	-	-
36.	2.5.2.		Гадаргын усыг ус хангамжийн эх үүсвэрт ашиглах тохиолдолд гадаргын усыг цэвэршүүлэх байгууламж барих;	✓	-	-	-	-
37.	2.5.3.		Эргийн тохижилт хийх;	✓	-	-	-	-
38.	2.5.4.		Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, гольфоос бусад спорт тоглоомын талбай байгуулах, мод бут сөөг тарих;	✓	-	-	-	-
39.	2.5.5.		Зөвхөн 2.3.1-2.3.3 <sup>47</sup> -д заасан газарт мал бэлчээх;	✓	-	-	-	-
40.	2.5.6.		Хяналт-шинжилгээний цооног гаргах, хяналт-шинжилгээ явуулах.	✓	-	-	-	-
41.	2.6.1.	2.6.Энгийн хамгаалалтын бүсийн заагийг дараах байдлаар тогтооно:	Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд;	✓	-	-	-	-
42.	2.6.2.		Нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 500 метр хүртэлх зайд.	✓	-	-	-	-
43.	2.7.		Хур бороо болон шар усаар түр зуурын хугацаанд тэжээгдэн урсан өнгөрөх, тогтоол ус үүсэхгүй, тогтмол тэжээлгүй голдирол бүхий хуурай сайранд хамгаалалтын бүс тогтоохгүй.	✓	-	-	-	-
44.	2.9.1.	2.9.Энгийн хамгаалалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:	Мод бут огтлох;	✓	-	-	-	-
45.	2.9.2.		Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжгүй буюу ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд холбогдоогүй барилга байгууламж барьж ашиглах;	✓	-	-	-	-
46.	2.9.3.		Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис, цацраг идэвхт бодис, бүх төрлийн бордоо, пестицид хадгалах, ашиглах;	✓	-	-	-	-
47.	2.9.4.		Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;	✓	-	-	-	-
48.	2.9.5.		Хог хаягдал, бохирдуулах бодис хаях, хог хаягдлын цэг байршуулах;	✓	-	-	-	-
49.	2.9.6.		Мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах;	✓	-	-	-	-
50.	2.9.7.		Стандартын шаардлага хангаагүй бохир усны цооног, бие засах газар барьж ашиглах.	✓	-	-	-	-
51.	2.10.		Энгийн хамгаалалтын бүсэд ашигт малтмал хайх, ашиглах харилцааг Усны тухай хуулийн 22.9-д <sup>48</sup> заасны дагуу зохицуулна.	✓	-	-	-	-
52.	2.11.		Энгийн хамгаалалтын бүсэд стратегийн орд ашиглах асуудлыг тухайн усны сан бүхий газрын усны нөөц, горим, гидрогеологийн онцлог нөхцөл, ашиглах технологи зэргийг харгалзан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, усны сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн тусгайлан шийдвэрлэнэ.	✓	-	-	-	-
53.	3.1.	Гурав. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс ба түүний дэглэм	Хүн амын үнд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөц хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтооно.	✓	-	-	-	-
54.	3.2.		Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс нь эрүүл ахуйн хориглолтын ба эрүүл ахуйн хязгаарлалтын бүсээс тогтоно. Ус хангамжийн газрын доорх усны эх үүсвэрт эрүүл ахуйн бүсээс гадна тухайн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийг тогтоож өгнө.	✓	-	-	-	-

<sup>47</sup> 2.3.1-2.3.3. Гол мөрний урсац бүрэлдэх эх хэсэгт түүний эргээс усны хагалбарын хил хүртэлх зайд; Гол мөрөн, горхи, булаг, шандын эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж; Нуур, урсцын тохируулгатай усан сангийн эргээс 100 метрээс доошгүй зайд, гол мөрөн дээр байгуулсан усан сангийн хувьд түүний эргээс тухайн гол мөрний онцгой хамгаалалтын бүсийн өргөнтэй тэнцүү хэмжээний зайд;

<sup>48</sup> 22.9.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглах харилцааг хуулиар зохицуулна.

55.	3.3.		Эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, тогтоох нөхцөл боломж хангагдаагүй болон бүсийн дэглэм зөрчигдөж байгаа усны эх үүсвэрийг хүн амын ус хангамжийн зориулалтаар ашиглахыг хориглоно.	✓	-	-	-	-
56.	3.4.		Ус хангамжийн газрын доорх усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг газрын доорх усны тухайн ордын нөөц тогтоох гидрогеологийн хайгуул, судалгааны ажлын үед нарийвчлан тогтооно. Энэ судалгаагаар тогтоох газрын доорх уст үеийн зузаан, цооног дахь ашиглалтын үеийн ундарга, түвшний бууралт, ус дамжуулах чадвар, шүүрэлтийн коэффициент, нүх сүвшилийн коэффициент, усны урсгалын чиглэл, хурд зэрэг үзүүлэлтийг үндэслэн бүсийн заагийг гидродинамикийн аргаар тооцоолж зураглана. Мэргэжлийн байгууллагын хийсэн уг судалгааны дүнг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дүгнэлт гаргана.	✓	-	-	-	-
57.	3.5.		Ус хангамжийн газрын доорх эх үүсвэрийн тэжээгдлийн мужийг тогтоохдоо тухайн эх үүсвэрийн усны орд газрын усны хуримтлалыг бий болгож байгаа сав газрыг бүхэлд нь хамруулах буюу усны хагалбарын хилээр хязгаарлана.	✓	-	-	-	-
58.	3.6.		Ус хангамжийн гадаргын усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо тухайн усны объектын ус хурах талбайн хөрс, чулуулгийн тогтолцоо, усны горим, чанар, урсцыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүгнэлтийг үндэслэнэ.	✓	-	-	-	-
59.	3.8.1.	3.8.Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд дараах дэглэмийг мөрдөнө:	Эрүүл ахуйн хориглолтын бүсэд гадаргуугийн урсцыг тус бүсээс зайлуулах суваг байгуулна;	✓	-	-	-	-
60.	3.8.2.		Эх үүсвэрийг ашиглах зориулалттай барилга байгууламжийг ариутгах татуургын төвлөрсөн системд холбоно. Хэрэв боломжгүй бол стандартын шаардлага хангасан бохир усны цооног, бие засах газрыг бүсийн гадна байрлуулна;	✓	-	-	-	-
61.	3.8.3.		Ус хангамжийн барилга байгууламжид өргөтгөх, засварлах ажил хийхдээ байгаль орчин, эрүүл ахуйн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэнэ;	✓	-	-	-	-
62.	3.8.4.		Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн эргэн тойрныг хашиж хамгаалан байнгын харуул хамгаалалттай байлгах бөгөөд худаг, усан сангийн таг, салхивчийг битүүмжлэн хялбар нээх, эвдэх боломжгүй болгоно;	✓	-	-	-	-
63.	3.8.5.		Бүсийн талбайг тогтмол цэвэрлэж, хог хаягдлыг зайлуулж, хөнөөлт шавж мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар механик аргаар хийлгэнэ;	✓	-	-	-	-
64.	3.9.1.		3.9. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:	Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;	✓	-	-	-
65.	3.9.2.	Ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах;		✓	-	-	-	-
66.	3.9.3.	Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;		✓	-	-	-	-
67.	3.9.4.	Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;		✓	-	-	-	-
68.	3.9.5.	Судалгаа шинжилгээ, унд ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;		✓	-	-	-	-
69.	3.9.6.	Төвлөрсөн ус хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээтэй газар унд ахуйн зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;		✓	-	-	-	-
70.	3.9.7.	Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;		✓	-	-	-	-
71.	3.9.8.	Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;		✓	-	-	-	-
72.	3.9.9.	Шатахуун түгээх станц байршуулах, машин техник угаах;		✓	-	-	-	-

73.	3.9.10.		Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;	√	-	-	-	-
74.	3.9.11.		Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;	√	-	-	-	-
75.	3.9.12.		Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох.	√	-	-	-	-
76.	3.10.1.	3.10. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөхөөс гадна 3.9 дүгээр зүйлд заасан болон нэмж дараах үйл ажиллагааг хориглоно:	Гаднын хүн орох;	√	-	-	-	-
77.	3.10.2.		Авто тээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах;	√	-	-	-	-
78.	3.10.3.		Мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих.	√	-	-	-	-
79.	3.11.		Ус хангамжийн газрын доорх усны эх үүсвэрийн тэжээгдлийн мужид цацраг идэвхт бодис болон химийн хорт бодис үйлдвэрлэх, тэдгээрийг ашиглан аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	√	-	-	-	-
80.	3.12.		Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, ус түгээх шугам, ус түгээх цэгт эрүүл ахуйн бүс тогтооно.	√	-	-	-	-
81.	3.13.		Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг тогтооно.	√	-	-	-	-
82.	3.14.		Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт хөрсний ус нэвтрэх болон урсгал уснаас шууд тэжээгдэх уст үеэс ус авч ашиглавал эх үүсвэрээс 500 метрээс доошгүй зайд, хөрсний уснаас хамгаалагдсан уст үеэс ус авч ашиглавал 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.	√	-	-	-	-
83.	3.15.		Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт гадаргын усыг ашиглавал түүний эргээс 200 метрээс доошгүй зайд, урсгал усны хувьд урсгалын дээд талд 50 км-ээс доошгүй, доод талд 500 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно. Нийт урт нь 40 км-ээс бага урсгал усыг ус хангамжийн эх үүсвэрт ашиглавал ус хурах талбайг бүхэлд нь хамааруулан эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.	√	-	-	-	-
84.	3.16.		Нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тухайн усны эх үүсвэрийн тэжээгдлийн муж болон түүнтэй гидравлик холбоотой гол, нуурын ус хурах талбайг хамруулан тогтоож болно.	√	-	-	-	-
85.	3.17.		Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойн тэнхлэгээс хоёр тийш 5 метрт эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.	√	-	-	-	-
86.	3.18.		Хот суурин газрын төвлөрсөн бүс ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.	√	-	-	-	-
<b>3. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>								
87.	-	Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ	Хөв цөөрөм байгуулах боломжтой газрын судалгааг хийх	√	-	-	-	-
88.			Ус авах худаг нэмэгдсэн тохиолдолд тухайн ус хангамжийн эх үүсвэрийг тоолууржуулах	√	-	-	-	-
89.			Ус хангамжийн худгуудын тоолуурын заалтыг тогтмол бүртгэх, сумын байцаагч эсвэл байгаль хамгаалагчаар баталгаажуулах ажлыг зохион байгуулах	√	-	-	-	-
90.			Гидрогеологийн хайгуулын ажлын үр дүнг баталгаажуулах	√	-	-	-	-
91.	-		Усыг хэмнэлттэй, зохистой ашиглах сургалт, мэдээллийг ажилтнуудад хийх	√	-	-	-	-

92.			Усны сан бүхий газрын эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах	√	-	-	-	-
93.	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Усны химийн ерөнхий шинжилгээ	√	-	-	-	-
94.	-		Усны хүнд металл	√	-	-	-	-
95.	-		Хөндлөнгийн хяналт шинжилгээ	√	-	-	-	-
<b>Нийт дүн</b>				<b>94</b>	<b>1</b>	-	-	-

### Аудитын үнэлэмж:

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан бөгөөд дараах дөрвөн хэлбэрээр илэрхийлэв.

- ❖ **Нийцэл.** Аудитын шалгуурыг хангасан. Шаардлагатай тохиолдолд сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Сайжруулах шаардлагатай.** Аливаа мэдээлэл дутуугаас тухайн шалгуурыг үнэлэх боломжгүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Хугацаа болоогүй.** Шалгуурыг гүйцэтгэх хугацаа болоогүй. Ирээдүйд хийгдэх ажлууд тул зөвхөн тайлбар бичсэн.
- ❖ **Үл нийцэл.** Аудитын шалгуурыг хангаагүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.

Нийт 116 шалгуурт тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

✓ Нийцэл	94
✓ Сайжруулах шаардлагатай	1
✓ Хугацаа болоогүй	0
✓ Үл нийцэл	0
✓ Хамааралгүй	21

Үнэлэмжийн бүтцийг зургаар үзүүлбэл:




График 3. Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ

### Үл нийцлийн эрсдэл:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, хүрээлэн буй орчны байгалийн бүрдэл хэсгүүд, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ буюу шаардлагуудыг тухайн төсөл хэрэгжүүлэгч биелүүлээгүйгээс аливаа эрсдэл үүсэх бөгөөд үүнээс улбаалан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, байгаль орчин бохирдож, доройтох ба хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Эрсдэлийг үнэлэхдээ дараа хэлбэрүүдийг ашиглав.

- ❖ **Их.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл өндөр. Аудитын багийн ахлагчид даруй мэдэгдэнэ.
- ❖ **Дунд.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл дунд зэрэг.
- ❖ **Бага.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл бага.

Нийт 95 шалгуурын эрсдэлийг тогтооход дараах байдалтай үнэлэгдэв. Эрсдэлийн бүртгэл:

✓ Их	0
✓ Дунд	0
✓ Бага	1
✓ Үгүй	94

Аудит хийлгэгч байгууллага эрсдэлийг хооронд нь ялгалгүйгээр бүгдэд нь анхаарал хандуулан ажиллах шаардлагатай.

Байгаль орчны аудитын явцад дараах эрсдэлүүд ажиглагдлаа. Үүнд:

1. Тус компани нь 2024 онд Хаягдал усны дүгнэлт, хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг авсан боловч ус бохирдуулсны төлбөрийн гэрээг холбогдох төрийн захиргааны байгууллагатай байгуулаагүй ажиллаж байна.

#### **Зөвлөмж:**

Усан орчны менежментийн аудитын үр дүнд дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Үүнд:

1. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээг Алтайн өвөр говийн сав газрын захиргаатай байгуулан ажиллах, гэрээнд заасны дагуу харьяалах татварын албанд төлбөрийг барагдуулан ажиллах.

#### **Аудитын дүгнэлт:**

Усан орчны менежментийн аудитын үр дүнгээс үзвэл үйлчлүүлэгч байгууллага усан орчны хувьд дараах нийцлүүд байна. Үүнд:

1. Мэргэжлийн байгууллагаар 2021 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хийлгүүлж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд үүнд усны асуудлыг бүрэн тусгасан.
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд усан орчинтой холбоотой хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлдэг.
3. Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг холбогдох төрийн захиргааны байгууллагатай жил бүр хийж, ашиглалтын тайланг жил бүр хүргүүлдэг.
4. 2024 оноос Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрлийг төрийн захиргааны холбогдох байгууллагатай байгуулан ажиллаж байгаа.

### 3.2.2. АГААР ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

#### Баталгаажсан нотолгоо:

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгон аудитын явцад цуглуулсан болно. Үүнд:

#### 1. Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ✓ Эвдрэл, элэгдэлд өртсөн, хөрсөн бүрхэвч талхлагдсан хэсгүүдээс тоос шороо агаарт дэгдэх
- ✓ Барилгын ажлын үед машин техникийн яндан, дизель цахилгаан генераторуудаас бохирдуулагчид агаарт хаягдан агаарын чанарт нөлөөлөх
- ✓ Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугианы нөлөөлөх үүсэх ба ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй
- ✓ Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугиан үүсэж, ойролцоо орших нутгийн 1 малчин айлын тав тухад сөргөөр нөлөөлж болзошгүй.

#### 2. Агаарын чанарын гүйцэтгэлийн үр дүн:

#### Агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан:


Тусгай зөвшөөрлийн талбай нь эх газрын говь цөлийн эрс тэс, хахир ширүүн уур амьсгалтай, хур тунадас, чийгшил харьцангуй бага хуурай, хуурайвтар бүс нутаг учраас тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт амархан үүсдэг. Тоосжилтыг багасгах зорилгоор тусгай зөвшөөрлийн талбай доторх замыг "Фалкон дриллинг" ХХК-аар, хээрийн анги орчмыг "Монруд" ХХК-аар, барилгын ажилтай холбоотой зам, талбайн усалгааг ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээлэн өдөр бүр услуулдаг байна. Замын усалгааны хуваарийг 7 хоногоор гаргаж, хуваарийн дагуу усалдаг байна. Ачаа тээврийн зам дагуу Шинэжинст сумын Уртын гол багийн Үзүүр худагаас төслийн талбай хүртэл 1 удаа усалгаа хийдэг байна.

Мөн хээрийн анги, ажлын талбарын орчимд 20 км/цаг, төслийн талбай дотор 40 км/цаг дээд хурдтай явахыг зөвшөөрдөг ба хурдны дээд хязгаарыг заасан 20 км/цаг 2 ш, 40 км/цаг 2 ш тэмдгийг байршуулсан байна.



Зураг 11. Замын усалгаа хийж байгаа байдал

Агаар дахь PM 2.5 болон PM10 тоосонцрын хэмжээг төслийн талбайд суурилуулсан Dust track TSU багажаар 24 цагийн турш тасралтгүй хэмждэг байна. Уг багажийг төслийн үйл ажиллагаанаас үүсэж байгаа тоосыг хэмжих зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайн зүүн урд захад, байгалийн өгөгдлийг цуглуулан харьцуулах зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайн баруун хойд захад тус бүр 1 ш-ийг байрлуулсан байна. Мөн зөөврийн тоос хэмжигч багажаар тусгай зөвшөөрлийн талбай дотор 9 цэгт тоосонцрын хэмжилтийг сар бүр хийдэг байна.



Зураг 12. Аqm-401 станцын хэмжилтийн үр дүн

### Дуу шуугианд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан:

Баянхөндий хээрийн ангид хамгийн их дуу чимээ гаргаж байгаа генераторын өрөөнд дуу чимээний хэмжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 06-нд хийсэн байна. Генераторын өрөөний дуу чимээ 95.3 dBA байсан тул генераторын өрөөнд зөвхөн зөвшөөрөгдсөн хүн нэвтрэх, ажилтан чихний бөглөөг тогтмол хэрэглэх санамжийг байршуулсан байна. Мөн тухайн генераторын байршлыг шилжүүлж хашааны зүүн урд хэсэгт байршуулснаар дуу чимээний нөлөөлөл буурсан.

Барилга угсралтын хүрээнд хэт өндөр дуу шуугианы хэмжилтийг багаж бүр дээр хийж байгаа бөгөөд 85 dBA-с дээш шуугиантай орчинд ажил гүйцэтгэх үед сонсгол хамгаалах хэрэгслийг тогтмол ашигладаг байна.



Зураг 13. Дуу шуугианы хэмжилт

### Аудитын шалгуур:

Хууль тогтоомжийн хүрээнд 40 шалгуур үзүүлэлтээр агаар орчны аудитыг гүйцэтгэв. Нийт 40 шалгуурын 2 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөрт, 12 нь үндэсний хууль тогтоомж, 7 холбогдох дүрэм журам, аргачлалд, 13 нь стандартад, 6 нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгалаа олсон байна.

Аудитын шалгуураар тодорхойгүй болон хамааралгүй гэж үнэлэгдсэн үзүүлэлтийг хасаж, аудитын нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

### Хүснэгт 8. Агаар орчны менежментийн нийцэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэгтгэл

№	Хуулийн заалт	Хамрах хүрээ	Шалгуур үзүүлэлт	Үнэлэмж				
				Нийцэл	Сайжруулах шаардлагатай	Үл нийцэл	Тодорхойгүй	Хамааралгүй
<b>1. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ</b>								
<b>1.1. Агаарын тухай хууль /шинэчилсэн найруулга/</b>								
1.	9.1.1.	9 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг	Агаарын хууль тогтоомж, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, Засаг даргын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;	√	-	-	-	-
2.	9.1.2.		Агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах;	√	-	-	-	-
3.	9.1.3.		Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох;	√	-	-	-	-
4.	9.1.4.		Аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн дагуу дотоод хяналтыг явуулах;	√	-	-	-	-
5.	9.1.5.		Аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг энэ хуулийн 12.5-д <sup>49</sup> заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх;	√	-	-	-	-
6.	9.1.6.		Агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;	√	-	-	-	-
7.	9.1.7.		Агаарын бохирдлыг бууруулах талаарх холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх;	√	-	-	-	-
8.	9.1.8.		Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаахгүй байх;	√	-	-	-	-
9.	9.1.9.		Агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, шингэрүүлсэн хийн түлш, бусад эх үүсвэрийг ашиглах;	√	-	-	-	-
<b>1.2. Агаарын бохирдлын төлбөрийн тухай</b>								
10.	4.1.4.	4 дүгээр зүйл. Агаарын бохирдлын төлбөр төлөгч, түүнийг бүртгэх 4.1.Дор дурдсан иргэн, аж ахуйн	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшигч;	√	-	-	-	-

<sup>49</sup> 12.5.Агаарын чанарын мэдээ гаргах журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.

		нэгж, байгууллага агаарын бохирдлын төлбөр төлөгч байна:						
11.	9.3.	9 дүгээр зүйл.Төлбөр төлөх, тайлагнах	Төлбөр төлөгч нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлөх бөгөөд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэгийн гэрчилгээ нь агаарын бохирдлын төлбөр төлсөн тухай тэмдэглэлтэй байна.	√	-	-	-	-
<b>2. ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ</b>								
<b>2.1. "Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох журам батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 3 дугаар сарын 07 -ны өдрийн А-63/67 тоот хамтарсан тушаал</b>								
12.	1.4.	Нэг. Нийтлэг үндэслэл	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч нь "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хуулийн 7.3-т <sup>50</sup> заасан ангиллын дагуу агаарын бохирдлын төлбөрийг холбогдох татварын албанд мөн хуулийн 9.3-т <sup>51</sup> заасан хугацаанд багтаан төлнө.	√	-	-	-	-
<b>БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛИЙН ҮНЭЛГЭЭ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>								
13.	-	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Замын усалгааг хуваарийн дагуу хийх	√	-	-	-	-
14.	-		Тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцох хурдны дээд хязгаарыг 40 км/цагаас хэтрүүлэхгүй байх	√	-	-	-	-
15.	-		Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн улсын үзлэгт хамруулах	√	-	-	-	-
16.	-		Хэт өндөр дуу шуугиантай (80дВА-аас дээш) орчинд ажилладаг ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл тогтмол ашиглуулах	√	-	-	-	-
17.	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Гадна агаарын чанарын шинжилгээ	√	-	-	-	-
18.	-		Ажлын байрны чанарын шинжилгээ	√	-	-	-	-
19.	-		Хөндлөнгийн хяналт шинжилгээ	√	-	-	-	-
<b>Нийт дүн</b>				<b>19</b>	-	-	-	-

### Аудитын үнэлэмж:

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан бөгөөд дараах дөрвөн хэлбэрээр илэрхийлэв.

- ❖ **Нийцэл.** Аудитын шалгуурыг хангасан. Шаардлагатай тохиолдолд сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Сайжруулах шаардлагатай.** Аливаа мэдээлэл дутуугаас тухайн шалгуурыг үнэлэх боломжгүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Хугацаа болоогүй.** Шалгуурыг гүйцэтгэх хугацаа болоогүй. Ирээдүйд хийгдэх ажлууд тул зөвхөн тайлбар бичсэн.
- ❖ **Үл нийцэл.** Аудитын шалгуурыг хангаагүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.

Нийт 40 шалгуурыг 19 нотолгоо дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

✓ Нийцэл 19

<sup>50</sup> 7.3.Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн төлбөрийг тэдгээрийн ангиллаас хамаарсан хувь, хэмжээгээр дараах байдлаар тогтооно.

<sup>51</sup> 9.3.Төлбөр төлөгч нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох жилийн төлбөрийг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө харьяалах татварын албанд төлөх бөгөөд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэгийн гэрчилгээ нь агаарын бохирдлын төлбөр төлсөн тухай тэмдэглэлтэй байна.

✓ Сайжруулах шаардлагатай	0
✓ Хугацаа болоогүй	0
✓ Үл нийцэл	0
✓ Хамааралгүй	21

Үнэлэмжийн бүтцийг графикт үзүүлбэл:



График 4. Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ

#### Үл нийцлийн эрсдэл:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, хүрээлэн буй орчны байгалийн бүрдэл хэсгүүд, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ буюу шаардлагуудыг тухайн төсөл хэрэгжүүлэгч биелүүлээгүйгээс аливаа эрсдэл үүсэх бөгөөд үүнээс улбаалан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, байгаль орчин бохирдож, доройтох ба хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Эрсдэлийг үнэлэхдээ дараа хэлбэрүүдийг ашиглав.

- ❖ **Их.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл өндөр. Аудитын багийн ахлагчид даруй мэдэгдэнэ.
- ❖ **Дунд.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл дунд зэрэг.
- ❖ **Бага.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл бага.

Нийт 19 шалгуурын эрсдэлийг тогтооход дараах байдалтай үнэлэгдэв. Эрсдэлийн бүртгэл:

✓ Их	0
✓ Дунд	0
✓ Бага	0
✓ Үгүй	19

#### Аудитын дүгнэлт:

Агаар орчны менежментийн аудитын үр дүнгээс үзвэл үйлчлүүлэгч байгууллага усан орчны хувьд дараах нийцлүүд байна. Үүнд:

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд агаар орчинтой холбоотой

хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлдэг.

2. Мэргэжлийн байгууллагаар 2021 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хийлгүүлж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд үүнд агаар орчны асуудлыг бүрэн тусгасан.
3. Агаарт утаа ялгаруулж буй тээврийн хэрэгсэл бүрийг техникийн улсын үзлэгт хамруулсан байна.
4. Технологийн замын усалгаа хийсэн байна.
5. Агаарын чанарын шинжилгээ гүйцэтгэсэн байна.
6. Уурхайн хүнд даацын тээврийн хэрэгсэлд хурдны хязгаар мөрдүүлэх, замын тэмдэг тэмдэглэгээг сэргээн засварласан байна.

### **3.2.3. ХӨРСӨН БҮРХЭВЧ БА ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ**

#### **Баталгаажсан нотолгоо:**

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгон аудитын явцад цуглуулсан болно. Үүнд:

#### **1. Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- ✓ Барилга байгууламжууд барих хөрс хуулалт хийх, уурхайн доторх зам ба талбайд газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх.
- ✓ Хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг стандартын дагуу зөв хадгалж, ашиглах.
- ✓ Тээврийн хэрэгслүүдийн явах эд ангиуд гэмтэх, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ гоожиж, асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй.
- ✓ Барилгын ажлын үед машин, механизмуудын засварын газраас гарсан ашигласан тос, тослох материалыг түр хадгалах саванд цуглуулах, түр хадгалах явцад дамжуулах шугам хоолойн гэмтэл, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдуулж болзошгүй.
- ✓ Ачаа тээврийн ажиллагаанаас олон салаа зам гарган хөрсний элэгдэл үүсгэж болзошгүй.

#### **2. Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч, техникийн нөхөн сэргээлт менежментийн гүйцэтгэлийн үр дүн:**

##### **Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч, техникийн нөхөн сэргээлт:**

Төслийн талбайд баяжуулах үйлдвэрийн барилгын ажил эхэлж, хогийн цэгийг шинээр байгуулсан байна. Барилгатай холбоотой газар шорооны ажил эхлэхээс өмнө газар хөндөх зөвшөөрлийг журмын дагуу олгож, явцын хяналтыг тогтмол тавин ажилласан байна.



*Зураг 14. Баяжуулах үйлдвэрийн барилгын явц*

Хайгуулын цооног өрөмдсөн тухай бүрд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэж, газар хөндөгдөхөөс өмнөх төрхөд ойртуулсан. Усыг дахин ашиглахын тулд өрөмдлөгт хэрэглэж байгаа усыг нүхэнд хуримтлуулж, өрөмдлөг дууссаны дараа нүхэнд үлдсэн усаар цооног өрөмдсөн талбайг усалдаг байна. Ус хуримтлуулах нүхийг ухахдаа 30 см зузаантай хөрсийг тусад нь ялгаж, нүхийг булсны дараа уг хөрсөөр хучилтыг хийдэг байна.



*Зураг 15. Хайгуулын цооног өрөмдөж байгаа үеийн байдал*

Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл, шимт хөрс хуулалтын үзлэгийн талаар болон Ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийн Биологийн төрөл зүйлийн сургалтын материалд тусган боловсруулж, барилгын ерөнхий гүйцэтгэгчид хүргүүлсэн ба туслан гүйцэтгэгч 2 аж ахуйн нэгжүүдийн ахлах ажилтан болон гардан гүйцэтгэгч нарт танилцуулж, гүйцэтгэлийг хангадаг байна.

Сайтын "Ерөнхий зааварчилгаа" болон байгаль орчны мэдлэг олгох сургалтын төлөвлөгөөг боловсруулан, төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулсан

байна. Мөн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны өдөрлөгийг 08 дугаар сарын 19-нд, “Ус хэмнэх аян”-г 10 дугаар сарын 11-ээс 18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтаар байгаль орчныг хамгаалах талаар тогтмол сануулдаг, эдгээрт усыг хэмнэлттэй хэрэглэх, эрчим хүчээ хэмнэх, амьтан үргээж, хөөхгүй, ургамал тасдахгүй байх, гарах хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах, эзлэхүүнийг багасган хаях, байгаль орчинд аюул учруулж болзошгүй зүйлсийг мэдээлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг байна.




*Зураг 16. Байгаль орчны мэдлэг олгох сургалт*

Замын хөдөлгөөнд оролцохдоо тогтоосон замаар зорчдог ба замыг өргөсгөхгүй байхыг эрхэмлэн тухайн тээврийн хэрэгслээс том оврын тээврийн хэрэгсэлд зам тавьж өгөн, зогсож өнгөрүүлдэг. Ачаа тээврийн болон төслийн талбай доторх дотоод замын маршрутыг шинэчлэн гаргаж, маршрутын дагуу зорчдог байна.




*Зураг 17. Дотоод зам байгуулсан байдал*



Зураг 18. Төслийн талбай доторх замын маршрут

Төслийн талбайд Замын хөдөлгөөний тухай хуулийн дагуу тэмдэг, тэмдэглэгээг байршуулах шаардлагатай газруудад тэмдэг тэмдэглэгээг төлөвлөсөн байна. Барилгын үе шатнаас эхлэн 71 ш замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах шаардлагатай бүртгэл гарсан байна.


Одоогийн байдлаар 4 төрлийн 20 ш тэмдэг, 1200 ширхэг гэрэл ойлгогч бүхий замын шонг байршуулж, замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.



Зураг 19. Замын тэмдэг


Замын хөдөлгөөний журмын дагуу хээрийн анги, ажлын талбарын орчимд 20 км/цаг, төслийн талбай дотор 40 км/цаг дээд хурдтай явах хурдны дээд хязгаарыг баталж, жолооч нарт танилцуулан ажиллаж байна. Тусгай зөвшөөрлийн талбайн хойд хил, кемпээс 2 км-ын зайд хурдны дээд хязгаарыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан (20 км/цаг 2ш, 40 км/цаг 2ш).

Ачаа тээврийн үйлчилгээг үзүүлж байгаа “Пик Пак Ворлдвайд” ХХК-ийн 9 ачааны машин GPS суурилуулсан бөгөөд ачаа тээвэр гүйцэтгэж байгаа цуваа тус бүрд хамгийн багадаа нэг GPS-тэй машин явуулах шаардлагыг гүйцэтгэгчид тавьдаг байна. Улаанбаатар, Баянхонгор хот хооронд зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгэж байгаа “Лотот” ХХК-ийн 30 автобус GPS суурилуулсан байна.



Зураг 20. Тээврийн хэрэгслийн GPS

Төслийн талбайд “Асгаралтын хариу арга хэмжээний журам”-ыг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр гүйцэтгэх захирлын EM2023/0002.01 тоот тушаалаар батлуулан ажилтнуудад танилцуулсан.



Зураг 21. Асгаралтын хариу арга хэмжээний журам

### Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбайд 500 ширхэг шингээх материалыг 2022 онд худалдан авч, шатахуун хадгалах цэгт шаардлагатай хэмжээгээр байрлуулсан байна. Шатахуун хадгалах цэгт 100 ш, генераторын өрөөнд 100 ш шингээгч материалыг байршуулан, үлдсэнийг нь хэрэглэхэд бэлэн нөөцөд хадгалж байна.

Шатах, тослох материалаар бохирдсон хөрс хадгалах 10x25 м хэмжээтэй талбайг талбайг бэлтгэн тусгаарлагч плёнка дэвсэн хөрснөөс тусгаарласан.

Тээврийн хэрэгслийн хяналтын улсын үзлэгт орсон тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулдаг. Төслийн талбай дээр ХАБАЭ мэргэжилтнүүд өдөр бүр тээврийн хэрэгслийг ажилд гарахаас өмнө үзлэг шалгалтыг хийж ажилладаг байна.

Аюултай хог хаягдлыг тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй “Хай би ойл” ХХК-тай “Аюултай хог хаягдал нийлүүлэх гэрээ”-г 2022 оны 7 дугаар сарын 01-нд байгуулсан. Барилга угсралт, хээрийн ангийн, хайгуулын үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал ялгараагүй.

Хог хаягдлын цэгийг шинээр байгуулан аюултай хог хадгалах 10x25 м хэмжээтэй талбайг бэлдэж, журамд заасны дагуу хөрсөнд тос шингэхээс сэргийлэх зорилгоор бетондсон байна.



Зураг 22. Саармагжуулах талбай

### 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Баянхөндий төслийн барилгажилт, уурхайн олборлолтын үе шатуудад эвдрэх газрын хэмжээг хамгийн бага байлгах үүднээс төслийн талбайд газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийг авч ажилладаг байна. Мөн нөхөн сэргээлтийн ажилд бэлдэх үүднээс байгалийн ургамал үржүүлгийн газар байгуулж, тодорхой хэмжээний ургамлын үр бэлдэж, үрээр үржүүлэх, тарьц суулгац бэлдэх ажлыг 2022 оноос эхлүүлсэн байна.

#### Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт:

- ✓ Шимт хөрсийг овоолгод тогтвортой байршуулж, нөхөн сэргээлтэд ашиглахад бэлтгэх
- ✓ Байгалийн ургамал үржүүлгийн газрыг бэхжүүлэх
- ✓ Газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах

#### Нөхөн сэргээлтийн арга хэмжээ:

- ✓ Төслийн барилгажилтын үед 24.77 га талбайгаас 0.3 м зузаантай хуулсан шимт болон шимэрхэг хөрсийг, талбай руу тээвэрлэх, овоолго үүсгэх
- ✓ Шимт хөрсний овоолго үүсгэсэн тохиолдолд хөрсний үржил, шимт чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор ургамал тарих
- ✓ Хүлэмжийн усалгааны системийг сайжруулах
- ✓ Нутгийн ургамлын үрээр тариалалт хийх
- ✓ Зөвшөөрлийн дагуу нутгийн ургамлын үр түүх
- ✓ Нөлөөлөлд өртөх ховор ургамлыг шилжүүлэн тарих талбайн хөрс сайжруулах
- ✓ Цооног өрөмдсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийн стандартыг баримтлан анхны төрхөд ойртуулах


#### Хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- ✓ Шимт хөрсний овоолгыг стандарт болон БОННУ-д тусгагдсаны дагуу 5 хүртэл метрийн өндөртэй, 60 м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэж байна.

#### Барилгын үе шатанд

- ✓ 125843 м<sup>3</sup> шимт хөрс хуулагдахаас 29323 м<sup>3</sup> шимт хөрсийг овоолгод байршуулсан.
- ✓ Шимт хөрсний овоолгыг 5 хүртэл метрийн өндөртэй, 60 м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэснээр хөрсөн дэх үрээр ургамал ургах нөхцөлийг бүрдүүлсэн.
- ✓ Хойд эгнээнд 3 м өндөр 60 м урт овоолгод 10 сарын 01-нд 180 м<sup>2</sup> талбайд зээргэнэ 500 гр, хайлаас 750 гр, чихэр өвс 950 гр нийт 2200 гр үрээр тарилт хийсэн.
- ✓ Байгалийн ургамал үржүүлгийн газрын 2 га талбайг байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20 тн багтаамжтай 2 контейнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч хийсэн ба 5 тн багтаамжтай нөөцийн сав 5 ш байршуулах ажлыг 2022 онд хийсэн байна.
- ✓ Шинэ кэмгийн худгаас Ургамал үржүүлгийн газар хүртэл 200 м далд шугамаар усыг татан 20 тн усны саванд хуримтлуулж, хуримтлуулсан уснаас

- 6 хүлэмж болон талбайн усалгааг хийдэг. Мөнх ногоон тал ХХК-аар 6 хүлэмжийн усалгааны системийг суурилуулах ажлыг гүйцэтгүүлсэн.
- ✓ Өмнө жил түүсэн нутгийн ургамлын үрээр хайлаас 23352, заг 20649, хотир 2669, сухай 1569, агч 1957, жигд 2703, шар хуайс 910, бүйлс 3095, лидэр 230 тоорой 5118 ш үрсэлгээг ургуулсан, амьдралт 95 хувьтай байна.
  - ✓ Дараа жилүүдийн тариалалтад хэрэглэх, нутгийн ургамлын үрийн сан бүрдүүлэх, нөхөн сэргээлтэд нутгийн ургамал хэрэглэх зорилгоор шар хотирын 4.4 кг, сухайн 0.4кг, лидэр 2.5кг, чихэр өвс 2.1 кг жигд 3кг, агч 5 кг үр түүсэн. Загийн үр боловсрохоор 50 кг хүртэл, 2024 оны 02 сард 20,000ш сухайн мөчир бэлтгэхээр төлөвлөж байна.
  - ✓ Газар шорооны ажил эхлэхийн өмнөх үзлэгээр шилжүүлэн тарих шаардлагатай нөн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй. Үрээр тариалалтыг бортогонд хийсэн бөгөөд хөрсийг элс, бууц, био ялзмаг холин бэлдсэн. Компост бордоо бэлдэх зорилгоор 1 м гүнтэй 2 м урт нүхэнд хүнсний ногооны хальс, цай кофены шаар, салфетикийг хуримтлуулж байна.
  - ✓ Хөндий талбайд 33 цооног 1810 т.м өрөмдлөг, 12 суваг 937.8 м<sup>3</sup> суваг малталтын ажил хийсэн. Цооног өрөмдсөн, суваг малтсан тухай бүрд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэхийг эрхэмлэн, анхны төрхөд ойртуулж, ойр орчмын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж дууссаны дараа уг талбайг хүлээн авдаг.
  - ✓ Салаа зам гаргасан болон эвдрэлд оруулсан, зорчих шаардлагагүй замыг тор татан хааж, дахин тээврийн хэрэгсэл зорчихгүй байх арга хэмжээг авдаг байна.
  - ✓ Шимт хөрсний овоолгыг стандарт болон БОННУ-д тусгагдсны дагуу 5 хүртэл метрийн өндөртэй, 60м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэж байна. Барилгын үе шатанд 125843 м<sup>3</sup> шимт хөрс хуулагдахаас 29323 м<sup>3</sup> шимт хөрсийг овоолгод байршуулсан байна.



Зураг 23. Шимт хөрсний овоолго байгуулсан байдал

Шимт хөрсний овоолгыг 5 хүртэл метрийн өндөртэй, 60 м урттай, эгнээ хооронд 10 м зайтай үүсгэснээр хөрсөн дэх үрээр ургамал ургах нөхцөлийг бүрдүүлсэн. Хойд эгнээнд 3 м өндөр 60 м урт овоолгод 10 сарын 01-нд 180 м<sup>2</sup> талбайд зээргэнэ 500гр, хайлаас 750 гр, чихэр өвс 950 гр нийт 2200 гр үрээр тарилт хийсэн.



*Зураг 24. Шимт хөрсний овоолго дээр тарилт хийж байгаа байдал*

Хөндий талбайн Хар морь хэсэгт хайгуулын ажил үргэлжлэн явагдаж 33 цооног 1810 т.м өрөмдлөг, 12 суваг 937.8 м<sup>3</sup> суваг малталтын ажил хийсэн. Цооног өрөмдсөн, суваг малтсан тухай бүрд уг талбайд техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийлгэхийг эрхэмлэн, анхны төрхөд ойртуулж, ойр орчмын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж дууссаны дараа уг талбайг хүлээн авдаг байна. Салаа зам гаргасан болон эвдрэлд оруулсан, зорчих шаардлагагүй замыг тор татан хааж, дахин тээврийн хэрэгсэл зорчихгүй байх арга хэмжээг авдаг байна.



*Зураг 25. Суваг малтахын өмнө болон дараа*

**Аудитын шалгуур:**

Хууль тогтоомжийн хүрээнд 37 шалгуур үзүүлэлтээр хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежментийн аудитыг гүйцэтгэв. Нийт 37 шалгуурын 1 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөрт, 9 нь үндэсний хууль тогтоомж, 7 холбогдох дүрэм журам, аргачлалд, 9 нь стандартад, 11 нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгалаа олсон байна.

Аудитын шалгуураар тодорхойгүй болон хамааралгүй гэж үнэлэгдсэн үзүүлэлтийг хасаж, аудитын нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 9. Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн нийцэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэгтгэл*

№	Хуулийн заалт	Хамрах хүрээ	Шалгуур үзүүлэлт	Үнэлэмж				
				Нийцэл	Сайжруулах шаардлагатай	Үл нийцэл	Тодорхойгүй	Хамааралгүй
<b>1. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ</b>								
<b>1.1. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай</b>								
1.	7.2.1.	7.2. Хот тосгон, суурин газрын хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон цэгээс бусад газарт хөрсийг хог хаягдлаар бохирдуулахгүй байх;	√	-	-	-	-
2.	7.2.2.		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эрүүл ахуйн шаардлага хангасан бохир ус зайлуулах байгууламжтай байх;	√	-	-	-	-
3.	7.2.3.		Барилга байгууламж барьж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын ажлын явцад болон дууссаны дараа эвдэрсэн газрын хөрсийг нөхөн сэргээх;	-	√	-	-	-
4.	7.2.4.		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн болон өмчлөлийн газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх;	√	-	-	-	-
5.	7.2.5.		Тогтоосон авто зогсоол болон авто замын зорчих хэсгээс бусад газарт тээврийн хэрэгсэл зогсоох, зорчихыг хориглох.	√	-	-	-	-
6.	9.1.	<b>9 дүгээр зүйл. Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг</b>	Хөрсийг доройтуулж, цөлжилт үүсэх нөхцөл бүрдүүлсэн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, хөрсний бохирдлыг арилгах, нөхөн сэргээх түүнд хариуцлага хүлээлгэх талаар эрх бүхий албан тушаалтнаас шаардах;	√	-	-	-	-
7.	9.2.		Хөрсний доройтол, цөлжилтийн талаар үнэн зөв мэдээллийг эрх бүхий байгууллагаас авах, өгөх;	√	-	-	-	-
8.	9.3.		Өөрийн хууль бус үйл ажиллагаанаас хөрсийг доройтуулсан бол хохирлыг арилгаж, хөрсийг нөхөн сэргээх.	√	-	-	-	-
<b>2. ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ</b>								
<b>2.1. "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал" батлах тухай БОНХАЖС-ын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/138 тушаал</b>								
9.	-	БОНХАЖС-ын 2015 оны А/138 дугаар тушаалын хавсралт	Аргачлалд заасны дагуу техникийн нөхөн сэргээлт хийгдсэн эсэх	√	-	-	-	-
<b>2.2. "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" батлах тухай БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаал</b>								
10.	4.9.	Дөрөв. Тухайн	Ажлын хэсэг тухайн жилийн байгаль орчны	√	-	-	-	-

		жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, зөвхөн батлагдсан төлөвлөгөөнд тусгасан ажлуудын гүйцэтгэлд үндэслэн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байлцуулан, энэхүү журмын 4-р хавсралтад заасны дагуу арга хэмжээний чиглэл тус бүрээр оноогоор тооцож, биелэлтийг нь нэгтгэн гаргаж, газар дээр нь баталгаажуулан гарын үсэг зурж, төсөл хэрэгжүүлэгчид 1 хувийг хадгалуулна.						
11.	4.10.		Улирлын чанартай ажилладаг уурхайн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг талбай дээр бодитоор нь үнэлэх, хэмжилт хийх боломжтой нөхцөлд зохион байгуулна.	√	-	-	-	-	
12.	6.3.	Зургаа. Бусад	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авч дүгнэх, дараа жилийн төлөвлөгөөг хянан батлах асуудлыг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага энэ журмын хавсралт 4 болон 6-д заасан баримт бичиг, мэдээллийн бүрдлийг үндэслэн ажлын 14 хоногт багтааж, шийдвэрлэнэ.		-	-	-	-	
<b>3. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>									
13.	-	Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх	√	-	-	-	-	
14.	-		Үйл ажиллагааны багуудад газар шорооны ажил эхлэх зөвшөөрөл олгохтой холбоотой сургалт зохион байгуулах	√	-	-	-	-	
15.	-		Барилга байгууламж барих үйл ажиллагааны үед олон салаа зам гаргахгүй, шаардлагатай тохиолдолд дотоод замын маршрутыг шинэчлэн батлаж, мөрдүүлэх	√	-	-	-	-	
16.	-		Шаардлагатай цэгүүдэд замын тэмдэг байрлуулах	√	-	-	-	-	
17.	-		Шимт болон шимэрхэг хөрсний үржил шим алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (5 метрээс өндөргүй овоолох)	√	-	-	-	-	
18.	-		Асгаралтаас урьдчилан сэргийлэх, асгаралтад авах арга хэмжээний дотоод журмыг хэрэгжүүлэх	√	-	-	-	-	
19.	-		Авто машины засварын газраас гарах ашигласан тос, тосолгооны материалыг зориулалтын саванд хуульд заасан хугацаанд түр хадгалах	√	-	-	-	-	
20.	-		Шаардлагатай цэгүүдэд замыг сайжруулах ажлыг зохион байгуулах	√	-	-	-	-	
21.	-		Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Хөрсний химийн ерөнхий шинжилгээ	√	-	-	-	-
22.	-			Хөрсний хүнд металл	√	-	-	-	-
23.	-		Хөндлөнгийн хяналт шинжилгээ	√	-	-	-	-	
<b>Нийт дүн</b>				<b>22</b>	<b>1</b>	-	-	-	

**Аудитын үнэлэмж:**

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан бөгөөд дараах дөрвөн хэлбэрээр илэрхийлэв.

- ❖ **Нийцэл.** Аудитын шалгуурыг хангасан. Шаардлагатай тохиолдолд сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Сайжруулах шаардлагатай.** Аливаа мэдээлэл дутуугаас тухайн шалгуурыг үнэлэх боломжгүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Хугацаа болоогүй.** Шалгуурыг гүйцэтгэх хугацаа болоогүй. Ирээдүйд хийгдэх ажлууд тул зөвхөн тайлбар бичсэн.

- ❖ **Үл нийцэл.** Аудитын шалгуурыг хангаагүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.

Нийт 37 шалгуурыг 23 нотолгоо дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

✓ Нийцэл	22
✓ Сайжруулах шаардлагатай	1
✓ Хугацаа болоогүй	0
✓ Үл нийцэл	0
✓ Хамааралгүй	14

Үнэлэмжийн бүтцийг графикт үзүүлбэл:




График 5. Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ

### Үл нийцлийн эрсдэл:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, хүрээлэн буй орчны байгалийн бүрдэл хэсгүүд, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ буюу шаардлагуудыг тухайн төсөл хэрэгжүүлэгч биелүүлээгүйгээс аливаа эрсдэл үүсэх бөгөөд үүнээс улбаалан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, байгаль орчин бохирдож, доройтох ба хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Эрсдэлийг үнэлэхдээ дараа хэлбэрүүдийг ашиглав.

- ❖ **Их.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл өндөр. Аудитын багийн ахлагчид даруй мэдэгдэнэ.
- ❖ **Дунд.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл дунд зэрэг.
- ❖ **Бага.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл бага.

Нийт 23 шалгуурын эрсдэлийг тогтооход дараах байдалтай үнэлэгдэв. Эрсдэлийн бүртгэл:

✓ Их	0
✓ Дунд	0
✓ Бага	1
✓ Үгүй	22

Аудит хийлгэгч байгууллага эрсдэлийг хооронд нь ялгалгүйгээр бүгдэд нь анхаарал хандуулан ажиллах шаардлагатай.

Байгаль орчны аудитын явцад дараах эрсдэлүүд ажиглагдлаа. Үүнд:

1. Уурхайн тосгон болон бусад дэд бүтцийн барилга байгууламжийн ойролцоох талбай элэгдэл эвдрэлд өртөх

#### **Зөвлөмж:**

Хөрсөн орчны менежментийн аудитын үр дүнд дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Үүнд:

1. Уурхайн тосгон болон бусад дэд бүтцийн барилга байгууламжийн ойролцоох элэгдсэн хөрстэй талбайг тухай бүр нөхөн сэргээх, ургамалжуулах

#### **Аудитын дүгнэлт:**

Хөрсөн орчны менежментийн аудитын үр дүнгээс үзвэл үйлчлүүлэгч байгууллага хөрсөн орчны хувьд дараах нийцлүүд байна. Үүнд:

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хөрсөн орчинтой холбоотой хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлдэг.
2. Мэргэжлийн байгууллагаар 2021 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хийлгүүлж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд үүнд хөрсөн орчны асуудлыг бүрэн тусгасан.
3. Ашиглагдахгүй болсон зам, хайгуулын сувагт техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.
4. Цөлжилтийн хяналт шинжилгээ судалгааг дотооддоо зохион байгуулсан байна.
5. Ашиглалтын үед үүссэн жижиг талбай, эвдрэлийг тэгшилж хэлбэржүүлсэн байна.
6. Барилгын ажлын үед шимт хөрсийг хуулж шимт хөрсний талбайд байршуулах, шимт хөрсийг хэлбэржүүлж стандартын дагуу хадгалсан байна.

### **3.2.4. УРГАМЛАН НӨМРӨГ БА БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ**

#### **Баталгаажсан нотолгоо:**

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгон аудитын явцад цуглуулсан болно. Үүнд:

#### **1. Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- ✓ Уурхайн түр байгууламжууд, агуулах барих, зам засах үед ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдах
- ✓ Түр байгууламжууд, агуулах барих, зам засахад ховор ургамлууд нөлөөлөлд өртөх
- ✓ Хүн амын суурьшил нэмэгдсэнээр заг, бутлаг ургамлыг түүж болзошгүй
- ✓ Байгаль орчны мэдлэг дутуугаас ургамал тасдаж болзошгүй

#### **2. Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн үр дүн:**

**Ургамлан нөмрөгт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан**

Газар шорооны ажил эхлэхийн өмнө уг талбайд ховор болон нэн ургамал илэрсэн тохиолдолд шилжүүлэн суулгах зорилгоор үзлэг хийн ургамлыг бүртгэдэг байна.

Нөлөөлөлд өртөх шилжүүлэн тарих шаардлагатай ургамжлын жагсаалтыг гаргаж, байгалийн ургамал үржүүлгийн газарт ургамал шилжүүлэн тарих 400 м<sup>2</sup> талбайг бэлдсэн байна.



*Зураг 26. Шилжүүлэн тариалалтын талбай*

Улаанбаатар хотоос төслийн талбай хүртэлх тээвэрлэлтийг ерөнхий гүйцэтгэгч "Эм-Си-Эс Проперти" ХХК, хүнс тээврийг "Монруд" ХХК, орон нутгийн ажилчдын ээлж солих тээвэрлэлтийг "Залаагийн тээвэрчид" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгэдэг байна. Тээврийн хэрэгсэл төслийн талбайд ирэх, явах тохиолдол бүрд, ажилд гарахын өмнө үзлэг шалгалтыг тогтмол хийж хэвшсэн байна. Ажилтнуудад талбайн Ерөнхий зааварчилгаагаар заг, бутлаг ургамал түүхийг хориглосон мэдээллийг тогтмол өгч ажилладаг байна.

Ажилтнууд ээлжид ирэх, буух бүрд цүнхний үзлэгийг хийдэг байна. 2023 онд 1800 орчим удаа тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийсэн. Заг бутлаг ургамал хадгалсан, тээвэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Төслийн талбайд шинээр ирж ажиллах тухай бүрд "Ерөнхий зааварчилгаа"-г өгч, шалгалт авдаг ба шалгалтын дүн 80-аас доош хувь үнэлэгдсэн тохиолдолд давтан зааварчилгаанд хамрагддаг. Ерөнхий зааварчилгаа, Байгаль хамгаалах арга хэмжээ, Биологийн төрөл зүйл сургалтын хүрээнд ургамлыг тасдахгүй байхыг хориглосон мэдээллийг тогтмол өгч ажилладаг байна.

#### **Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт:**

Баянхөндий хээрийн ангийг тохижуулах, цэцэрлэгжүүлэх ажлын хүрээнд гэрүүд, оффис, гал тогоо, ариун цэврийн өрөө хооронд хайрган замыг гаргасан ба оффис, амралтын өрөө, ариун цэврийн өрөө, амралтын өрөөний урд талд өмнөх жилүүдэд үрээр тарьсан заг, хайлаас, мөчрөөр тарьсан сухай, суулгацаар тарьсан саваа улиас, тоорой ургаж байна. Төслийн оффисын хойд талд 50 ш хайлаас, Анхны тусламжийн цэгийн урд талын цэцгийн мандалд 30 ш мандлын цэцэг тарьсан.



Зураг 27. Кэмпийн тохижилт, цэцэрлэгжүүлэлт

#### **Нөхөн сэргээлтийн зорилт**

- ✓ Хээрийн ангийн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

#### **Нөхөн сэргээлтийн арга хэмжээ**

- ✓ Намрын тариалалтаар тариалсан суулгацыг арчилж ургуулах, хайлаасыг үрээр, нэг наст цэцэг тарих

#### **Хэрэгжүүлсэн арга хэмжээ**

- ✓ Баянхөндий хээрийн анги нь 2 га талбайтай, үүнээс 2018-2021 онуудад тариалалт хийсэн талбай 40 м<sup>2</sup>, 2022 онд 127 м зурвас талбайд ургамал тариалсан. Тайлант онд дээрх талбайнуудын усалгаа, арчилгааг хийхийн зэрэгцээ шинээр оффисын хойд талд 50 ш хайлаас, Анхны тусламжийн цэгийн урд талын цэцгийн мандалд 30 ш мандлын цэцэг тарьсан.

### **3. Байгалийн ургамал, үржүүлгийн талбай**

Байгалийн ургамал үржүүлгийн газрыг 2 га талбайд байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20 тн багтаамжтай 2 контейнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч хийсэн ба 5 тн багтаамжтай нөөцийн сав 5 ш байршуулах ажлыг 2022 онд хийсэн байна. Шинэ кэмпийн худгаас Ургамал үржүүлгийн газар хүртэл 200 м далд шугамаар усыг татан 20 тн усны саванд хуримтлуулж, хуримтлуулсан уснаас 6 хүлэмж болон талбайн усалгааг хийдэг байна. “Мөнх ногоон тал” ХХК-аар 6 хүлэмжийн усалгааны системийг суурилуулах ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Хүснэгт 10. 2023 оны тариалалтын мэдээ

№	Ургамлын нэр	Ургасан тоо	Тариалалт	Өвөлжилтөд бэлтгэсэн
1	Заг	2669	Үрээр	Хүлэмжид бортогонд
2	Хайлаас	23352	Үрээр	Хүлэмжид бортогонд
3	Хотир	2669	Үрээр	Хүлэмжид бортогонд
4	Хармаг	280	Үрээр	Хүлэмжид бортогонд
5	Агч	1957	Үрээр	Хүлэмжид бортогонд
6	Сухай	1569	Мөчрөөр	Хүлэмжид бортогонд
7	Тоорой	5118	Үрээр	Хүлэмжид бортогонд
8	Жигд	2703	Үрээр	Хүлэмжид бортогонд
9	Шар хуайс	910	Үрээр	Хүлэмжид бортогонд
10	Бүйлс	3095	Үрээр	Хүлэмжид бортогонд
11	Лидэр	230	Үрээр	Хүлэмжид бортогонд
<b>Дүн</b>			<b>62532</b>	





Зураг 28. Хүлэмжийн аж ахуйн ерөнхий харагдах байдал



Зураг 29. Байгалийн ургамал, мод үржүүлгийн харагдах байдал

Дараа жилүүдийн тариалалтад хэрэглэх, нутгийн ургамлын үрийн сан бүрдүүлэх, нөхөн сэргээлтэд нутгийн ургамал хэрэглэх зорилгоор шар хотирын 4.4кг, сухайн 0.4кг, лидэр 2.5кг, чихэр өвс 2.1 кг жигд 3кг, агч 5 кг үр түүсэн. Загийн үр боловсрохоор 50 кг хүртэл, 2024 оны 02 дугаар сард 20,000 ш сухайн мөчир бэлтгэхээр төлөвлөж байна.



Зураг 30. Түүсэн үрийг хадгалсан байдал



Зураг 31. Хуримтлуулах усан сан байгуулсан байдал

### **Аудитын шалгуур:**

Хууль тогтоомжийн хүрээнд 30 шалгуур үзүүлэлтээр ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежментийн аудитыг гүйцэтгэв. Нийт 30 шалгуурын 2 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөрт, 10 нь үндэсний хууль тогтоомж, 9 холбогдох дүрэм журам, аргачлалд, 2 нь стандартад, 7 нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгалаа олсон байна.

Аудитын шалгуураар тодорхойгүй болон хамааралгүй гэж үнэлэгдсэн үзүүлэлтийг хасаж, аудитын нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 11. Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн нийцэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэгтгэл

№	Хуулийн заалт	Хамрах хүрээ	Шалгуур үзүүлэлт	Үнэлэмж				
				Нийцэл	Сайжруулах шаардлагатай	Үл нийцэл	Тодорхойгүй	Хамааралгүй
<b>1. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ</b>								
<b>1.1. Ургамал хамгааллын тухай /шинэчилсэн найруулга/</b>								
1.	7.1.	7 дугаар зүйл. Ургамлыг хамгаалах	Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.	√	-	-	-	-
2.	7.4.		Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавжаас хамгаалахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид *төрийн захиргааны төв байгууллага* гэх/-ын зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно.	√	-	-	-	-
3.	9.1.	9 дүгээр зүйл. Ургамлыг нөхөн сэргээх	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газраа зохих журмын дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх буюу нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлсний дараа сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.	√	-	-	-	-
<b>1.2. Газрын тухай /шинэчилсэн найруулга/</b>								
4.	56.6.	56 дугаар зүйл. Хот, тосгон, бусад суурины газрыг зохистой ашиглах, хамгаалах	Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.	-	√	-	-	-
<b>2. ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ</b>								
<b>2.1. "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал" батлах тухай БОНХАЖС-ын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/138 тушаал</b>								
5.	-	БОНХАЖС-ын 2015 оны А/138 дугаар тушаалын хавсралт	Аргачлалд заасны дагуу биологийн нөхөн сэргээлт хийгдсэн эсэх	√	-	-	-	-
<b>2.2. "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" батлах тухай БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаал</b>								
6.	4.9.	Дөрөв. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Ажлын хэсэг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, зөвхөн батлагдсан төлөвлөгөөнд тусгасан ажлуудын гүйцэтгэлд үндэслэн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байлцуулан, энэхүү журмын 4-р хавсралтад заасны дагуу арга хэмжээний чиглэл тус бүрээр оноогоор тооцож, биелэлтийг нь нэгтгэн гаргаж, газар дээр нь баталгаажуулан гарын үсэг зурж, төсөл хэрэгжүүлэгчид 1 хувийг хадгалуулна.	√	-	-	-	-
7.	4.10.		Улирлын чанартай ажилладаг уурхайн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг талбай дээр бодитоор нь үнэлэх, хэмжилт хийх боломжтой нөхцөлд зохион байгуулна.	√	-	-	-	-
8.	6.3.	Зургаа. Бусад	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээн авч дүгнэх, дараа жилийн төлөвлөгөөг хянан батлах асуудлыг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага энэ журмын хавсралт 4 болон 6-д заасан баримт бичиг, мэдээллийн бүрдлийг үндэслэн ажлын 14 хоногт багтааж, шийдвэрлэнэ.	√	-	-	-	-
<b>3. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>								

9.	-	Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ	Уурхайн барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтаар үүссэн түр, зам талбайг хааж, байгалийн аясаар ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх	✓	-	-	-	-
10.			Газар хөндөлтийн өмнө тухайн талбай дахь нэн ховор, ховор ургамлыг бүртгэх	✓	-	-	-	-
11.			Нөлөөлөлд өртөх ховор зүйлийн ургамлыг шилжүүлэн тарих	✓	-	-	-	-
12.			Хууль бусаар ургамал түүх, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглон, уурхайн шалган нэвтрүүлэх хэсэг, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийх	✓	-	-	-	-
			Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Биологийн олон янз байдлын мэдлэг олгох” сургалтад хамруулах	✓	-	-	-	-
13.	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Ургамлан нөмрөгийн судалгаа	✓	-	-	-	-
14.	-		Хөндлөнгийн хяналт шинжилгээ	✓	-	-	-	-
<b>Нийт дүн</b>				<b>13</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Аудитын үнэлэмж:

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан бөгөөд дараах дөрвөн хэлбэрээр илэрхийлэв.

- ❖ **Нийцэл.** Аудитын шалгуурыг хангасан. Шаардлагатай тохиолдолд сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Сайжруулах шаардлагатай.** Аливаа мэдээлэл дутуугаас тухайн шалгуурыг үнэлэх боломжгүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Хугацаа болоогүй.** Шалгуурыг гүйцэтгэх хугацаа болоогүй. Ирээдүйд хийгдэх ажлууд тул зөвхөн тайлбар бичсэн.
- ❖ **Үл нийцэл.** Аудитын шалгуурыг хангаагүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.

Нийт 30 шалгуурыг 14 нотолгоо дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

✓ Нийцэл	13
✓ Сайжруулах шаардлагатай	1
✓ Хугацаа болоогүй	0
✓ Үл нийцэл	0
✓ Хамааралгүй	16

Үнэлэмжийн бүтцийг графикт үзүүлбэл:




График 6. Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ

### Үл нийцлийн эрсдэл:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, хүрээлэн буй орчны байгалийн бүрдэл хэсгүүд, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ буюу шаардлагуудыг тухайн төсөл хэрэгжүүлэгч биелүүлээгүйгээс аливаа эрсдэл үүсэх бөгөөд үүнээс улбаалан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, байгаль орчин бохирдож, доройтох ба хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Эрсдэлийг үнэлэхдээ дараа хэлбэрүүдийг ашиглав.

- ❖ **Их.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл өндөр. Аудитын багийн ахлагчид даруй мэдэгдэнэ.
- ❖ **Дунд.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл дунд зэрэг.
- ❖ **Бага.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл бага.

Нийт 14 шалгуурын эрсдэлийг тогтооход дараах байдалтай үнэлэгдэв. Эрсдэлийн бүртгэл:

✓ Их	0
✓ Дунд	0
✓ Бага	1
✓ Үгүй	13

Аудит хийлгэгч байгууллага эрсдэлийг хооронд нь ялгалгүйгээр бүгдэд нь анхаарал хандуулан ажиллах шаардлагатай.

Байгаль орчны аудитын явцад дараах эрсдэлүүд ажиглагдлаа. Үүнд:

1. Ногоон байгууламжийн төлөвлөгөөг маш сайн хэрэгжүүлдэг боловч Газар эзэмшигч нь Монгол улсын газрын тухай хуулийн 56.6-д заасны дагуу тухайн аж ахуйн эзэмшил газрынхаа өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10%-аас доошгүй талбайд ногоон байгууламж бий болоогүй байна.

### Зөвлөмж:

Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн чиглэлд хийсэн аудитын үр дүнд дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

1. Тухайн аж ахуйн эзэмшил газрынхаа өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу байгалийн ургамал, мод үржүүлгийн талбай, мод бүхий зурвас байгуулах ажлыг жил бүрийн төлөвлөгөөгөөр нэмэгдүүлж Монгол улсын газрын тухай хуулийн 56.6-д заасны дагуу эзэмшилд авсан газрын 10%-аас доошгүй талбайг ногоон байгууламжтай болгох шаардлагатай.

### Аудитын дүгнэлт:

Хөрсөн орчны менежментийн аудитын үр дүнгээс үзвэл үйлчлүүлэгч байгууллага хөрсөн орчны хувьд дараах нийцлүүд байна. Үүнд:

1. Мэргэжлийн байгууллагаар 2021 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хийлгүүлж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд үүнд ургамлан нөмрөг, нөхөн сэргээлт, ногоон байгууламж, мод бүхий зурвас байгуулах асуудлыг бүрэн тусгасан.
2. Байгалийн ургамал үржүүлгийн газрыг 2 га талбайд байгуулан 6 хүлэмж барьж, ургамал шилжүүлэн тарих, бойжуулалтын 9 талбайг бэлтгэсэн ба 20 тн багтаамжтай 2 контайнер, оффисын зорилгоор 1 гэр, ажилчдын амрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2 сүүдрэвч хийсэн ба 5 тн багтаамжтай нөөцийн сав 5 ш байршуулах ажлыг хийсэн.
3. Газар шорооны ажил эхлэхийн талбайд ховор болон нэн ургамал илэрсэн тохиолдолд шилжүүлэн суулгах зорилгоор үзлэг хийн ургамлыг бүртгэдэг.
4. Нөлөөлөлд өртөх шилжүүлэн тарих шаардлагатай ургамжлын жагсаалтыг гаргаж, байгалийн ургамал үржүүлгийн газарт ургамал шилжүүлэн тарих ажлыг зохион байгуулдаг.
5. Төслийн талбайд шинээр ирж ажиллах тухай бүрд "Ерөнхий зааварчилгаа"-г өгч, шалгалт авдаг бөгөөд ерөнхий зааварчилгаа, байгаль хамгаалах арга хэмжээ, биологийн төрөл зүйл сургалтын хүрээнд ургамлыг тасдахгүй байхыг хориглосон мэдээллийг тогтмол өгч ажилладаг байна.
6. Намрын тариалалтаар тариалсан суулгацыг арчилж ургуулах, хайлаасыг үрээр, нэг наст цэцэг тарих ажлыг зохион байгуулдаг.

### 3.2.5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТ

#### Баталгаажсан нотолгоо:

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгон аудитын явцад цуглуулсан болно. Үүнд:

#### 1. Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл:

- ✓ Хүн амын суурьшил; тээврийн хэрэгслийн дуу чимээ, гэрэл зэргээс амьтад байршиж буй газар нутгаасаа үргэж дайжихаас гадна, тээврийн хэрэгсэлд дайруулж болзошгүй.
- ✓ Байгаль орчны мэдлэг дутуугаас амьтныг үргээж, элдэж, алж болзошгүй.
- ✓ Хүн амын суурьшил нэмэгдсэнээр хууль бус ан хийгдэж болзошгүй.
- ✓ Шувууд эрсдэж болзошгүй.
- ✓ Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар Говийн их ДЦГ-ын А хэсгийн орчны бүс, Их Боглын БЦГ-т тархан амьдрах амьтад үргэж дайжих, хууль бус ан хийх.

#### 2. Биологийн олон янз байдлын менежментийн гүйцэтгэлийн үр дүн: Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбай дотор болон ойр орчимд, худгуудын усны түвшний хэмжилт хийх замд амьтан харагдах бүрд бүртгэдэг, 2023 онд мөлхөгч 2 зүйл, шувуу 23 зүйл, хөхтөн 6 зүйл амьтан 187 удаа ажиглагдсан байна.


№	Огноо	Цэг минут	Латин нэр	Харсан амьтан	Хамгаалалтын статус	Тоо- тоолой	Байршил (UTM)	Харсан газар	Цэг амаар	Томъёо	Бүртгэсэн хүний нэр	Компани
<b>2023</b>												
1	2/25/2023	16:26	Gazella subgutturosa	Харсуулт		5		Сүрьеэ хуудайн хайрцаг	Дундговь		Я.Хурцбилатар	ESD
2	2/25/2023	16:30	Gazella subgutturosa	Харсуулт		3		Кейптийн цохио	Дундговь		Я.Хурцбилатар	ESD
3	4/3/2023	10:36	Vulpes vulpes	Шар үхэй		1		Өргөн хуудайн хайрцаг	Дундговь		Я.Хурцбилатар	ESD
4	4/3/2023	12:16	Gazella subgutturosa	Аар суулт		7		Төвөн хуудай	Дундговь		Я.Хурцбилатар	ESD
5	6/12/2023	10:05	Ovis montanus	Бүдүүлч чочлого		1		Кейптийн цохио дотор гэрүүдийн хажууд	Сэлэнгэ		Э.Хурцбилатар	ESD
6	5/12/2023	17:00	Capra capra	Мяа хээтэй		2		Кейп	Сэлэнгэ	Насны өнгөрсөн	Э.Хурцбилатар	ESD
7	5/2/2023	14:16	Vulpes vulpes	Шар үхэй		1		Өргөн хуудайн үлд	Сэлэнгэ	Гүйж өссөн	Э.Хурцбилатар	ESD
8	5/2/2023	17:26	Phocaena physalis	Цэцэгтэй галуулт		1		БУУГ	Сэлэнгэ	Сүүл байсан	Э.Хурцбилатар	ESD
9	5/2/2023	16:36	Capra capra	Мяа хээтэй		2		БУУГ-ий ноён талбай дээр сууж байсан	Сэлэнгэ	Сүүл байсан	Э.Хурцбилатар	ESD
10	5/2/2023	22:05	Neotoma montana	Дэгдэн явсаа		1		Кейптийн цохио дотор өвсний газар	Сэлэнгэ		Э.Нягарава	ESD
11	5/3/2023	9:00	Prasopis montana	Узрын бор цувруу		2		Кейптийн 01 урд талын эзэн дээр	Бага зэрэг сэлэнгэ	Мод	Э.Хурцбилатар	ESD
12	5/3/2023	10:15	Moschus moschiferus	Мяа цугтай		1		Кейптийн цохио дотор	Сэлэнгэ	Гэрүүдийн принод	Э.Хурцбилатар	ESD
13	5/3/2023	10:00	Lepus timidus	Нүүрэн ханцартай байх мэгддэг		1	Канон	Кейптийн газар 00 орчим	Сэлэнгэ	00 ашааны хажууд байсан	Э.Хурцбилатар	ESD
14	5/3/2023	10:00	Ovis montanus	Цагайн чочлого		1		Кейптийн газар 00 орчим	Сэлэнгэ	1 Ханцарын хажууд байсан	Э.Хурцбилатар	ESD
15	5/3/2023	10:20	Ovis montanus	Адууч чочлого		1		Кейптийн цохио дотор өвсний хажууд	Сэлэнгэ		Э.Хурцбилатар	ESD
16	5/4/2023	13:05	Ovis montanus	Цагайн чочлого		1		Ургамал ургуулганы талбай	Дундговь	Мөргөө	Э.Хурцбилатар	ESD
17	5/4/2023	14:05	Ovis montanus	Адууч чочлого		1		Кейптийн цохио дотор	Дундговь	Мөргөө	Э.Хурцбилатар	ESD
18	5/4/2023	14:05	Moschus moschiferus	Мяа цугтай		1		Кейптийн цохио дотор	Дундговь	Мөргөө	Э.Хурцбилатар	ESD
19	5/4/2023	15:00	Moschus moschiferus	Уулын цугтай		1		Кейптийн цохио дотор	Дундговь	Мөргөө	Э.Хурцбилатар	ESD
20	5/5/2023		Gazella subgutturosa	Харсуулт эхэр		?		Эүү мод явсаг зам, Өргөн хуудайн ноён Б- Бам-1			Амгааж-Бам рөндгөний туслах	ESD
21		14:56	Prasopis montana	Мяа бор цувруу		1		Кейптийн цохио дотор			Э.Хурцбилатар	ESD
22	5/5/2023	15:04	Moschus moschiferus	Уулын цугтай		1		Кейптийн цохио дотор			Э.Хурцбилатар	ESD
23	5/5/2023	15:03	Streblopera desocato	Хурцгоо Бурхан байх мэгддэг		1		Кейптийн цохио дотор			Э.Хурцбилатар	ESD
24	5/6/2023	10:16	Ovis montanus	Цагайн чочлого		1		Кейптийн цохио дотор			Э.Хурцбилатар	ESD
25	5/6/2023	10:56	Moschus moschiferus	Мяа цугтай		1		Кейптийн цохио дотор			Э.Хурцбилатар	ESD
26	5/6/2023	10:16	Capra capra	Мяа хээтэй		1		Кейптийн цохио дотор			Э.Хурцбилатар	ESD
27	5/6/2023		Gazella subgutturosa	Харсуулт эхэр		5		Эүү мод явсаг зам, Өргөн хуудайн ноён Б- Бам-1			Амгааж-Бам рөндгөний туслах	ESD
28	6/6/2023	8:40	Lepus timidus	Мяа цугтай		1		Кейптийн цохио дотор өвсний хажууд	Говьсүмбэр		Бичигчин	ESD

Зураг 23. Амьтны бүртгэл

Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд батлагдсан маршрутын дагуу зорчихыг, зэрлэг амьтныг үргээх, элдэж хөөхийг хориглодог. Төслийн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм”-д заагдсаны дагуу хэрийн анги, ажлын талбарын орчимд хурдны дээд хязгаар 20 км/цаг, төслийн талбайд 40 км/цаг байхыг шаарддаг ба замын хөдөлгөөнд оролцогч бүр жолоочийн хурдад хяналт тавьдаг.

Говийн их дархан цаазат газрын “А” хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах санамж бичгийг 2021 онд байгуулсан байна. Санамж бичигт тусгагдсаны дагуу биологийн олон янз байдлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд мэргэшсэн судлаач нартай хамтран биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын тандан судалгааг хийж амьдрах орчныг сайжруулах, үст цэг байгуулах боломжит газруудыг тогтоох судалгааны ажил үргэлжлэн явагдаж байна. Мөн SMART программыг нэвтрүүлэхээр санал солилцож, 11 дүгээр сард программын сургалтыг авахаар төлөвлөсөн байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, зэрлэг амьтны амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд мэргэшсэн судлаач нартай хамтран биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, амьдрах орчныг сайжруулах зорилгоор үст цэг байгуулах боломжит газруудыг тодорхойлох судалгааны ажлыг 2022 онд эхлүүлэн үргэлжлэн явагдаж байна.



Зураг 32. Биологийн олон янз байдлын суурь судалгаа

Хууль бусаар амьтан агнах, айлгаж үргээхийг хориглосон ба санамжуудыг хээрийн анги, харуул хамгаалалтын хэсэг зэрэг шаардлагатай газруудад байршуулсан байна.



Зураг 33. Хулгайн ан хийхгүй байх санамж

### Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан

Төслийн талбай нь бүхэлдээ Говийн Их ДЦГазрын "А" хэсгийн орчны бүсэд хамаарагддаг.

Говийн их ДЦГ-ын "А" хэсгийн хамгаалалтын захиргаатай байгуулсан санамж бичгийн хүрээнд жил бүр хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэн ажилладаг байна. Энэ онд уст цэгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг худаг, хөв цөөрөм байгуулах үнийн судалгаа хийх, 2024 онд хөв байгуулах худгийг сонгох, SMART программыг нэвтрүүлэх, мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хамтран гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Төлөвлөгөөний дагуу хамгаалалтын захиргааны даргатай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хөв байгуулах боломжтой гэж үзсэн Нарийн хөхийн хоолой дахь цооног, Ламын тооройн худгуудыг газар дээр нь очиж үзсэн байна. Газар дээр нь үзэж ярилцан Ламын тооройн худгийг түшиглэн 2024 онд сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг хөв байгуулахаар сонгосон ба Шар хулстайд 2 ш стандартын шаардлага хангасан 00 барих, БОАЖЯамтай хамтран тусгай хамгаалалттай газрын ажилтныг Канад улсад сургалтад хамруулах зэрэг ажлуудыг хийсэн байна. SMART программыг нэвтрүүлэх, мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлэх туршлага солилцох уулзалтыг 11 дүгээр сард гүйцэтгэхээр төлөвлөжээ.



Зураг 34. ГИДЦГ-ын "А" хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтран ажиллаж байгаа байдал

### **3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

#### **Биологийн болон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зорилт:**

- ✓ Байгалийн амьдрах орчныг нөхөн сэргээх
- ✓ Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

#### **Биологийн болон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ:**

- ✓ Тарьц, суулгац бэлдэх
- ✓ Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газар нутгийг сонгоход холбогдох төрийн захиргааны байгууллагуудаас санал авах
- ✓ Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах
- ✓ Дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэх газар нутгийн биологийн төрөл зүйлийн судалгааг үе шаттайгаар хийх

#### **Хэрэгжүүлсэн арга хэмжээ**

- ✓ Байгалийн ургамал үржүүлгийн газар нутгийн ургамлын үрээр хайлаас 23352, заг 20649, хотир 2669, сухай 1569, агч 1957, жигд 2703, шар хуайс 910, бүйлс 3095, лидэр 230 тоорой 5118 ш үрсэлгээг ургуулсан.
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр санал болгсон газруудад судлаач Н.Батсайхан, түүний багтай хамтран биологийн олон янз байдлын тандан судалгааг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Судлаачдын баг 2023 оны 06 болон 09 дүгээр саруудад талбай дээр ажиллан биологийн төрөл зүйлийн суурь судалгааг хийсэн.
- ✓ "Эрдэнэ Монгол" ХХК-ийн зүгээс Шинэжинст сумын иргэдтэй хамтран мод тарих боломжтой газрын судалгааг хийж 4 байршилд мод тарих боломжтой гэж үзсэн. Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангасан байхаар төлөвлөж судалгааны ажлуудын хүрээнд дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэх талаар санал авахаар Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2023.10.13-ны 250/23, Шинэжинст сумын Засаг даргад 2023.10.13-ны 249/23 албан бичгийг хүргүүлж, хариу хүлээж байна.
- ✓ Монгол Улсын Их Сургуулийн мэргэшсэн судлаачидтай хамтран биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх газар нутгийг сонгох, хамгааллын аргуудыг сонгох тандан судалгааны ажлын гэрээг 2022 оны 09 дүгээр сард байгуулж, хээрийн судалгааны ажлыг 2022 оны 10 дугаар сар, 2023 оны 06 болон 09 дүгээр саруудад талбай дээр ажиллан биологийн төрөл зүйлийн суурь судалгааг хийсэн байна. Биологийн төрөл зүйлийн жагсаалтыг гаргаж дууссан ба хамгааллын арга хэмжээг боловсруулахаар төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлэх хариуг хүлээж байна.
- ✓ Судлаачдын баг 2022 оны 10 дугаар сар, 2023 оны 06 болон 09 дүгээр саруудад талбай дээр ажиллан биологийн төрөл зүйлийн суурь судалгааг хийсэн байна.
- ✓ "Эрдэнэ Монгол" ХХК-ийн зүгээс Шинэжинст сумын иргэдтэй хамтран мод тарих боломжтой газрын судалгааг хийж 4 байршилд мод тарих боломжтой

гэж үзсэн.

- ✓ Геоэкологийн хүрээлэнтэй хамтран “Хөндий дүүргийн загийн тархалтын судалгаа”-г хийсэн байна.
- ✓ Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл ТББ-тай “Тэрбум мод хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ТЭЗҮ боловсруулах “Ажил гүйцэтгэх гэрээ”-г 10 дугаар сарын 17-нд байгуулж, хээрийн ажил эхэлсэн байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг дэмжин 2030 он гэхэд 1 сая мод тарих ажлыг төлөвлөсөн байна. Байгалийн ургамал үржүүлгийн газарт үрээр заг, хайлаас, тоорой, хотир, лидэр, хармаг, агч, жигд, бүйлс, шар хуайс мөчрөөр сухай хүлэмжид тарьсан үрслэгээний амьдралтын хувь 95% байна.



Зураг 35. Тэрбум мод хөтөлбөрийн хэрэгжилт

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр санал болгосон газруудад судлаач Н.Батсайхан, түүний багтай хамтран биологийн олон янз байдлын тандан судалгааг 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Судлаачдын баг 2022 оны 10 дугаар сар, 2023 оны 06 болон 09 дүгээр саруудад талбай дээр ажиллан биологийн төрөл зүйлийн суурь судалгааг хийсэн байна.

Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэхэд талуудын оролцоог хангасан байхаар төлөвлөж судалгааны ажлуудын хүрээнд дүйцүүлэн хамгаалал хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэх талаар санал авахаар Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2023.10.13-ны 250/23, Шинэжинст сумын Засаг даргад 2023.10.13-ны 249/23 албан бичгийг хүргүүлж, хариу хүлээж байна.



Зураг 36. Хийгдэж байгаа судалгааны ажлууд

### **Нөлөөлөлд өртөх болон дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ**

Баянхөндий төслийн ил уурхайн олборлолт, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн бүтцийн байгууламжууд нь талбай болон зурвас хэлбэрийн нөлөөлөл үзүүлэх ба нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ “Нөлөөлөл бууруулах программ” (Mongolian Mitigation Design Tool)-д тооцсоноор 1,041 га (337.5 га их, 107.5 га дунд, 595.9 га бага эрчимтэй), дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайн хэмжээг мөн “Нөлөөлөл буурах программ”-д тооцсон ба 5721 га буюу нөлөөлөлд өртөх талбайгаас 5 дахин их байна.” гэж БОННУ-д тусгагдсан байна.

### **Дүйцүүлэн хамгаалах газрын санал болгож буй байршлууд:**

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжит газрын байршлаар ГИДЦГ-ын А хэсгийн орчны бүсэд орших Эдрэнгийн нуруу, Номингийн говь болон Баянбулагийн тал гэсэн 3 байршил сонгогдсон байна. Өмнийн говийн Экологийн бүс нутгийн үнэлгээгээр Эдрэнгийн нуруу, Номингийн говь, хамгаалах шаардлагатай газруудад Баянбулагийн тал Шинээр хамгаалах шаардлагатай газрын ангилалд хамаарагдана. 2022 онд төслийн талбай болон дээрх БОННУ-ний тайланд санал болгосон байршлуудад Монгол Улсын Их Сургуулийн мэргэшсэн судлаачидтай хамтран биологийн төрөл зүйлийн дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх байршил, амьдрах орчныг тэтгэх чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлуудыг тодорхойлох зорилгоор тандан судалгааг 2022 оны 09 дүгээр сард зохион байгуулсан байна.

Судалгааны үр дүнд төслийн үйл ажиллагаанд хамаарах газар нутгийн цар хүрээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах зорилгод нийцэх амьдрах орчин буюу экосистемийн хэв шинж нь өвөрмөц экосистем болох гүний уснаас хамааралтай сайр, садарга, хотгор газар илэрч байгаа тул энэ дурдсан орон зайд сонголт хийх шаардлагатай гэж үзжээ. Тухайлбал, олон улсын болон бүс нутгийн түвшинд ховордлын зэрэг өндөртэй зарим зүйл хөхтөн амьтан, шувуу (хар сүүлт зээр хулан жороо), түүнчлэн монгол буйлс, алтан харгана, Төв Азийн лавай, Монгол азар

зэрэг олон эндемик зүйл сөөг өвөрмөц экосистемд тохиолдож буй нь энэ экосистемийн ач холбогдлыг илэрхийлж байна.

ОУСК-ын боловсруулсан гүйцэтгэлийн стандарт 6-д, ОУБХХ-ны боловсруулсан Улаан дансны шалгуураар бүс нутгийн болон олон улсын түвшинд ховордлын зэрэг өндөртэй амьтан, ургамлын зүйлийг нэн тэргүүнд санал болгосон байдаг байна. Тиймээс Жинст уулын бэлд орших Баянбулгийн тал, Идрэнгийн нурууны дорнод хаяа уулсын бэлд орших загт бүлгэмдэлтэй талархаг газар, Долооны хоолой нь биологийн олон янз байдлын хувь ядмаг түгээмэл экосистем болох хээржүү цөл, жинхэнэ цөл, алаг цоог цөлжүү хээр илэрч байгааг тодорхойлсон. байна Дүйцүүлэн хамгааллын байршлыг шинжлэх ухааны судалгаан дээр үндэслэн, талуудын оролцоог ханган сонгож, хамгааллын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### Аудитын шалгуур:

Хууль тогтоомжийн хүрээнд 30 шалгуур үзүүлэлтээр биологийн олон янз байдлын менежментийн чиглэлд аудитыг гүйцэтгэв. Нийт 30 шалгуурын 1 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөрт, 8 нь үндэсний хууль тогтоомж, 6 холбогдох дүрэм журам, аргачлалд, 8 нь стандарт, 7 нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөөнд тусгалаа олсон байна.

Аудитын шалгуураар тодорхойгүй болон хамааралгүй гэж үнэлэгдсэн үзүүлэлтийг хасаж, аудитын нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 12. Биологийн олон янз байдлын нийцэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэгтгэл

№	Хуулийн заалт	Хамрах хүрээ	Шалгуур үзүүлэлт	Үнэлэмж				
				Нийцэл	Сайжруулах шаардлагатай	Үл нийцэл	Тодорхойгүй	Хамааралгүй
<b>1. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ</b>								
<b>1.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай /шинэчилсэн найруулга/</b>								
1.	8.4.6.	8 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	Газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, нөхөн сэргээлтийн зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ;	√	-	-	-	-
2.	9.6.	9 дүгээр зүйл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.	√	-	-	-	-
<b>2. ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ</b>								
<b>2.1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам батлах тухай Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоол</b>								
3.	5.2.1.	5.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх газар нь тухайн нөлөөлөлд өртсөн газартай адил байгаль экологийн нөхцөлтэй байх;	√	-	-	-	-
4.	5.2.2.	дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгах ба	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлын тооцоо нь үнэн бодит судалгаа, мэдээлэлд үндэслэсэн байх;	√	-	-	-	-
5.	5.2.3.	дүйцүүлэн хамгаалах	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь төсөл	√	-	-	-	-

		арга хэмжээ нь дараах зарчмыг хангасан байна:	хэрэгжүүлэгчийн зүгээс хуулиар хүлээсэн нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх үүргээс зайлсхийх нөхцөл болохгүй байх;					
6.	5.2.4.		Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үр дүнг тайлагнах хэлбэр, хяналт тавих механизм зэргийг тодорхой тусгасан байх;	√	-	-	-	-
<b>2.2. “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” батлах тухай БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаал</b>								
7.	1.5.	Нэг. Ерөнхий зүйл	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын ба газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.	√	-	-	-	-
8.	-	БОАЖС-ын 2019 оны А/619 тоот тушаалын 3-р хавсралтын А хэсэг	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг тусгах	√	-	-	-	-
9.		БОАЖС-ын 2019 оны А/619 тоот тушаалын 3-р хавсралтын Б хэсэг	Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг тусгах	√	-	-	-	-
10.	-		Зөвхөн батлагдсан замын сүлжээг ашиглах ба тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоож, мөрдүүлэх	√	-	-	-	-
11.			ОХШХ-ийн дагуу амьтны хяналт мониторингийг хэрэгжүүлж, бүртгэл хөтлөх	√	-	-	-	-
12.			Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Биологийн олон янз байдлын мэдлэг олгох” сургалтад хамруулах	√	-	-	-	-
13.		Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Хууль бусаар амьтан агнах, тэдгээрийн гаралтай түүхий эдийг тээвэрлэх, ашиглахыг хориглох, уурхайн шалган нэвтрүүлэх хэсэг, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийх	√	-	-	-	-
14.			Шувууд (элдэв идэшт) цуглах таатай орчин бүрдүүлэхээс зайлсхийж хоол хүнсний үлдэгдлийг ил задгай хаяхгүй бай, холбогдох хяналт тавих	√	-	-	-	-
15.			Элдэв идэшт шувуудын ажиглалтын бүртгэл хөтлөх	√	-	-	-	-
16.	-		Их Богдын БЦГ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулах	√	-	-	-	-
<b>Нийт дүн</b>				<b>16</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Аудитын үнэлэмж:**

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан бөгөөд дараах дөрвөн хэлбэрээр илэрхийлэв.

- ❖ **Нийцэл.** Аудитын шалгуурыг хангасан. Шаардлагатай тохиолдолд сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Сайжруулах шаардлагатай.** Аливаа мэдээлэл дутуугаас тухайн шалгуурыг үнэлэх боломжгүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.

- ❖ **Хугацаа болоогүй.** Шалгуурыг гүйцэтгэх хугацаа болоогүй. Ирээдүйд хийгдэх ажлууд тул зөвхөн тайлбар бичсэн.
- ❖ **Үл нийцэл.** Аудитын шалгуурыг хангаагүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.

Нийт 30 шалгуурыг 16 нотолгоо дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

✓ Нийцэл	16
✓ Сайжруулах шаардлагатай	0
✓ Хугацаа болоогүй	0
✓ Үл нийцэл	0
✓ Хамааралгүй	14

Үнэлэмжийн бүтцийг графикт үзүүлбэл:




График 7. Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ

### Үл нийцлийн эрсдэл:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, хүрээлэн буй орчны байгалийн бүрдэл хэсгүүд, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ буюу шаардлагуудыг тухайн төсөл хэрэгжүүлэгч биелүүлээгүйгээс аливаа эрсдэл үүсэх бөгөөд үүнээс улбаалан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, байгаль орчин бохирдож, доройтох ба хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Эрсдэлийг үнэлэхдээ дараа хэлбэрүүдийг ашиглав.

- ❖ **Их.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл өндөр. Аудитын багийн ахлагчид даруй мэдэгдэнэ.
- ❖ **Дунд.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл дунд зэрэг.
- ❖ **Бага.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл бага.

Нийт 16 шалгуурын эрсдэлийг тогтооход дараах байдалтай үнэлэгдэв. Эрсдэлийн бүртгэл:

✓ Их	0
✓ Дунд	0
✓ Бага	0
✓ Үгүй	16

### 3.2.6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

#### 3.2.6.1. АХУЙН ХОГ ХАЯГДАЛ

##### Баталгаажсан нотолгоо:

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгон аудитын явцад цуглуулсан болно. Үүнд:

##### 1. Ахуйн хог хаягдлын менежментийн гүйцэтгэлийн үр дүн:

“Эрдэнэ Монгол” ХХК нь “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулж, үлдсэн хог хаягдлыг шинээр байгуулсан хог хаягдлын цэгт хадгалж байгаагийн зэрэгцээ сумын төвийн нэгдсэн хогийн цэгт гэрээт иргэнээр тээвэрлүүлэн нийлүүлдэг байна.

“Шинэжинст сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй байгуулах хог хаягдлын гэрээ”-г 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр сумын ЗДТГазрын даргатай байгуулсан байна [33, 34].

Шинэжинст сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч бүрэн эрхийн хүрээнд, компанийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд хог хаягдлын бүртгэл, цуглуулалт, хадгалалтын байдалд хяналт тавьж ажилласан байна.

Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад 55.6 сая төгрөг зарцуулсан ба дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны “Тавигдах шаардлага батлах тухай” А/443, “Аргачилсан заавар батлах тухай” А/445 тушаалуудын дагуу 125 м х 10м хэмжээтэй аюултай болон энгийн хог хаягдал хадгалах цэгийг шинээр байгуулсан байна.

Тосоор бохирдсон хөрс хадгалах саармагжуулалтын хэсгийг хөрснөөс тусгаарлаж плёнк дэвссэн ба аюултай хог хаягдал хадгалах хэсгийг бетондсон байна. Хуванцар, цаас хадгалах хэсгүүдийг салхинд хийсэхээс сэргийлэх зорилгоор дээврийн хэсгийг битүү торлосон байна. Хогийн цэг нь гадуураа хашаатай ба хаягжуулсан, үерийн хамгаалалтын далантай. Шинээр байгуулсан хогийн цэгт төслийн барилгын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хуримтлуулж байна. Баянхөндий хээрийн ангийн хог хаягдлыг гэрээний дагуу Шинэжинст сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлдэг байна.



Зураг 37. Хог хаягдлын цэг



Зураг 38. Ахуйн хог хаягдлын цэгийн харагдах байдал

Оффис, гэр, контейнер сууцуудад, гадна талбайн шаардлагатай байршлуудад хог ангилан хаях зориулалттай ногоон болон хар өнгийн хогийн савнууд, гал тогоонд хоолны үлдэгдэл, өндөгний хальс, хуванцар хаягдал хаях савнуудыг байрлуулсан.



Зураг 39. Кэмп доторх хогийн сав

Хог хаягдлыг зохистойгоор хаяж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажлын байрны шалгалт тогтмол явуулж, ажилчдад заавар зөвлөмжийг тогтмол өгдөг байна. Мөн ажлын талбай бүр, хээрийн ангийн ойр орчмын хог хаягдлыг Ням гараг бүрд тогтмол цэвэрлэдэг ба тээврийн зам дагуух хог хаягдлыг үүссэн тухай бүрд цэвэрлэдэг байна.



Зураг 40. Бүх нийтийн цэвэрлэгээ

### **Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт:**

#### **Хаягдлын эх үүсвэр**

- ✓ Уурхайн тосгон, оффис, аж ахуйн барилга
- ✓ Эмнэлэг
- ✓ Машин механизмын засварын цэг барьж, ашиглалтад орсон тохиолдолд

#### **Хэрэгжүүлсэн арга хэмжээ**

- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 01 сарын 30-аас 02 сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан "Хариуцлагатай уул уурхай, нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээ" сургалтад байгаль орчны 3 мэргэжилтэн хамрагдсан байна.
- ✓ Мөн "Чанарын удирдлагын нэгдсэн менежментийн тогтолцоо" сургалтыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болох Ошми консалтинг ХХК-аас 05 сарын 04- 05-ны өдрүүдэд зохион байгуулж компанийн бүх ажилтан хамрагдсан байна.

- ✓ Сургалтын материалыг бэлтгэж, төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулсан. Хээрийн ангийн үйл ажиллагаа 05 сард эхэлсэнтэй холбоотойгоор 05, 07, 08 дугаар саруудад сургалтыг зохион байгуулж хоол үйлдвэрлэл, барилга угсралтын багаас бусад хэсэг нэгжийн ажилтнууд хамрагдсан. Хоол үйлдвэрлэл, барилга угсралтын багт хог хаягдлын менежментийн сургалтыг ерөнхий зааварчилгаагаар дамжуулан олгодог байна.
- ✓ Шинэжинст сумын Тохижилт үйлчилгээний албатай "Хог хаягдлын талаар хамтран ажиллах гэрээ"-г 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан. Баянхөндий хээрийн ангийн хог хаягдлыг 10-14 хоногт 1 удаа сумын төвийн нэгдсэн хогийн цэгт нийлүүлэхээр тээвэрлүүлдэг байна.
- ✓ Хог хаягдлыг энгийн, хуванцар, аюултай хог хаягдал гэж ангилан хог хаягдлын цэгт хадгалж байна.
- ✓ Хог хаягдлыг булшлах устгах хүсэлтийг Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу Баянхонгор аймгийн Засаг даргад 08 сарын 13-ны өдөр хүргүүлсэн ба одоогийн байдлаар хариу ирээгүй байна.
- ✓ Барилга угсралтын хүрээнд 30 тонн-н шүүлтүүр тасалгаатай 2 танк, 300м.кв талбайд 150мм хоолой ашиглан шүүрүүлэх системийг хийж гүйцэтгэсэн байна.
- ✓ Тус ажлын гүйцэтгэх ажлыг гэрээний дагуу барилгын ерөнхий гүйцэтгэгч хариуцаж байгаа. Цэвэршүүлэх байгууламж барих аж ахуйн нэгжийг шалгаруулах тендер зарлахад 4 компанийн мэдээлэл ирж "Доктор эко" ХХК сонгогдсон байна. Ус цэвэршүүлэгч байгууламж нь усыг 98 хувь цэвэрлэх бөгөөд MNS 4943:2015 стандартыг хангасан байна.
- ✓ Усны нөөцийг хэмнэлттэй ашиглах талаар хээрийн ангийн ерөнхий зааварчилгаанд тусгасан ба "Ус хэмнэх" сургалтын материалыг боловсруулан 05 сарын 04-нд танилцуулсан. "Ус хэмнэх аян"-г 10 сарын 11-18-ны өдрүүдэд зохион байгуулсан байна.
- ✓ Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журмыг гүйцэтгэх захирлын 06 дугаар сарын 05-ны өдрийн ЕМ 2023/0002.01 тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан байна.

### **Аудитын шалгуур:**

Хууль тогтоомжийн хүрээнд 92 шалгуур үзүүлэлтээр хог хаягдлын аудитыг гүйцэтгэв. Нийт 92 шалгуурын 4 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөрт, 40 нь үндэсний хууль тогтоомж, 32 нь холбогдох дүрэм журам, аргачлалд, 7 нь стандартад, 9 нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгалаа олсон байна.

Аудитын шалгуураар тодорхойгүй болон хамааралгүй гэж үнэлэгдсэн үзүүлэлтийг хасаж, аудитын нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн нийцэл,  
гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэгтгэл

№	Хуулийн заалт	Хамрах хүрээ	Шалгуур үзүүлэлт	Үнэлэмж				
				Нийцэл	Сайжруулах шаардлагатай	Үл нийцэл	Тодорхойгүй	Хамааралгүй
<b>1. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ</b>								
<b>1.1. Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/</b>								
1.	10.2.1.	10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг 10.2.Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараах үүрэг хүлээнэ:	Энэ хуулийн 9.1.3-т <sup>52</sup> заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;	√	-	-	-	-
2.	10.2.2.		Энэ хуулийн 15 дугаар зүйлд <sup>53</sup> заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх;	√	-	-	-	-
3.	10.2.3.		Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах;	√	-	-	-	-
4.	10.2.4.		Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;	√	-	-	-	-
5.	10.2.5.		Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;	√	-	-	-	-
6.	10.2.6.		Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох;	√	-	-	-	-
7.	10.2.7.		Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;	√	-	-	-	-
8.	10.2.8.		Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;	√	-	-	-	-
9.	10.2.9.		Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;	√	-	-	-	-
10.	10.2.10.		Энэ хуулийн 9.4.12-т <sup>54</sup> заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;	√	-	-	-	-
11.	10.2.11.		Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;	√	-	-	-	-
12.	10.2.12.		Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;	√	-	-	-	-
13.	10.2.13.		Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;	√	-	-	-	-
14.	10.2.14.		Хог хаягдлын талаарх хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;	√	-	-	-	-
15.	10.2.16.		Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;	-	√	-	-	-
16.	10.2.17.		Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод	√	-	-	-	-

<sup>52</sup> 9.1.Хог хаягдлын талаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.1.3.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх;

<sup>53</sup> 15.1.Нийтийн эдэлбэр газар байршуулах хогийн сав дараах шаардлагыг хангасан байна:

15.1.1.хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

15.1.2.галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

15.1.3.хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

<sup>54</sup> 9.4.12.нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох;

			болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;					
17.	10.2.18.		Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.	√	-	-	-	-
18.	10.3.1.	10.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно:	Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;	√	-	-	-	-
19.	10.3.2.		Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;	√	-	-	-	-
20.	10.3.3.		Хог хаягдлыг ил задгай шатаах;	√	-	-	-	-
21.	10.3.4.		Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;	√	-	-	-	-
22.	10.3.5.		Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;	√	-	-	-	-
23.	10.3.6.		Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;	√	-	-	-	-
24.	10.3.7.		Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.	√	-	-	-	-
25.	14.2.	14 дүгээр зүйл. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.	√	-	-	-	-
26.	14.3.		Энэ хуулийн 14.2-т <sup>55</sup> заасан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.	√	-	-	-	-
27.	14.4.		Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө.	√	-	-	-	-
28.	14.5.		Энэ хуулийн 14.4-т заасан хуваарийн дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгнө.	√	-	-	-	-
29.	15.1.1.	15 дугаар зүйл. Хогийн саванд тавигдах шаардлага	Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;				-	-
30.	15.1.2.		Галд тэсвэртэй материалаар хийгдсэн;	-	√		-	-
31.	15.1.3.		Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.				-	-
<b>2. ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ</b>								
<b>2.1. "Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/428 тоот тушаал</b>								
32.	6.2.	Зургаа. Мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг	Хог хаягдлын тухай хуулийн 11.3-д <sup>56</sup> заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цахимаар болон цаасан хэлбэрээр энгийн хог хаягдлын мэдээ тайланг харьяалах сум дүүргийн Засаг дарга, аюултай хог хаягдлын мэдээ тайланг харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.	-	√	-	-	-
<b>2.2. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 тоот тушаал</b>								
33.	2.1.3.	Хоёр. Тавигдах ерөнхий шаардлага болон хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Энгийн хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий этгээд Хог хаягдлын тухай хуулийн 8.1.3-д <sup>57</sup> заасан журмын дагуу хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.	-	√*	-	-	-
34.	2.2.2.	2.2. Хог хаягдлыг ангилахад тавигдах	Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь үүсгэж буй энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр болон үйл	√	-	-	-	-

<sup>55</sup> 14.2.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

<sup>56</sup> 11.3. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлын мэдээг батлагдсан маягтын дагуу сум дүүрэгт, аюултай хог хаягдлын мэдээг аймаг, нийслэлд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

<sup>57</sup> 8.1.3. Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журмыг батлах;

		ерөнхий шаардлага	ажиллагааны явцад дахин ашиглах, хүнсний хаягдал, үнс болон бусад гэсэн төрлөөр заавал ангилна.						
35.	2.2.4.		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ангилсан хог хаягдлаа зориулалтын дагуу Эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх үүрэгтэй.	✓	-	-	-	-	
36.	2.2.7.а.		Ангилан ялгах хог хаягдлын төрлөөр хогийн савыг өнгөөр ялгасан, эсвэл ангилах ялгах зориулалтын тэмдэг, тэмдэглэгээ бүхий байж болно.	✓	-	-	-	-	
37.	2.2.7.в.	2.2.7. Хогийн савны хэмжээ, төрөл, хэлбэр, өнгийг орон нутгийн онцлогоос хамаарч тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоох ба дараах ерөнхий шаардлагыг мөрдөнө.	Цоорч гэмтээгүй, шингэн нэвчихгүй, угааж цэвэрлэхэд хялбар;	✓	-	-	-	-	
38.	2.2.7.г.		Тагтай, хуванцар, металл материалаар хийгдсэн;	✓	-	-	-	-	
39.	2.2.7.д.		Салхин доор, гэр байшин, хүнс боловсруулах, хадгалах газар, хүүхдийн тоглоомын талбайгаас 20-30 метрт байрлуулсан;	✓	-	-	-	-	
40.	2.2.7.е.		Хогийн сав байршуулах талбайн хөрсийг тэгшлэн, нягтаршуулсан, цементэлсэн, зориулалтын хавтан, дэвсгэр дэвссэн;	✓	-	-	-	-	
41.	2.2.7.ж.		Тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх зай талбайтай;	✓	-	-	-	-	
42.	2.2.8.		Иргэн, аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.	✓	-	-	-	-	
43.	2.3.2.	2.3. Хог хаягдлыг цуглуулахад тавигдах ерөнхий шаардлага	Хог хаягдлын тухай хуулийн 14.2-т <sup>58</sup> заасан гэрээнд хог хаягдал цуглуулах төрөл, хэлбэр, хогийн цэгийн байршил, ажиллах цагийн хуваарь, орчны тохижилт, ариун цэврийн шаардлагын талаар тодорхой тусгасан байна.	✓	-	-	-	-	
44.	2.3.3.а.		Хог хаягдал цуглуулах сав, төхөөрөмжийг сум, хорооны Засаг даргын зөвшөөрсөн хэлбэр, хэмжээ, зориулалт болон заасан газарт байгуулна.	✓	-	-	-	-	
45.	2.3.3.б.	2.3.3. Хог хаягдлыг цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмж гэж энгийн хог хаягдлыг тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах зорилгоор хог хаягдлыг цуглуулж байгаа хог хаягдал үүсгэгчийн ойролцоо байршуулсан савыг хэлэх ба дараах ерөнхий шаардлага хангасан байна.	Орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн талбай, явган хүн, авто машины хөдөлгөөнд саад учруулахааргүй газар байна.	✓	-	-	-	-	
46.	2.3.3.в.		Хог хаягдал хийсэх, агаар болон хөрсөнд тархах, шингэх, уусах, үнэр тархахгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.	✓	-	-	-	-	
47.	2.3.3.г.		Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.	✓	-	-	-	-	
48.	2.3.3.д.		Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцөлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.	✓	-	-	-	-	
49.	2.3.3.е.		Тээвэрлэх зориулалт бүхий уяа, дэгээтэй, хог хаягдал ачих тээврийн хэрэгсэлд зориулагдсан байна.	✓	-	-	-	-	
50.	2.3.3.ж.		Хог хаягдал цуглуулах зориулалт бүхий сав, төхөөрөмжийн хог хаягдал хадгалах, цуглуулах багтаамж 3 хоногоос ихгүй байна.	✓	-	-	-	-	
<b>3. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ БА БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>									
51.	-	Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээ	Ахуйн болон барилгын хаягдал түр хадгалах цэгийг бэлдэх	✓	-	-	-	-	
52.			Хог хаягдлын менежментийн чиглэлээр мэргэжлийн байгууллагаас сургалт авах	✓	-	-	-	-	
53.			Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах сургалтын материал бэлтгэж, сургалт зохион байгуулах	✓	-	-	-	-	
54.			Ялгаруулж буй хог хаягдлыг өдөр бүр ангилан бүртгэх, мэдээллийн санг хөтлөх	✓	-	-	-	-	
55.			Хог хаягдлыг ангилан зөвшөөрөгдсөн цэгт түр хадгалах	✓	-	-	-	-	
56.			Барилгын ажилтай холбогдуулан бохирын септик системийг өргөтгөх	✓	-	-	-	-	
57.			Төслийн бохир ус цэвэршүүлэх байгууламжийн зураг төслийг боловсруулах	✓	-	-	-	-	
58.	-			Ус ашиглалт, усыг зүй зохистой хэрэглэх талаар	✓	-	-	-	-

<sup>58</sup> 14.2.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

59.		сургалт зохион байгуулах						
		Хог хаягдлыг Бүртгэх	√	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>			<b>57</b>	<b>2</b>	-	-	-	-

Тайлбар: \* Давхардлыг тэмдэглэв.

### Аудитын үнэлэмж:

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан бөгөөд дараах дөрвөн хэлбэрээр илэрхийлэв.

- ❖ **Нийцэл.** Аудитын шалгуурыг хангасан. Шаардлагатай тохиолдолд сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Сайжруулах шаардлагатай.** Аливаа мэдээлэл дутуугаас тухайн шалгуурыг үнэлэх боломжгүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.
- ❖ **Хугацаа болоогүй.** Шалгуурыг гүйцэтгэх хугацаа болоогүй. Ирээдүйд хийгдэх ажлууд тул зөвхөн тайлбар бичсэн.
- ❖ **Үл нийцэл.** Аудитын шалгуурыг хангаагүй. Цаашид сайжруулах зөвлөмж бичигдсэн.

Нийт 92 шалгуурт тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Үнэлэмжийн бүртгэл:

✓ Нийцэл	57
✓ Сайжруулах шаардлагатай	1
✓ Хугацаа болоогүй	0
✓ Үл нийцэл	1
✓ Хамааралгүй	33

Үнэлэмжийн бүтцийг зургаар үзүүлбэл:



График 8. Аудитын үнэлэмжийн хувь хэмжээ

### Үл нийцлийн эрсдэл:

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, хүрээлэн буй орчны байгалийн бүрдэл хэсгүүд, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх ёстой арга хэмжээ буюу шаардлагуудыг тухайн төсөл хэрэгжүүлэгч биелүүлээгүйгээс аливаа эрсдэл үүсэх бөгөөд үүнээс улбаалан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуй, байгаль орчин бохирдож, доройтох ба хуулийн дагуу хариуцлага хүлээх болно. Эрсдэлийг үнэлэхдээ дараа хэлбэрүүдийг ашиглав.

- ❖ **Их.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл өндөр. Аудитын багийн ахлагчид даруй мэдэгдэнэ.
- ❖ **Дунд.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл дунд зэрэг.
- ❖ **Бага.** Тухайн шалгуурыг гүйцэтгээгүйгээс байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учирч болох эрсдэл бага.

Нийт 57 шалгуурын эрсдэлийг тогтооход дараах байдалтай үнэлэгдэв. Эрсдэлийн бүртгэл:

✓ Их	0
✓ Дунд	0
✓ Бага	2
✓ Үгүй	57

Аудит хийлгэгч байгууллага эрсдэлийг хооронд нь ялгалгүйгээр бүгдэд нь анхаарал хандуулан ажиллах шаардлагатай.

Байгаль орчны аудитын явцад дараах эрсдэлүүд ажиглагдлаа. Үүнд:

1. Энгийн хог хаягдлыг ангилан ялгаж байгаа боловч энгийн хог хаягдлыг хогийн цэгт хадгалахдаа стандарт шаардлагыг хангаагүй, хөрсөнд дээр шууд хадгалдаг.
2. Энгийн хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлдэггүй зэрэг болно.

#### **Зөвлөмж:**

Хог хаягдлын менежментийн чиглэлд хийсэн аудитын үр дүнд дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

1. Хогийн сав нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн, шаардлагыг хангасан хогийн савтай байх.
2. Энгийн хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий этгээд Хог хаягдлын тухай хуулийн 8.1.3-д заасан журмын дагуу хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг болно.

#### **Аудитын дүгнэлт:**

Хог хаягдлын менежментийн аудитын үр дүнгээс үзвэл үйлчлүүлэгч байгууллагад дараах нийцлүүд байна. Үүнд:

1. Мэргэжлийн байгууллагаар 2021 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хийлгүүлж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд үүнд хог хаягдлын менежментийн асуудлыг бүрэн тусгасан.

### 3.2.6.2. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

#### Баталгаажсан нотолгоо:

Аливаа аудитын үнэлэмжийг боловсруулахдаа баталгаажсан нотолгоог үндэслэл болгон аудитын явцад цуглуулсан болно. Үүнд:

#### 1. Аюултай хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны “Тавигдах шаардлага батлах тухай” А/443, “Аргачилсан заавар батлах тухай” А/445 тушаалуудын дагуу 125 м х 10м хэмжээтэй аюултай болон энгийн хог хаягдал хадгалах цэгийг шинээр байгуулсан байна.

Тосоор бохирдсон хөрс хадгалах саармагжуулалтын хэсгийг хөрснөөс тусгаарлаж плёнк дэвссэн ба аюултай хог хаягдал хадгалах хэсгийг бетондсон байна.



Зураг 41. Аюултай хог хаягдлын цэг байгуулсан байдал

#### 2. Химийн нэгдэл агуулсан аюултай хог хаягдлын зохицуулалт.

Техникийн засварын хэрэглээнд ашигласан шатах тослох материалын хаягдал, дизелийн масло болон бусад тос, тосолгоо материал, химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа, боодол нь аюултай хог хаягдал болон гарна. Үйл ажиллагааны үед үүсэх аюултай хог хаягдал нь бодисын сав, баглаа, боодол, батарей, аккумулятор, автомашины дугуй, тос масло зэрэг болно. Дээрх нэр төрлийн химийн нэгдэл агуулсан бүтээгдэхүүний хаягдал сав баглаа боодол нь “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” батлах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 тоот тушаалын дагуу аюултай хог хаягдлын зэрэглэлд хамаарна.

Уурхайд үүсэж буй аюултай хог хаягдлыг тусад нь цэг байгуулан хадгалж байгаа боловч (ашигласан химийн бодисын уут, сав шуудай, ажилласан тос тосолгооны материал болон техникийн шингэн, актлагдсан хаягдал техникийн эд ангиуд буюу шүүр, хаягдал дугуй гэх мэт) аюултай хог хаягдлын цэг нь хуулийн шаардлага хангаагүй байгаа нь “Хог хаягдлын тухай хуулийн” 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгална” гэсэн шаардлагыг ханган ажиллаж байна.



Зураг 42. Аюултай хог хаягдлын цэгийн харагдах байдал

### Хэрэгжүүлсэн арга хэмжээ

- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 01 сарын 30-аас 02 сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан “Хариуцлагатай уул уурхай, нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээ” сургалтад байгаль орчны 3 мэргэжилтэн хамрагдсан байна.
- ✓ Мөн “Чанарын удирдлагын нэгдсэн менежментийн тогтолцоо” сургалтыг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болох Ошми консалтинг ХХК-аас 05 сарын 04- 05-ны өдрүүдэд зохион байгуулж компанийн бүх ажилтан хамрагдсан байна.
- ✓ Сургалтын материалыг бэлтгэж, төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулсан. Хээрийн ангийн үйл ажиллагаа 05 сард эхэлсэнтэй холбоотойгоор 05, 07, 08 дугаар саруудад сургалтыг зохион байгуулж хоол үйлдвэрлэл, барилга угсралтын багаас бусад хэсэг нэгжийн ажилтнууд хамрагдсан. Хоол үйлдвэрлэл, барилга угсралтын багт хог хаягдлын менежментийн сургалтыг ерөнхий зааварчилгаагаар дамжуулан олгодог байна.
- ✓ Төслийн анхны тусламжийн цэгээс гарсан эмнэлгийн хог хаягдлыг Эрүүл

мэндийн сайдын 2011 оны 158 тоот “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах заавар батлах тухай” тушаалын дагуу хог хаягдал үүсэх бүрд бүртгэдэг байна.

- ✓ Эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй саванд нарны тусгалаас сэргийлэн, битүүмжлэн хадгалж, Шинэжинст сумын хүн эмнэлэгт 3.1 кг хурц үзүүртэй, иртэй хог хаягдлыг хог хаягдлыг хүлээлгэн өгсөн байна.
- ✓ Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журмыг гүйцэтгэх захирлын 06 дугаар сарын 05-ны өдрийн ЕМ 2023/0002.01 тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан байна.

### Тосоор бохирдсон арчих материал зэрэг хог хаягдал үүсээгүй.

- ✓ Барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгч “Эм-Си-Эс Проперти” ХХК нь “Хаби Ойл” ХХК-тай гэрээтэй. Барилга угсралтаар үүсэж байгаа бентонетийн савыг аюултай хог хаягдал хадгалах цэгт хадгалж байгаа бөгөөд хуульд заасан хадгалах хугацаанаас хэтрээгүй.

### Аудитын шалгуур:

Хууль тогтоомжийн хүрээнд 101 шалгуур үзүүлэлтээр Аюултай хог хаягдлын менежментийн аудитыг гүйцэтгэв. Нийт 97 шалгуурын 2 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөрт, 44 нь үндэсний хууль тогтоомж, 45 холбогдох дүрэм журам, аргачлалд, 6 нь стандарт, 4 нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөөнд тусгалаа олсон байна.

Аудитын шалгуураар тодорхойгүй болон хамааралгүй гэж үнэлэгдсэн үзүүлэлтийг хасаж, аудитын нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 14. Аюултай хог хаягдлын менежментийн нийцэл, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нэгтгэл

№	Хуулийн заалт	Хамрах хүрээ	Шалгуур үзүүлэлт	Үнэлэмж				
				Нийцэл	Сайжруулах шаардлагатай	Үл нийцэл	Тодорхойгүй	Хамааралгүй
<b>1. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ</b>								
<b>1.1. Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/</b>								
1.	21.1.	21 дүгээр зүйл. Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх	Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 8.1.9.а-д <sup>59</sup> заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна.	✓	-	-	-	-
2.	22.1.	22 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг савлах	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж хадгална.	✓	-	-	-	-
3.	22.2.		Аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй,	✓	-	-	-	-

<sup>59</sup> 8.1.9.а. Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх;

			стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байна.						
4.	23.1.1.	23 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах 23.1.Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг дараах хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно:	Сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол 180 хоног;	✓	-	-	-	-	
5.	23.1.2.		Сард 1000 килограммаас их хэмжээтэй аюултай хог хаягдал үүсгэдэг бол 90 хоног.	✓	-	-	-	-	
6.	23.2.		Тодорхой шалтгааны улмаас энэ хуулийн 23.1-д <sup>60</sup> заасан хугацаанаас илүү хугацаагаар хадгалах бол аймаг, нийслэлийн хог хаягдлын менежментийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, түр хадгалах зөвшөөрөл авна.	✓	-	-	-	-	
7.	23.3.		Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална.	✓	-	-	-	-	
8.	23.4.		Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэнэ.	✓	-	-	-	-	
9.	23.5.		Аюултай хог хаягдлыг хадгалах үед үүссэн шүүрлийг аюултай хог хаягдал гэж үзнэ.	✓	-	-	-	-	
10.	23.6.		Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг энэ хуулийн 8.1.4-т <sup>61</sup> заасан зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхэд энэ хуулийн 8.1.7.а-д <sup>62</sup> заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлнэ.	✓	-	-	-	-	
11.	23.7.		Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдал хариуцсан орон тооны болон орон тооны бус ажилтантай байна.	✓	-	-	-	-	
12.	24.1.		24 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх	Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.	✓	-	-	-	-
13.	24.2.			Аюултай хог хаягдал тээвэрлэгч аюултай хог хаягдал үүсгэгчээс тэмдэг, тэмдэглэгээтэй зориулалтын саванд савласан, хог хаягдлын дагалдах бичигтэй аюултай хог хаягдлыг гэрээний үндсэн дээр хүлээн авч тээвэрлэнэ.	✓	-	-	-	-
14.	24.3.	Аюултай хог хаягдал тээвэрлэгч хог хаягдлын дагалдах бичгийг бүрэн зөв бөглөгдсөн эсэхийг шалгаж хүлээн авна.		✓	-	-	-	-	
15.	24.4.	Аюултай хог хаягдал тээвэрлэгч хог хаягдлын дагалдах бичгийг хүлээн авагчид хог хаягдлын хамт хүлээлгэн өгнө.		✓	-	-	-	-	
16.	24.5.	Аюултай хог хаягдал тээвэрлэгч тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал болон аюултай хог хаягдлын сав баглаа боодол, тоо хэмжээний бүрэн бүтэн байдлыг хариуцна.		✓	-	-	-	-	
17.	24.6.	Аюултай хог хаягдал тээвэрлэгч аюултай хог хаягдал асгарах, алдагдах үед ашиглах багаж хэрэгсэл, материалаар тээврийн хэрэгслийг хангасан байна.		✓	-	-	-	-	
18.	24.7.	Аюултай хог хаягдал үүсгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас аюултай хог хаягдлын дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээнд үл зохицол үүсвэл аюултай хог хаягдал хүлээн авагч уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно.		✓	-	-	-	-	
19.	24.8.	Энэ хуулийн 24.7-д <sup>63</sup> заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хог хаягдлыг аюултай хог хаягдал үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг тухайн аюултай хог хаягдал үүсгэгч хариуцна.		✓	-	-	-	-	
20.	24.9.	Тээвэрлэлтийг нэгээс дээш аюултай хог хаягдал тээвэрлэгч гүйцэтгэвэл эцсийн тээвэрлэгчээс бусад тээвэрлэгчид хог хаягдлын дагалдах бичгийн		✓	-	-	-	-	

<sup>60</sup> 23.1.Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг дараах хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно:

<sup>61</sup> 8.1.4. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгох;

<sup>62</sup> 8.1.7.а. Аюултай хог хаягдлын дагалдах бичгийн;

<sup>63</sup> 24.7.Аюултай хог хаягдал үүсгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас аюултай хог хаягдлын дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээнд үл зохицол үүсвэл аюултай хог хаягдал хүлээн авагч уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно.

			хуулбарыг хадгална.					
21.	24.10.		Нийцгүй аюултай хог хаягдлыг хамт тээвэрлэхийг хориглоно.	√	-	-	-	-
22.	24.11.		Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэл, стандартад заасан анхааруулах тэмдэг байрлуулсан, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх ба аюултай хог хаягдлыг ачих, буулгах, тээвэрлэхэд энэ хуулийн 7.1.2-т <sup>64</sup> заасан журмыг мөрдөнө.	√	-	-	-	-
23.	24.12.		Аюултай хог хаягдал тээвэрлэгч нь аюултай хог хаягдал тээвэрлэдэг тээврийн хэрэгслийг цэвэрлэх, ариутгах байгууламжтай байна.	√	-	-	-	-
24.	24.13.		Тээвэрлэлтийн үед аюултай хог хаягдал асгарсан тохиолдолд аюултай хог хаягдал үүсгэгч болон тухайн орон нутгийн онцгой байдлын албанд мэдэгдэнэ.	√	-	-	-	-
25.	33.1.		Аюултай хог хаягдлыг, хадгалж байгаа аюултай хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийсэн, эсхүл доторлосон бат бөх зориулалтын саванд хадгална.	√	-	-	-	-
26.	33.2.		Аюултай шингэн хог хаягдал хадгалах савыг байрлуулах талбай нь асгарсан, алдагдсан хаягдал, хуримтлагдсан хур тунадсыг тогтоон барих хязгаарлалтын системтэй байна.	-	√	-	-	-
27.	33.3.	33 дугаар зүйл. Аюултай хог хаягдал хадгалахад тавигдах нэмэлт шаардлага	Аюултай шингэн хаягдлыг газар доор суурилуулсан саванд хадгалахыг хориглоно.	√	-	-	-	-
28.	33.4.		Аюултай хуурай хог хаягдал хадгалах савыг байрлуулах талбай нь хуримтлагдсан хур тунадсыг зайлуулах, шавхах боломжтой, сав нь хуримтлагдсан шингэнтэй хүрэлцэхгүй байхаар өргөгдсөн, эсвэл хамгаалагдсан байна.	√	-	-	-	-
29.	33.5.		Аюултай хог хаягдал хадгалах талбай нь хур тунадас, нарны шууд тусгалаас хамгаалсан дээвэртэй байна.	√	-	-	-	-
30.	33.6.		Нийцгүй хог хаягдлыг нэг саванд хадгалахыг хориглоно.	√	-	-	-	-

## 2. ДҮРЭМ, ЖУРАМ, АРГАЧЛАЛ

### 2.1. “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/428 тоот тушаал

31.	6.2.	Зургаа. Мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг	Хог хаягдлын тухай хуулийн 11.3-д <sup>65</sup> заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цахимаар болон цаасан хэлбэрээр энгийн хог хаягдлын мэдээ тайланг харьяалах сум дүүргийн Засаг дарга, аюултай хог хаягдлын мэдээ тайланг харьяалах аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.	√	-	-	-	-
32.	6.3.		Хэрэв эрх бүхий этгээд хэд хэдэн аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэр дамжин үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд тухайн аймаг, сум, дүүрэг тус бүрээр тайлангаа гаргаж харьяа сум, аймаг, дүүрэгт хүргүүлнэ.	√	-	-	-	-

### 2.2. “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам, аюултай хог хаягдлын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 116 тоот тогтоол

33.	2.1.	Хоёр. Аюултай хог хаягдлыг түр хадгалах	Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23.1-д <sup>66</sup> заасан хугацаанд эх үүсвэр дээр түр хадгална.	√	-	-	-	-
34.	2.2.1.	2.2. Аюултай хог хаягдал үүсгэгч болон өмчлөгч нь аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр	Аюултай хог хаягдлыг ангилан ялгасан байх;	√	-	-	-	-
35.	2.2.2.		Аюултай хог хаягдлыг агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсхүл ийм материалаар доторлосон байх;	√	-	-	-	-

<sup>64</sup> 7.1.2. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам батлах;

<sup>65</sup> 11.3. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлын мэдээг батлагдсан маягтын дагуу сум дүүрэгт, аюултай хог хаягдлын мэдээг аймаг, нийслэлд тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

<sup>66</sup> 23.1. Аюултай хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг дараах хугацаанд эх үүсвэр дээр түр хадгалж болно:

23.1.1. сард 1000 килограммтай тэнцүү буюу түүнээс бага аюултай хог хаягдал үүсгэдэг бол 180 хоног;

23.1.2. сард 1000 килограммаас их хэмжээтэй аюултай хог хаягдал үүсгэдэг бол 90 хоног.

36.	2.2.3.	хадгалахад Хог хаягдлын тухай хуулийн 23.3-т <sup>67</sup> зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:	Аюултай хог хаягдлыг хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн нэр, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх бөгөөд ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн байх;	✓	-	-	-	-
37.	2.2.4.		Хог хаягдлын аюулын шинж чанар болон аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулсан байх;	✓	-	-	-	-
38.	2.2.5.		Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх;	✓	-	-	-	-
39.	2.2.6.		Гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материал, хувийн хамгаалах хэрэгслийг шаардлагатай газар байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангасан байх;	-	✓	-	-	-
40.	2.2.7.а.	2.2.7. Шаардлагатай газруудад дараах мэдээллийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна:	Аюултай хог хаягдал хариуцсан ажилтны овог нэр, утасны дугаар;	✓	-	-	-	-
41.	2.2.7.б.		Гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалын байрлалыг заасан зураг, схем;	✓	-	-	-	-
42.	2.2.7.в.		Галын дуудлага өгөх утасны дугаар.	✓	-	-	-	-
43.	2.3.1.	2.3. Аюултай хог хаягдал үүсгэгч нь Хог хаягдлын тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:	Аюултай хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих;	✓	-	-	-	-
44.	2.3.2.		Үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, хоргүйжүүлэх, устгах замаар байгаль орчинд ялгарах ялгарал, бохирдуулагчийн хэмжээг бууруулах;	✓	-	-	-	-
45.	2.3.3.		Өөрийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлаа устгах тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах;	✓	-	-	-	-
46.	2.3.4.		Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаа устгах болон дахин боловсруулах боломжгүй тохиолдолд аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, экспортлох зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх;	✓	-	-	-	-
47.	2.3.5.		Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрээр боловсруулж, тэднийг сургаж, дадлагажуулах;	✓	-	-	-	-
48.	2.3.6.		Анхны тусламж үзүүлэх зааварчилгаа боловсруулж, шаардлагатай материал, хэрэгслээр хангах.	✓	-	-	-	-
49.	2.6.		Аюултай хог хаягдал үүсгэгч нь үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаар бүртгэл хөтлөх бөгөөд бүртгэлийг аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлснээр дуусгавар болгож, дахин эхлэх үед бүртгэлийг шинээр хөтөлж эхэлнэ.	✓	-	-	-	-
50.	2.7.		Үүсгэгч болон өмчлөгч нь шүүрлийн шингэн цуглуулах системд хуримтлагдсан шингэнийг хамгийн багадаа 90 хоногт 1 удаа цэвэрлэж, энэ тухай бүртгэл хөтлөх бөгөөд үүссэн хаягдлыг устгах зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлнэ.	✓	-	-	-	-
51.	2.8.		Үүсгэгч болон өмчлөгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхдээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан маягтын дагуу аюултай хог хаягдлын дагалдах бичгийг бүрдүүлж, бүртгэл хөтөлнө.	✓	-	-	-	-

<sup>67</sup> 23.3.Аюултай хог хаягдлыг агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална.

52.	2.9.		Үүсгэгч болон өмчлөгч нь энэ журмын 2.8-д <sup>68</sup> заасан дагалдах бичгийг 4 хувь үйлдэх бөгөөд өөрөө болон тээвэрлэгч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа 1 хувийг өөрт үлдээж, бусад 3 хувийг тээвэрлэгчид хог хаягдлын хамт хүлээлгэн өгнө.	✓	-	-	-	-
53.	2.10.		Тээвэрлэгч нь энэ журмын 2.9-д <sup>69</sup> заасан 3 хувь хог хаягдлын дагалдах бичгийг хог хаягдлын хамт хүлээн авагчид хүргэж, гарын үсэг зуруулж баталгаажуулан, 1 хувийг хог хаягдал хүлээн авагчид өгч, 1 хувийг тээвэрлэгч өөртөө үлдээнэ. 3 дахь хувийг үүсгэгчид эргүүлэн өгнө.	✓	-	-	-	-
54.	2.11.		Үүсгэгч нь энэ журмын 2.10-т <sup>70</sup> заасан өөрт үлдээсэн хог хаягдлын дагалдах бичгийг хүлээн авагч гарын үсэг зурж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичгийн хувийг хүлээн авах хүртэлх хугацаанд хадгална.	✓	-	-	-	-
55.	2.12.		Үүсгэгч нь энэ журмын 2.11-д <sup>71</sup> заасны дагуу гарын үсэг зурж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичиг, үүсгэсэн болон тээвэрлүүлсэн хог хаягдлын бүртгэл, тайлангийн баримт материалыг 10 жил хадгална.	✓	-	-	-	-
56.	3.1.		Тээвэрлэгч нь аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.	✓	-	-	-	-
57.	3.2.		Тээвэрлэгч нь үүсгэгч болон өмчлөгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр зориулалтын саванд савласан, "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэг, тэмдэглэгээтэй, хог хаягдлын дагалдах бичиг бүхий аюултай хог хаягдлыг үүсгэгчээс хүлээн авч тээвэрлэнэ.	✓	-	-	-	-
58.	3.3.		Тээвэрлэгч нь үүсгэгчийн огноо, гарын үсэг бүхий хог хаягдлын 3 хувь үйлдсэн дагалдах бичгийг бүрэн, үнэн зөв бөглөгдсөн эсэхийг шалгаж, гарын үсэг зурж хүлээн авна.	✓	-	-	-	-
59.	3.4.		Тээвэрлэгч нь үүсгэгчээс хүлээн авсан аюултай хог хаягдлын бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг ханган тээвэрлэж, дагалдах бичигт заасан аж ахуйн нэгжид хүлээлгэж өгнө.	✓	-	-	-	-
60.	3.5.	Гурав. Аюултай хог хаягдлыг тээвэрлэх	Тээвэрлэлт дууссаны дараа энэ журмын 2.11-д <sup>72</sup> заасны дагуу хүлээн авагчийн гарын үсэг зурж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичгийн 1 хувийг үүсгэгчид буцаан өгч, 1 хувийг өөртөө авна.	✓	-	-	-	-
61.	3.6.		Үүсгэгч болон өмчлөгчийн буруутай үйл ажиллагааны улмаас аюултай хог хаягдлын дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээтэй таарахгүй байгаа тохиолдолд хүлээн авагч уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж хог хаягдлын дагалдах бичгийг энэ журмын 2.9 <sup>73</sup> , 2.10-т <sup>74</sup> заасны дагуу шинээр бүрдүүлнэ.	✓	-	-	-	-
62.	3.7.		Хүлээн авагч хог хаягдлыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд энэ тухай бичгээр гаргасан тайлбарыг хог хаягдал болон түүний дагалдах бичгийн хамт үүсгэгчид хүлээлгэн өгнө.	✓	-	-	-	-
63.	3.8.		Хэрэв тээвэрлэлтийг нэгээс дээш тээвэрлэгч (жишээ нь: авто болон төмөр замын холимог тээвэр) гүйцэтгэж байгаа тохиолдолд тээвэрлэгч бүр гарын	✓	-	-	-	-

<sup>68</sup> 2.8. Үүсгэгч болон өмчлөгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхдээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан маягтын дагуу аюултай хог хаягдлын дагалдах бичгийг бүрдүүлж, бүртгэл хөтөлнө.

<sup>69</sup> 2.9. Үүсгэгч болон өмчлөгч нь энэ журмын 2.8-д<sup>69</sup> заасан дагалдах бичгийг 4 хувь үйлдэх бөгөөд өөрөө болон тээвэрлэгч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа 1 хувийг өөрт үлдээж, бусад 3 хувийг тээвэрлэгчид хог хаягдлын хамт хүлээлгэн өгнө.

<sup>70</sup> 2.10. Тээвэрлэгч нь энэ журмын 2.9-д<sup>70</sup> заасан 3 хувь хог хаягдлын дагалдах бичгийг хог хаягдлын хамт хүлээн авагчид хүргэж, гарын үсэг зуруулж баталгаажуулан, 1 хувийг хог хаягдал хүлээн авагчид өгч, 1 хувийг тээвэрлэгч өөртөө үлдээнэ. 3 дахь хувийг үүсгэгчид эргүүлэн өгнө.

